

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ II ТӨСӨЛ



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛЫН ОЛОН УЛСЫН ТУРШЛАГЫН ЭМХЭТГЭЛ

Улаанбаатар хот
2022


ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛЫН ОЛОН УЛСЫН ТУРШЛАГЫН ЭМХЭТГЭЛ

**Бодлого боловсруулагчид, эрдэмтэн судлаачид, багш сурган
хүмүүжүүлэгчдэд зориулсан хураангуй орчуулга**

Улаанбаатар хот
2023

ННА 74
ДАА 370
Т-441

ТӨСЛИЙН САНХҮҮЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД



ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГУУД



Энэхүү орчуулгын эмхэтгэлийг Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр “Тогтвортой хөгжлийн боловсрол-II төслийн түшиц байгууллага Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгээс хэвлүүлэв.

Эх хэлнээ хөрвүүлсэн: Э.Оюунчимэг

Ш.Нарантуяа

Эмхэтгэж, хянан тохиолдуулсан: А.Энхтогтох

Л.Уранчимэг

Д.Хишигбуян

Техник редактор: Э.Шинэцэцэг

Б.Оюунцэцэг

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Б.Сарнай

Хавтасны дизайнер: Ю.Хатанболд

Хэвлэлийн хуудас: 6.7 хх

Хэвлэлийн “Соёмбо Принтинг” ХХК-д хэвлэв.

ISBN 978 9919-9714-5-8

© Зохиогчийн зөвшөөрөлгүй хэвлэн олшруулахыг хориглоно.

ӨМНӨХ ҮГ

ЮНЕСКО-ийн “ТХБ-2030” баримт бичигт тогтвортой хөгжлийн зорилгод хүргэх дэлхий нийтийн үйлийн хүрээ, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл тус бүрээр юу хийх хэрэгтэйг зааж өгөхийн зэрэгцээ улс орнуудад хандан 2020-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа үйлийн тэргүүлэх таван чиглэлд идэвхжүүлэн хөгжүүлэхийг уриалсан. Дэлхийн улсууд дээрх баримт бичгийг баримжаалан, өөрийн орны онцлогтой уялдуулан ТХБ-ыг дэмжин хөгжүүлэх бодлого, стратегийг боловсруулан хэрэгжүүлж байна.

Монгол улс, Монголын боловсролын салбар нь ТХ, ТХБ-ын түүхэн хөгжлийн үе шат бүрд Дэлхий нийтийн шинэ санаачилга, үйл хэргийг ажил хэрэг болгож, тэдгээрийг хэрэгжүүлэхийн төлөө чармайн ажиллаж байна.

Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр ТХБ-II төслийн хүрээнд “Тогтвортой хөгжлийн зорилгын төлөөх боловсролыг суралцахуйд интеграцчилах арга зүй” -н хөтөч ном болон 3 гарын авлагаас бүрдсэн 4 багц номыг хэвлүүлж хүргэсэн билээ. Энэ удаа бид эрдэмтэн судлаачид, багш нарын хүсэлтээр бүх нийтийн тогтвортой хөгжлийн боловсролын үйл хэргийг эрчимжүүлэх, “Боловсролыг тогтвортой хөгжлийн төлөө хувирган өөрчлөх” гэсэн дэлхий нийтийн шинэ санаачилгыг бодит үйл хэрэг болгох арга замыг тодруулахад тус нэмэр болох дараах 4 номыг орчуулж хураангуйлан эмхэтгэлээ.

Тус орчуулгын эмхэтгэлд

1. ЮНЕСКО. (2022)., ESD for 2030. Berlin Declaration on Education for Sustainable Development. Эх сурвалж: <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000381229>
2. ЮНЕСКО. (2019)., Educational content up close. Эх сурвалж: <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000372327>
3. World Future Council. (2019)., Advancing education for sustainable development key Success Factors for Policy and Practice. Эх сурвалж: https://www.worldfuturecouncil.org/wp-content/uploads/2019/01/Handbook-advancing-education-for-sustainable-devolopment-by-alistair-whitby-wfc_2019.Pdf
4. OECD.(2021)., Building the future of education. Эх сурвалж: <https://www.oecd.org/education/future-of-education-brochure.pdf>

Олон улсын баримтлах бодлогын баримт бичиг, судалгааны үр дүн, хэрэгжүүлсэн улс орнуудын туршлагаас гарсан зөвлөмж, боловсролын ирээдүйн талаарх энэхүү багц орчуулгыг уншиж танилцсан бүх түвшний бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид, гадаад, дотоодын түншлэгч байгууллагууд, орон нутгийн иргэд, эцэг эх, олон нийт ТХБ-ын төлөөх багшлахуй ба суралцахуй, түүний хэрэгжих орчныг хувирган өөрчлөх талаар сургууль, багш нарын гаргаж буй бүхий л санаачилга, хүчин чармайлтыг тал бүрээр дэмжин ажиллахыг хүсэж байна.

Номын цагаан буян дэлгэрэх болтугай!

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирал, (Ph.D)
Миеэжавын Итгэл

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГ	5
ТХБ-2030. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛЫН БЕРЛИНИЙ ТУНХАГЛАЛ	7
БОЛОВСРОЛЫН АГУУЛГЫГ ОЙРООС ШИНЖЛЭХҮЙ.....	18
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ БОЛОВСРОЛЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ	48
БОЛОВСРОЛЫН ИРЭЭДҮЙГ ЦОГЦЛООХ НЬ.....	70

ТОВЧИЛСОН ҮГ

Монгол товчилсон үг

ББ	Бага боловсрол
БДБ	Бүрэн дунд боловсрол
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ДБ	Дунд боловсрол
ДИБ	Дэлхийн иргэний боловсрол
ИДС	Их дээд сургууль
МБ	Мэргэжлийн боловсрол
МБС	Мэргэжлийн боловсрол сургалт
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
СБААХ	Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ТХ	Тогтвортой хөгжил
ТХБ	Тогтвортой хөгжлийн боловсрол
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
ХОУ	Хиймэл оюун ухаан
ХБОБ	Хүрээлэн буй орчны боловсрол
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ЭЗХАХБ	Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа ба Хөгжлийн Байгууллага
ЮНЕСКО	Нэгдсэн Үндэстний Байгууллагын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага

АНГЛИ ТОВЧИЛСОН ҮГ

ALL	Adult Literacy and Life-skills Survey
CASEL	Collaborative for Academic, Social, and Emotional Learning
COP	Conference of the Parties
ECO	Economic Cooperation Organisation
IFFE d	The International Finance Facility for Education
IALS	Adult Literacy Survey
LEED	Leadership in Energy and Environmental Design
UNESCO	United Nations Educational, Scientific and Cultural Organization
OECD	Organisation for Economic Co-operation and Development
PIAAC	Programme for the International Assessment of Adult Competencies
PISA	Programme for the International Assessment of Adult Competencies
SIDS	Small Island Developing Countries
SSES	Survey of Social and Emotional skills
STEM	Science, technology, engineering, and mathematics
UNECE	United Nations Economic Commission for Europe
UNFPA	United Nations Population Fund
UNESCO-APCEIU	UNESCO Asia-Pacific Centre of Education for International Understanding
UNESCO-ASPnet	UNESCO -Associated Schools Network
UNESCO-IBE	UNESCO-International Bureau of Education
UNESCO-MGIEP	UNESCO- Mahatma Gandhi Institute of Education for Peace and Sustainable Development
VUCA	volatility, uncertainty, complexity, ambiguity



#ESDfor2030



BERLIN

→ DECLARATION ←
on

EDUCATION
**FOR SUSTAINABLE
DEVELOPMENT**

Education
2030 

ТХБ-2030
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛЫН
БЕРЛИНИЙ ТУНХАГЛАЛ

ОРШИЛ

1. “Тогтвортой хөгжлийн боловсрол”-ын олон улсын бага хурал 2021 оны 5 дугаар сарын 17-19-ний өдрүүдэд онлайн хэлбэрээр Германы Берлин хотод зохион байгуулагдлаа. Чуулганыг ХБНГУ-ын Боловсрол, Судалгааны Яамны дэмжлэгтэйгээр ЮНЕСКО зохион байгуулан ЮНЕСКО-гийн Германы Үндэсний Комисс зөвлөх түншээр хамтран оролцов. “Тогтвортой хөгжлийн боловсрол”-ын олон улсын бага хуралд оролцсон Засгийн газар, олон улсын болон төрийн, төрийн бус байгууллагууд, иргэний нийгэм, залуучууд, эрдэм шинжилгээний байгууллага, бизнесийн салбар, сургалтын байгууллагын төлөөллүүд хамтран дараах тунхаглалыг гаргажээ.
2. Дэлхий дээр тулгарч байгаа, хоорондоо хамаарал бүхий томоохон сорилтууд болох уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдлын мөхөлт, орчны бохирдол, цар тахал, хэт ядуурал ба тэгш бус байдал, хүчирхийлэл, мөргөлдөөн болон байгаль орчин, нийгэм эдийн засгийн хямрал зэрэг нь бидний амьдралд ихээхэн аюул, занал авчрах тул эдгээрийн эсрэг яаралтай арга хэмжээ авах шаардлага хүн төрөлхтний өмнө тулгарч байна. Үүнийг КОВИД–19 цар тахал улам тодорхой харуулсан ба үүний тулд хоорондоо уялдаатай, байгальд ээлтэй, шударга, эрх тэгш, энэрэнгүй, энхтайванч харилцаанд суурилсан тогтвортой хөгжлийн төлөөх өөрчлөлтийг санаачлах шаардлагатайг чуулганы оролцогчид онцоллоо.
3. Боловсрол бол хувь хүний сэтгэлгээ, ертөнцийг үзэх үзэлд эерэгээр нөлөөлдөг хүчирхэг хөшүүрэг мөн. Хөгжлийн гурвалжин гэдэг нь бидний амьдарч буй

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТУЛГУУР

Тогтвортой хөгжлийн гурван тулгуур багана нь нийгэм, байгаль орчин, эдийн засаг бөгөөд эдгээр нь өөр хоорондоо уялдаа холбоотой байдаг. Тогтвортой ирээдүйг байгуулахын тулд амьдралын чанарыг сайжруулах эрмэлзлэл зорилгодоо байгаль орчин, нийгэм, эдийн засгийн асуудлуудыг тэнцвэртэй авч үзэх нь чухал юм.

Цаашид судлах уншигчдын эрэл хайгуулыг дэмжих зорилгоор тунхаглалын бүрэн эхийг, тайлбарын хамт толилуулж байна. Тунхаглалын эх бичвэрийг эндээс олж үзнэ үү. (<https://en.unesco.org/events/ESDfor2030>).



дэлхий ертөнцөд хор хохирол учруулахуйц эдийн засгийг хөгжүүлэх бус харин энэхүү дэлхийн сайн сайхны төлөөх тогтвортой хөгжлийн гурван тулгуур багана болсон эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчны шүтэлцээг чухалчилдаг.

4. ТХЗ 4.7 дээр дэвшүүлсэн тогтвортой хөгжлийн боловсролыг хөгжүүлэх зорилт нь нь хүн бүрт тогтвортой хөгжлийг дэмжихэд шаардлагатай мэдлэг, чадвар, үнэт зүйл, хандлагыг олгоход чиглэж байгаа бөгөөд энэ нь өнөөгийн боловсролын шинэчлэлийн үндэс нь мөн. Тогтвортой хөгжлийн боловсролыг хөгжүүлснээр ТХ-ийн 17 зорилгод хүрэх гүүр нь болж өгөх юм. Энэ хүрээнд суралцагчдын шүүмжлэлт сэтгэлгээ, хамтран ажиллах, асуудал шийдвэрлэх, нарийн төвөгтэй байдал ба эрсдлийг даван туулах, гэсвэртэй байх, аливааг олон талаас нь бүтээлчээр сэтгэх чадварыг хөгжүүлэх төдийгүй улмаар “ТХЗ 4–Боловсрол 2030” баримт бичигт тодорхойлсон чанартай боловсрол эзэмших эрхийг нь ханган, иргэний үүргээ хариуцлагатай гүйцэтгэхэд нь дэмжлэг болох ёстой. ТХБ-оор дамжуулан байгаль орчноо хайрлан хүндэтгэх, хүний эрх, ардчилал, хуульд хүндэтгэлтэй хандах, ялгаварлан гадуурхахгүй байх, тэгш хүртээмжтэй байх болон жендерийн тэгш байдлыг хангах үзэл баримтлалыг хэрэгжүүлнэ. Мөн бусад орны соёлд хүндэтгэлтэй ханддаг, соёлын олон хэлбэрийг ойлгодог, энхтайван ба үл хүчирхийлэлгүй, оролцоонд суурилсан, хариуцлагатай, идэвхтэй дэлхийн иргэнийг төлөвшүүлнэ.
5. Ирэх 10 жилд улс орнууд төрийн бодлогодоо олон улсын чиг хандлагыг уялдуулах, суралцахуйн орчныг хүүхдэд ээлтэй болгон хувирган өөрчлөх, боловсролын бүх шатны хүний нөөцийг ТХБ-ын чиглэлээр чадавхжуулах, залуучуудад сурч, хөдөлмөрлөх, хөгжих өргөн боломж, эрх мэдэл олгох ба ТХБ-ыг бүх нийтээр дэмжин хөгжүүлэх ажлыг эрчимжүүлэхийн тулд “ТХБ-2030 ба замын зураглал- гэсэн баримт бичигт заагдсан үйл ажиллагааг улс орнууд хэрэгжүүлнэ.

ТХБ- 2030

2020 онд ЮНЕСКО ТХЗ-уудад хүрэхийн тулд дараагийн 10 жилд хэрэгжүүлэх Тогтвортой хөгжлийн боловсролын шинэ стратеги буюу ТХБ-2030-ыг гаргасан. Уг стратеги нь ТХБ-ыг бэхжүүлж, Тогтвортой хөгжлийн 17 зорилгод хүрэхэд хувь нэмэр оруулах замаар илүү шударга, тогтвортой дэлхийг бий болгох зорилготой.



Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл 1
Бодлогыг уялдуулах



Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл 2
Сургалтын орчныг хувирган өөрчлөх



Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл 3
Сурган хүмүүжүүлэгчдийг чадавхжуулах



Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл 4
Хүүхэд, залуучуудад боломж, эрх чөлөө олгох



Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл 5
Орон нутгийн түвшний үйл ажиллагааг хурдасгах

БИД СУРЧ БАЙГАА
ЗҮЙЛГЭЭ ӨӨРЧЛӨХ
ХЭРЭГТЭЙ

СУРГУУЛЬ НЬ
СУРАЛЦАГЧИД
АМЬДРАЛААС СУРАЛЦАЖ,
СУРСНАА АМЬДРАЛД
ХЭРЭГЖҮҮЛДЭГ ТАЛБАР
БОЛОХ

СУРАЛЦАГЧДЫН
ӨӨРЧЛӨЛТИЙГ
ДЭМЖИХИЙН ТҮЭД БАГШ
НАРТ МЭДЛЭГ, УР ЧАДВАР,
ҮНЭТ ЗҮЙЛИЙГ БИЙ
БОЛГОХ

ХҮҮХЭД ЗАЛУУЧУУД
ӨӨРЧЛӨЛТИЙГ БИЙ
БОЛГОГЧ ГЭДГИЙГ
ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ

ТОГТВОРТОЙ
ХӨГЖИЛД ХҮРТЭХ
УТГА УЧИРТАЙ
ӨӨРЧЛӨЛТ ОЛОН
НИЙТНИЙН ХҮРЭЭНД
ЯВАГДААГ

БИДНИЙ ХИЙХ ЗҮЙЛ

Бид өөрсдийн бүрэн эрх, хариуцлагынхаа хүрээнд хэрэгцээ, чадавх, байгаа нөөц бололцоо болон үндэснийхээ тэргүүлэх чиглэлийг харгалзан үзэж дараах зорилтыг дэвшүүлж байна. Үүнд:

- a. Байгаль орчны болон уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой үйл ажиллагааг сургалтын хөтөлбөрийн цөм хэсэг болгож, тогтвортой хөгжлийн тулгуур багана хоорондын уялдаа холбоог хангасан, ТХБ-ын цогц ойлголтыг дэлгэрүүлэх, ТХБ нь бүх түвшний боловсролын тогтолцооны үндэс суурь юм гэдгийг баталгаажуулах;
- b. ТХБ-ыг СӨБ-оос эхлэн мэргэжлийн боловсрол болон дээд, насан туршийн боловсрол хүртэлх бүх шатны боловсрол, албан бус болон амьдрах ухааны боловсролд интеграцчилах замаар бүх хүн насан туршдаа тогтвортой хөгжилд суралцах боломжоор хангагдах;
- c. Хувь хүн ба нийгмийн хувирган өөрчлөлтийн хэмжүүр болох танин мэдэхүй, ур чадвар, нийгэм-сэтгэл хөдлөлийн суралцахуй, тогтвортой хөгжлийн төлөөх хувь хүний дадал хэвшлийг өөрчлөх өөрчлөлтийг тусгах, эрх тэгш байдал ба хүний эрхийг хүндэтгэх, мөн түүнчлэн нийгэм, эдийн засгийн тогтолцооны түвшин дэх бүтцийн ба соёлын суурь өөрчлөлтүүд, тэдгээр өөрчлөлтийг бий болгоход шаардагдах бодлогыг дэмжих зэрэгт анхаарал хандуулан ТХБ-ыг хэрэгжүүлэх;

ТОЛГОЙ

Тогтвортой байдлын сорилт ба тэдгээрийн хоорондын нарийн төвөгтэй уялдаа холбоог ойлгож боломжит хувилбарыг эрэлхийлэх



ЗҮРХ

Тогтвортой байдлын үнэт зүйл, хандлагыг бий болгож, бусад хүн ба эх дэлхийд нигүүлсэнгүй хандах өрөвч нинжин сэтгэлийг суулгах, өөрчлөлтийг манлайлахад түлхэц өгөх



ГАР

Хувь хүн, нийгэм, улс төрийн хүрээнд тогтвортой хувирган өөрчлөлтийг хийх бодит үйл ажиллагааг хэрэгжүүлэх



- d. ТХБ-ыг нийгмийг шинэчлэн өөрчлөхөд ашиглахын тулд судалгаа ба нотолгоонд суурилсан бодлого боловсруулах, ардчилсан зарчмын дагуу шийдвэр гаргах, мэдлэг, чадварыг үнэлэхэд өгөгдөл, мэдээллийг ашиглах, хүн төрөлхтний болон дэлхий ертөнцийн сайн сайхан байдлыг хүндэтгэсэн тогтвортой, хувирган өөрчлөх эдийн засгийг дэмжих, дэлхийн ирээдүйн хямралд уян хатан, тэвчээртэй, бэлтгэлтэй байх байдлыг нэмэгдүүлэх;

**БАЙГУУЛЛАГА
БҮХЛЭЭРЭЭ АЖИЛЛАХ
АРГА ХАНДЛАГА**

Суралцагчид амьдралаас суралцаж, сурсан зүйлээ амьдралдаа ашигладаг орчин бидэнд хэрэгтэй байна. Энэхүү өөрчлөлтийг хийхийн тулд боловсролын байгууллагууд тогтвортой хөгжлийн зарчмуудыг зөвхөн суралцахуй болон арга зүйн үйл ажиллагаандаа нэвтрүүлээд зогсохгүй удирдлагын шийдвэр гаргах түвшиндээ хэрэгжүүлэх шаардлагатай.

- e. Суралцагчид тогтвортой хөгжлийн үйл явцад ардчилсан зарчмын дагуу оролцох, сургуулийн орчинд иргэний идэвхтэй үйл ажиллагаа явуулах, эрх тэгш байдал ба жендерийн тэгш байдлыг дэмжих, эрүүл мэнд, байгалиа хамгаалах, хүндэтгэлтэй хандах, эрчим хүчээ хэмнэх зэргээр сургуулийн орчныг тогтвортой хэрэглээний лаборатори болгосноор байгууллага бүхлээрээ ажиллах арга хандлага төлөвших юм. Сургалтыг туршилт хийх талбар, үйлд чиглүүлж орон нутаг ба соёлын онцлогтоо суурилсан, амьдралаас суралцаж, сурснаа амьдралд хэрэглэх боломжийг олгодог болгох;
- f. Жижиг арлуудын хөгжиж буй орнууд (Small Island Developing Countries (SIDC)) уур амьсгалын өөрчлөлт болон байгалийн гамшигт өртөх нь илүү нэмэгдэж байгаа учраас ТХБ-ыг хэрэгжүүлэхдээ уур амьсгалын өөрчлөлтийг тэргүүлэх чиглэл болгох;
- g. ТХБ-ыг дэлгэрүүлэхэд багш нар шийдвэрлэх үүрэгтэйг ухаарч, бүх түвшний багшлах боловсон хүчин, боловсролын салбарын ажилтнуудын чадавхыг бэхжүүлэхэд хөрөнгө оруулж, боловсролын хувирган өөрчлөлтөд салбар бүхлээрээ ажиллах арга хандлагыг хэрэгжүүлэх;
- h. Шинэ, дижитал, “ногоон” технологийн боломжийг ашиглах. Түүнийг ашиглах, хөгжүүлэх үйл ажиллагааг хариуцлагатай, аюулгүй, хүртээмжтэй, тэгш хамарсан байдлаар зохион байгуулж, шүүмжлэлтэй сэтгэлгээ, эрсдэл даах чадвар, технологийг эзэмших, хөгжүүлэх ашиглах баталгаа бий болгох, түүнчлэн боловсролын нээлттэй эх сурвалж, нээлттэй шинжлэх ухаан, ТХБ-ын И-суралцахуйн хэрэгслүүдийг дэмжиж дэлгэрүүлэх;

НОГООН ТЕХНОЛОГИ

Ногоон технологи, боловсролын талаарх илүү дэлгэрэнгүй мэдээллийг доорх баримт бичгээс аваарай.

Ур чадварын хөгжил ба уур амьсгалын өөрчлөлтийн үеийн арга хэмжээний төлөвлөгөө: МБС-ын байгууллагын хувь нэмэр

Техникийн болоод мэргэжлийн боловсролд ногоон технологийг нэвтрүүлэх: гарын авлага



i. Залуучуудыг тогтвортой хөгжлийн өөрчлөлтийг бий болгогч болоход нь дэмжлэг үзүүлэх. Мөн суралцахуй болон иргэний үйл ажиллагаанд оролцох боломжийг дэмжих, хувь хүн ба нийгмийн өөрчлөлтийг хамтран бий болгохын тулд ТХБ-ын үйл ажиллагаанд оролцох чадамж, арга хэрэгслээр хангах;

j. Тухайн улс орны онцлогт тохирсон ТХБ-ын бодлогыг дэмжих замаар хөгжлийн бэрхшээлтэй иргэд, мөргөлдөөн, хямрал, байгалийн гамшигт өртсөн хүмүүс, дүрвэгчид зэрэг зорилтот бүлгийн хүн амд анхаарал хандуулж тэргүүлэх ач холбогдол бүхий ТХБ-ийн зорилтуудыг яаралтай тусламжийн боловсролд тусгах;


k. Мэдлэг, ур чадвар эзэмшихэд жендэрийн тэгш байдал, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, тогтвортой байдлын сорилт, боломжит шийдлүүдийг бий болгохуйцаар ТХБ-ын хөгжлийг жендэрийн эрх тэгш байдалтай уялдуулах;

l. Ядуурал болон хэт ядууралтай тэмцэхэд ТХБ-ыг хэрэглэх. Суралцагчдад хувь хүний болон нийгмийн хэрэгцээнд нийцсэн чадамжийг мэргэжлийн боловсролын сургалт болон тогтвортой амьдрахад шаардлагатай ур чадварыг хөгжүүлэх замаар олгох;

m. Засаглалын бүх түвшинд ТХБ-ын асуудлаар салбар дундын болон шинжлэх ухааны салбар хоорондын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, Боловсролын Яам тогтвортой хөгжлийн чиглэлээр бусад яамтай хамтран ажиллах, гол цөм нь Боловсролын яам болон Байгаль орчны яам, төрийн бус байгууллагууд, эрдэм шинжилгээний байгууллага, бизнесийнхэн, залуучууд бусад холбогдох оролцогч талуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх;

ЗАЛУУЧУУД БА ТЭДНИЙ ҮҮРЭГ РОЛЬ

Залуучууд бол зөвхөн ирээдүй биш одоо үе, тэд өөрсдийн ирээдүйг тодорхойлох, тогтвортой байдлын хүндрэл сорилтуудад шинэ шийдэл гаргах, дэлхийн удирдагчдаас амлалт, хариуцлага нэхэх зэрэгт идэвхтэй оролцож байна. Илүү тогтвортой дэлхий ертөнцөд хувь нэмэр оруулахад залуучуудыг чадавхжуулах, боломж олгох нь ТХБ-ын хэрэгжилтийн нэг гол хэсэг юм.



- n. Боловсрол, байгаль орчин, уур амьсгал, тогтвортой эдийн засаг болон хөгжлийн бусад асуудлын уялдаа холбоог дэлхий дахин, бүс нутаг, үндэсний түвшинд дэмжих, ТХБ-ыг системийн хүрээнд хэрэгжүүлэхэд янз бүрийн оролцогч талууд харилцан бие биеийгээ дэмжих, нөхөх, харилцаа холбоог сайжруулах;
- o. КОВИД-19 цар тахлын үед болон түүний дараа ТХБ-д оруулах дотоодын болон олон улсын санхүүжилтийг бууруулахгүйн тулд хангалттай нөөцийг хуваарилах, мөн нийгмийг илүү шударга, тогтвортой болгодог боловсролын хүчийг бэхжүүлэхийн тулд хөгжиж буй орнуудын чанартай боловсролыг дэмжих, залуучуудыг чадавхжуулахад олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны гүйцэтгэж буй үүргийг тодруулах;
- p. ТХБ хэрэгжилт нь тасралтгүй сайжирч байгааг нотлох, хэн ч үлдэж хоцроогүйг батлахад чиглэсэн үнэлгээний тогтолцоог нэвтрүүлэх, ТХБ-ын ахицыг хэрхэн үнэлэх талаарх судалгааг нэмэгдүүлэх зэрэг зорилгоор ТХЗ, ялангуяа Зорилго 4.7-ын ерөнхий мониторингийн хүрээнд ТХЗ-ын дэвшлийг хянах;



ЦААШИД

6. Бид НҮБ-ын Боловсролын байгууллага болох ЮНЕСКО-г гишүүн орнуудтайгаа хамтран харьяа байгууллага, сүлжээгээ ([UNITWIN/UNESCO Chairs](#), [UNESCO Associated Schools](#), [UNESCO designated sites](#)) ашиглан энэхүү тунхаглалыг хэрэгжүүлэхэд манлайлах, хэрэгжилтийн явцыг хянахад манлайлан оролцохыг урьж байна.
7. Бид энэхүү тунхаглал болон түүний заалтуудыг [дэлхий, бүс нутаг, үндэсний болон орон нутгийн холбогдох үйл явцаар](#) дамжуулан хэрэгжүүлнэ. Биднийг 2021 онд болох [НҮБ-ын Биологийн олон янз байдлын бага хурал \(COP 15\)](#) болон 2021 онд болох [НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн бага хурал \(COP 26\)](#) зэрэг чухал арга хэмжээ, үйл явц хүлээж байна.
8. Бидний үе болон ирээдүй хойч үеийнхэн тэсч үлдэхийн тулд хүмүүс болон гариг ертөнцийн хувьд суралцахуйг хувирган өөрчлөх явдал зайлшгүй болоод байна.

Бид гариг ертөнцийнхөө төлөө суралцах, үйл хэрэг хийх цаг нь яг одоо тулж ирээд байна.

ОЛОН НИЙТТЭЙ ХАРЬЦАХ



Нийгмийг өөрчлөх боловсролд уриалахын тулд ЮНЕСКО-ийн үйл хэрэгт нэгдээрэй. Та [UNESCO's Education for Sustainable Development \(ЮНЕСКО-ийн ТХБ\) LinkedIn Group](#)-тэй холбогдож, нийгмийн сүлжээнд [#ESDfor2030](#) ба [#Learn ForOurPLanet](#) хаштаг-ийг ашиглан ТХБ-ын сүлжээтэй холбогдон харилцах боломжтой.



СУРАЛЦ

Ажиллах
цаг бол
одоо /
Одоо бол
ажиллах
цаг

О
Д
О
О

АЖИЛЛА



БЕРЛИНИЙ ТУНХАГЛАЛ

Тогтвортой хөгжлийн боловсролын ЮНЕСКО-ийн олон улсын бага хурал 2021



БОЛОВСРОЛ
ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Бохирдол



Уур амьсгалын өөрчлөлт



СОРИЛТУУД

Шинэ Сэтгэлг

КОВИД



Биологийн олон янз байдлын мөхөл

Одоогийн байдал



Насан Туршийн Боловсрол

БИДНИЙ АМГ

Салбар хоорондын **ХАМТЫН АЖИЛЛАГАА**

Хувийн хэвшил



Олон оролцогчдын үйл ажиллагаа



Төрийн бус байгууллага-ТББ

Ногоон Технологи



Шинжлэх ухаан



БОЛОВСРОЛ



БАЙГАЛЬ ОРЧИН

Дэлхийн Зөвлөгөө

Сэтгэлгээ


Ертөнцийг үзэх

үзлийн эерэг

ӨӨРЧЛӨЛТ

БОЛОВСРОЛ БОЛ

Хүчтэй зэвсэг мөн



Багш
→ шийдвэрлэх үүрэг
ГҮЙЦЭТГЭНЭ

ТХБ

бол суурь

ЭЛЕМЕНТ

ТХБ

бол

→ сургалтын
хөтөлбөрийн

ЦӨМ ХЭСЭГ

Балгуумага бүхлээрээ ажиллах
АРГА ХАНАЛАГА



Агуулга
→ Арга зүй
→ Сургалтын орчин

2030 ОНЫ ТХБ

Манай гаригийн төлөө суралцах

a Visual by ANJARIESE.COM

Нийгмийг

ӨӨРЧЛӨХӨД ТХБ-ЫН



Хүчийг
Ашиглах

Ажиллах цаг бол одоо / Одоо бол ажиллах цаг

СУРАЛЦ

ОДОО

АЖИЛЛА



unesco.org/esd



United Nations
Educational, Scientific and
Cultural Organization

Educational content up close

Examining the learning dimensions of Education for

Sustainable Development and Global Citizenship Education



БОЛОВСРОЛЫН АГУУЛГЫГ ОЙРООС ШИНЖЛЭХҮЙ

1. ХУРААНГУЙ

АГУУЛГА

Тогтвортой Хөгжлийн Боловсрол (ТХБ) болон Дэлхийн Иргэний Боловсрол (ДИБ) нь Тогтвортой хөгжил 2030, ялангуяа ТХ-ийн зорилго 4-ийн нэг хэсэг юм. ТХ-ийн зорилго 4.7-д тогтвортой амьдралын хэв маяг, хүний эрх, жендэрийн эрх тэгш байдал, энх тайван ба үл хүчирхийллийг дэмжих, дэлхийн иргэншил болон соёлын

олон янз байдлыг хүлээн зөвшөөрөх, хүндлэх талаар тусгасан байдаг.

ТХБ, ДИБ-ыг эзэмшүүлж, суралцахуйн мөн чанарыг хувирган өөрчилж чадах үнэ цэнд суурилсан, цогц арга хандлагыг төлөвшүүлэхэд танин мэдэхүйн, нийгэм-сэтгэл хөдлөлийн болон зан үйлийн гурван айг зайлшгүй харгалзан үзэх шаардлагатай.

ДЭВШҮҮЛСЭН АСУУЛТ

Улс орнууд сургуулийн өмнөх, бага, дунд болон бүрэн дунд боловсролын түвшинд ТХБ, ДИБ-ыг эзэмшүүлэхдээ суралцахуйн дээрх гурван айг эн тэргүүнд тавьж хэрэгжүүлдэг эсэх, хэрэгжүүлдэг тохиолдолд хэдий хэмжээгээр хэрэгжүүлдэг болохыг судалж, судалгааны гол үр дүн, дүгнэлтийг авч үзсэн болно. Ингэхдээ ЮНЕСКО-ийн таван өөр бүсэд байрлах гишүүн орнуудаас сонгон судалгаанд хамруулсан нь Коста Рика, Япон, Кени, Ливан, Мексик, Марокко, Португал, БНСУ, Ливан болон Швед улс юм. Эдгээр улс орнууд боловсролын дөрвөн түвшинд суралцахуйн гурван айг хэрхэн тусгаж, хэрэгжүүлж байгааг судалж, ТХБ, ДИБ-ыг эзэмшүүлэхдээ суралцахуйн ай бүрд хэр их төвлөрч, ач холбогдол өгч байгааг илрүүлэхийг зорилоо.

Үүний тулд тухайн улсын албан боловсролын салбарт сургуулийн өмнөх боловсрол, бага боловсрол, дунд боловсрол болон бүрэн дунд боловсролын түвшинд хүчин төгөлдөр үйлчилж буй хууль журам, бодлого, сургалтын хөтөлбөрт шинжилгээ хийсэн бөгөөд мэргэжлийн боловсрол, насанд хүрэгчдийн болон албан бус боловсролын салбарыг хамруулаагүй болно. Энэхүү судалгааны хүрээнд судлагдахууны сургалтын хөтөлбөрт шинжилгээ хийсэн ба харин түүний хэрэгжилт (анги танхимд хэрхэн зааж буй), сурах бичиг, сурлагын амжилт зэрэгт шинжилгээ хийгээгүйг тэмдэглэх нь зүйтэй. Судалгаанд ашигласан эх сурвалж нь олон нийтэд хүртээмжтэй тавигдсан баримт бичиг, материал болно.

ДЭВШҮҮЛЖ БУЙ ТААМАГЛАЛ

Судалгааны хүрээнд дараах таамаглалыг дэвшүүлж байна.

- ТХБ, ДИБ-ыг үр дүнтэй эзэмшүүлэхэд суралцахуйн гурван айг бүгдийг нь харилцан уялдаатай хөгжүүлэх шаардлагатай.

- **Танин мэдэхүйн ай:** Дэлхий дахин, бүс нутаг, үндэсний болон орон нутгийн асуудлын талаар мэдлэг эзэмших, олон улс үндэстэн, хүн амын харилцан хамаарал, уялдаа холбоог ойлгох, тогтвортой хөгжлийн тухайд нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчны хүчин зүйлсийн талаар мэдлэг эзэмших, ойлгох, шүүмжлэлтэй хандах;
- **Нийгэм-сэтгэл хөдлөлийн ай:** Хүн төрөлхтний нэг хэсэг гэдгээ ойлгох, үнэ цэн, үүрэг хариуцлагыг хамтран үүрэхийг ухамсарлах, ялгаатай байдал, олон янз байдлыг ойлгох, хүндлэх, эв нэгдэлтэй байх, тэдний оронд өөрийгөө тавьж үздэг байх, ирээдүйн төлөө үүрэг хүлээхийг ухамсарлах;
- **Зан үйлийн ай:** Энх тайван, тогтвортой нийгмийг цогцлоохын төлөө орон нутгийн, үндэсний болон дэлхий дахины хэмжээнд хариуцлагатай, үр дүнтэй үйлдэл хийх, арга хэмжээ авах;
- ТХБ, ДИБ-ыг эзэмшүүлэхэд суралцахуйн гурван айг боловсролын түвшин (босоо байдлаар), тухайн түвшний холбогдох судлагдахуун бүр (хэвтээ байдлаар)-д тусгаж, ач холбогдол өгөх нь зүйтэй. Гэхдээ энэ нь бүхий л улс орон, боловсролын түвшин болон судлагдахуун бүрд суралцахуйн айг нэг ижил түвшинд тусгаж, нэг арга барилаар хандах хэрэгтэй гэсэн үг биш юм. Гэвч ТХБ, ДИБ-ыг эзэмшүүлэх арга барил нь тэнцвэртэй бус, жишээ нь танин мэдэхүйн айд хэт төвлөрөх, эсхүл суралцахуйн гурван айг боловсролын зөвхөн нэг түвшинд тусгаж хэрэгжүүлбэл эцсийн үр дүндээ суралцагч өдөр тутмын амьдралдаа өөрчлөлт хийх нь бага, тэгш хүртээмж, шударга, энх тайван, тогтвортой нийгмийг бий болгох идэвх, оролцоо бага байх магадлалтай юм.
- ТХБ, ДИБ-ыг эзэмшүүлэх суралцахуйн зорилтыг боловсруулж, бодлого, сургалтын хөтөлбөрөөр баталгаажуулж өгөх тутамд сургалтын амжилтыг тэр хэмжээгээр сайжруулж чадна гэж үзэж байна. Анх боловсруулсан сургалтын хөтөлбөрийн хэмжээнд судлагдахууныг бүрэн эзэмшүүлж чадаагүй байгаа тохиолдолд ч тухайн суралцахуйн зорилтыг боловсруулж, тодорхойлж өгснөөр ТХБ, ДИБ-ын сэдвүүдийг дэмжсэн орчныг бүрдүүлж өгч байна хэмээн үзэж болно.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

- Судалгаанд хамрагдсан улс орнууд боловсролын дөрвөн түвшинд суралцахуйн гурван айг тусгасан байдалд тодорхой зүй тогтол ажиглагдаж байна.
- Сургуулийн өмнөх боловсролоос бүрэн дунд боловсролын түвшинд ахих тусам нийгэм-сэтгэл хөдлөлийн айд төвлөрөх нь багасч танин мэдэхүйн айд төвлөрсөн

байдал ихэсч байна. Бусад хоёр суралцахуйн айтай харьцуулахад зан үйлийн айг бага тусгасан хэдий ч боловсролын түвшин бүрд тодорхой хэмжээгээр тусгагдсан байна.

- **Улс орноосоо шалтгаалж ялгаатай байна.** Швед, Мексик, Коста Рика гэх мэт улсууд ТХБ, ДИБ-ыг эзэмшүүлэхдээ суралцахуйн танин мэдэхүйн айд илүү төвлөрч байхад Кени, Ливан, Марокко, БНСУ зэрэг улс нийгэм-сэтгэл хөдлөлийн айд илүү төвлөрсөн байна.
- **Боловсролын дөрвөн түвшинд суралцахуйн гурван айд жигд төвлөрсөн улс орон байхгүй байна.** Боловсролын 2-3 түвшиндээ суралцахуйн гурван айг харьцангуй жигд тусгасан хэд хэдэн улс орон ажиглагдсан. Зарим улс, эсхүл боловсролын түвшинд ТХБ, ДИБ-ыг эзэмшүүлэхдээ аль нэг суралцахуйн айг маш бага хэмжээнд тусгасан тохиолдол нэлээдгүй байгаа бөгөөд энэ нь ихэнхдээ зан үйлийн ай, дунд боловсролын түвшинд байна.
- **Бусад баримт бичигтэй харьцуулахад боловсролын хууль тогтоомжид ТХБ, ДИБ-ыг эзэмшүүлэхэд нийгэм-сэтгэл хөдлөлийн айд төвлөрөх тухай илүү тусгасан байна.** ТХБ, ДИБ-той холбоотой сэдвээр нь харьцуулж үзвэл бараг бүх төрлийн баримт бичигт ДИБ-той холбоотой сэдэв ТХБ-той холбоотой сэдвээс ойролцоогоор хоёр дахин илүү илэрцтэй байлаа.
- **Нийгмийн ухаан болон байгалийн шинжлэх ухааны судлагдахуунууд танин мэдэхүйн айд илүү төвлөрч байна.** Боловсролын бүх түвшинд хэл болон шинжлэх ухааны судлагдахуунууд нийгэм-сэтгэл хөдлөлийн айд бага төвлөрч байгаа бол сургуулийн өмнөх болон бага боловсролын түвшинд нийгэм-сэтгэл хөдлөлийн айд илүү төвлөрч байгаа нь ажиглагдлаа.
- Баримт бичгийн бүхий л төрлүүдэд **ДИБ-той холбоотой агуулгыг эзэмшүүлэхдээ танин мэдэхүйн айгаас нийгэм-сэтгэл хөдлөлийн айд илүү төвлөрч**, зан үйлийн ай бага тусгагдсан ажиглагдаж байна. **ТХБ-той холбоотой агуулгыг эзэмшүүлэхэд зан үйлийн айгаас танин мэдэхүйн айд илүү төвлөрч нийгэм-сэтгэл хөдлөлийн айд бага төвлөрсөн байна.**
- Цаг хугацааны хувьд гурван үеэр хувааж судалсан: (i) 2006 оноос өмнөх үе, (ii) 2006-2014 болон (iii) 2015 оноос өнөө үе. Эдгээр цаг үед ТХБ, ДИБ-д харьцангуй жигд анхаарч иржээ. Харин суралцахуйн гурван айн хувьд 2015 оноос хойш гарсан баримт бичигт илүү дэлгэрэнгүй тусгагдсан байна.

ДҮГНЭЛТ

Судалгааны үр дүнд дараах дүгнэлт хийх боломжтой байна. Үүнд:

1. **Зүй тогтлын хувь ялгаатай байна.** Судалгаанаас үзэхэд суралцахуйн ай бүрд (танин мэдэхүйн, нийгэм-сэтгэл хөдлөлийн, зан үйлийн) харьцангуй ялгаатай анхаарал төвлөрүүлж буй байдал нь улс орнууд, боловсролын аль түвшинд гэдгээс хамаараад ялгаатай байгаа ба тухайн боловсролын тогтолцоо, суралцагчдын хэрэгцээ шаардлагаас шалтгаалж байна.
2. **Суралцахуйн цогц хандлага чухал хэвээр байна.** Суралцахуйн гурван айд ялгаатай хэмжээгээр анхаарч, төвлөрч байгаа ба илүү цогц байдлаар хандаж, эерэг үр дүнд хүрэхийн тулд нийгэм-сэтгэл хөдлөлийн болон зан үйлийн айд илүү анхаарал хандуулах шаардлагатай болохыг энэхүү судалгаа харуулж байна.
3. **Судлагдахуунаас хамаарч ялгаатай байна.** ТХБ, ДИБ-ыг тусган, зааж эзэмшүүлж буй тухайн судлагдахуунаас хамаарч суралцахуйн гурван айд их бага, ялгаатай төвлөрсөн байна. Тиймээс боловсролын харилцаанд оролцогчид, шийдвэр гаргагчид ТХБ, ДИБ-той холбогдох сэдвүүдийг агуулсан тухайн судлагдахуунд мөн анхаарах хэрэгтэй болж байна. Ингэснээр суралцахуйн гурван ай бүрд жигд төвлөрч, ТХБ, ДИБ-ыг эзэмшүүлж чадна.
4. **Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага.** ТХБ, ДИБ-ыг эзэмшүүлэхэд СБААХ-ыг хэрэгжүүлэхийг ЮНЕСКО-оос зөвлөдөг. Ингэснээр зөвхөн тодорхой сургалтын хөтөлбөр, заах арга барилаар дамжуулж ТХБ, ДИБ-ыг хүргэх бус, харин сургуулийн биет, материаллаг, хөдөлгөөнт орчинд, олон нийтийн үйл хэрэгт оролцож, боловсролын харилцаанд оролцогч бүхий л талууд, боловсролын тогтолцоо, тэргүүлэх засаглал, байгууллагуудаар дамжуулж ТХБ, ДИБ-ыг эзэмшүүлэхийг зөвлөж байна.
5. **Цаашид хийгдэх судалгаа.** Энэхүү судалгаагаар боловсролын бодлогын баримт бичгүүд болон сургалтын хөтөлбөрийн хүрээнд шинжилгээ хийсэн. Суралцахуйн гурван айг хэрхэн эзэмшүүлж байгаа, үр дүн нь ямар байгааг илрүүлэх үүднээс цаашид сургуулийн орчин болоод анги танхимд хэрхэн зааж, эзэмшүүлж байгаа талаар судалгаа хийх нь зүйтэй.

ТАЙЛБАР

Энэхүү судалгаанд хэрэглэгдсэн зураг, графикийг ЮНЕСКО боловсруулсан болно. Судалгааг ЮНЕСКО-ийн захиалгаар хийсэн ба судалгаанд хэрэглэсэн мэдээлэл, тоо баримтыг тухайн улс орны олон нийтэд нээлттэй тавьсан баримт бичиг, материалаас авсан. Энэхүү мэдээлэл, тоо баримт нь тухайн улс орны албан ёсны бодлого, төлөвлөгөөг бүрэн цогцоор нь тусгаагүй байж болно

2. СУУРЬ АСУУДЛУУД

ТХБ БОЛОН ДИБ

Улс орнууд тогтвортой хөгжлийн зорилго 4.7-г хэрэгжүүлэхэд ЮНЕСКО дэмжиж ажилладаг. ТХБ болон ДИБ-ыг ЮНЕСКО дараах байдлаар тодорхойлдог ба эдгээр ойлголтын харилцан уялдаа болон давхцлыг мөн хүлээн зөвшөөрдөг.

- *Тогтвортой Хөгжлийн Боловсрол (ТХБ)* нь хүн бүр соёлын олон янз байдлыг хүндэтгэхийн зэрэгцээ одоо үе болон ирээдүй үеийн төлөө хүрээлэн буй орчноо хэвээр үлдээж, хүчирхэг эдийн засаг, шударга нийгмийг цогцлоохын төлөө мэдлэгт суурилсан шийдвэр гаргах боломжийг бүрдүүлнэ (UNESCO 2014, ху. 20).
- *Дэлхийн Иргэний Боловсрол (ДИБ)* нь бүх насны суралцагч орон нутагтаа болон дэлхийн хэмжээнд

илүү энх тайван, хүлээцтэй, тэгш хүртээмжтэй, аюулгүй нийгмийг бүрдүүлэхэд идэвхтэй үүрэг гүйцэтгэх боломжийг бүрдүүлнэ (UNESCO 2015, ху.14). ДИБ нь нийт хүн төрөлхтөн, илүү өргөн олон нийтэд харьяалагдаж, тэдний нэг гэсэн мэдрэмжийг төрүүлэхийг зорьдог бөгөөд дэлхий нийт, улс орон болоод орон нутгийн улс төр, эдийн засаг, нийгэм соёлын харилцан хамаарал, уялдаатай байдлыг анхаарч үздэг (UNESCO 2015, ху.14).

ТХЗ 4.7

НҮБ-аас хэрэгжүүлсэн ТХБ-ын 10 жилийн (2005-2014) хугацаанд ихэнх улс орон ТХБ-ын үйлийн хүрээг боловсруулж, үндэсний хэмжээндээ хэрэгжүүлж эхэлжээ. Хүрээлэн буй орчны тогтвортой байдал, амьдралын тогтвортой хэв маяг, тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэл, болон хүн төрөлхтний амьд үлдэж, оршин тогтнохтой холбоотой сэдвүүд ТХБ-д тусгагдсан нь зүйн хэрэг юм. ТХБ-д “ДИБ-той холбоотой” сэдвүүд мөн багтсан бөгөөд хүрээлэн буй орчин, нийгэм болон эдийн засгийн асуудлуудыг харилцан хамааралд нь авч үздэг.

ДИБ-ыг 2012 онд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын “Боловсрол Нэгдүгээрт” санаачилга (Global

Education First Initiative - GEFI) -д анх танилцуулсан хэдий ч үндсэн ойлголтууд болох энх тайвны боловсрол, хүний эрхийн боловсролын тухай ДИБ-ыг гаргаж тавихаас өмнө олон улс орон дэмжин хэрэгжүүлж ирсэн билээ. Зарим улс орон эдгээр үзэл санааг ТХБ-д тусган хэрэгжүүлж байна. ТХБ-ын үзэл санааг ч ДИБ-д тусган хэрэгжүүлж болох ба адил төстэй зүйлс олон байгааг үүнээс харж болно.

Энэхүү судалгааны хүрээнд ТХБ болон ДИБ-ыг ялгаатай авч үзсэн болохыг онцлох нь зүйтэй юм. Ингэхдээ тэдгээрийн харилцан хамаарал, сэдвийн давхцлыг бүрэн хүлээн зөвшөөрч, харгалзан үзсэн болно.

ТХБ болон ДИБ-ыг 2015 оноос эхлэн ТХ-ийн зорилго 4.7-д тусгасан.



2030 он гэхэд тогтвортой хөгжлийн мэдлэг, тогтвортой амьдралын хэв маяг, хүний эрх, жендэрийн тэгш байдал, энх тайван болон хүчирхийлэл үл хэрэглэх соёлыг төлөвшүүлэх, дэлхийн иргэн байх, соёлын олон янз байдал болон тогтвортой хөгжилд соёлын оруулж буй хувь нэмрийг ойлгуулах мэдүүлэх замаар тогтвортой хөгжлийг хөхиүлэн дэмжихэд шаардлагатай мэдлэг, ур чадварыг бүх суралцагчдад олгох (НҮБ, 2015).

Улс орон бүр ТХ-ийн зорилго 4.7-д хүрэхээр авч буй арга хэмжээнийхээ талаар сайн дурын үндэсний тайландаа тусган шалгуур үзүүлэлтүүдийг тайлагнаж байх үүрэг хүлээдэг.¹ ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн дагуу “ТХБ, ДИБ, жендэрийн тэгш байдал болон хүний эрхийн асуудлыг боловсролын бүх шатны (а) үндэсний боловсролын бодлого, (б) сургалтын хөтөлбөр, (в) багшийн боловсрол, (г) суралцагчийн үнэлгээнд нэвтрүүлэн хэрэгжүүлсэн эсэхийг илрүүлэхэд төвлөрнө (НҮБ, Статистикийн алба, 2019).

Энэхүү судалгаанд ТХБ болон ДИБ-ын аль нэгтэй нь, эсхүл аль алинтай

¹ 1974 оны “Олон улсын ойлголцол, хамтын ажиллагаа, энх тайвны төлөөх боловсрол болон хүний эрх, үндсэн эрх чөлөөтэй холбоотой боловсролын тухай” зөвлөмжид тусгагдсаны дагуу гишүүн орнууд 4 жил тутамд тайлан ирүүлдэг бөгөөд ЮНЕСКО энэхүү үйл явцыг ашиглан 4.7.1 дугаар зорилтын шалгуур үзүүлэлтийн мэдээллийг мөн цуглуулж авдаг. Дэлхийн хэмжээнд шалгуур үзүүлэлтийг хэрхэн тооцох арга зүйг загварчлан боловсруулсан бөгөөд ТХЗ-ын шалгуур үзүүлэлтээр мэргэшсэн экспертийн баг, агентууд хянаж, эцэслэдэг.

нь холбогдож болох хэд хэдэн сэдвийг мөн хөндсөн ба шинжилгээ хийх явцад зарим сэдэв нь ДИБ-той илүү холбогдож, зарим нь ТХБ-той илүү холбогдож байна. Дэлхийн хяналт шинжилгээний үйл явцад эдгээр хоёр сэдвийг харилцан уялдаанд нь, хамтад нь авч үзэж байгаа тул зарим дүгнэлтэд энэ хоёр сэдвийг хамтад нь авч үзсэн болно.

СУРАЛЦАХУЙН ГУРВАН АЙ

ТХБ болон ДИБ-ыг танин мэдэхүйн, нийгэм-сэтгэл хөдлөлийн болон зан үйлийн гэсэн суралцахуйн гурван айгаар дамжуулан гүнзгий ойлгох боломжтой (UNESCO 2015, 2017; Battiste 2000; Brookings Institution, 2017; UNESCO-APCEIU 2015). Гурван хэсгээс бүрдэх энэхүү хьюристик (heuristic) хандлага нь Делорсын “Боловсрол: Түүнд нуугдсан эрдэнэс” тайланд дурдагдсан суралцахуйн дөрвөн тулгуур зарчим “мэдэхийн төлөө, бүтээхийн төлөө, оршин байхын төлөө болон хамтдаа нийгэмшин амьдрахын төлөө суралцах”-тай нийцэж буй бөгөөд суралцахуйн олон төрлийг үл алагчлан, илүү холистик, цогц байдлаар хандахад чиглүүлнэ. Хүрээлэн буй орчин, соёл болон нийгмийн эрх тэгш байдал, шударга байдлын тулгамдаад байгаа асуудлыг ойлгон, хүндэтгэлтэй хандаж, мэдлэг, ойлголтыг илүү гүнзгий түвшинд эзэмшүүлэхийг зорьдог.

Хэдийгээр салангид гурван айд хуваасан боловч суралцахуйг холистик, цогц хэмээн үзэж, хьюристик хандлагаар авч үзвэл энэхүү гурван ай нь хоорондоо давхцах ба нягт уялдаатай байна.

- Танин мэдэхүйн айд дэлхий дахин, түүний ээдрээг асуудлуудыг илүү сайн ойлгоход нь шаардлагатай мэдлэг, шүүмжлэлт сэтгэлгээ багтана.
- Нийгэм-сэтгэл хөдлөлийн айд олон янз байдалт, даяаршсан энэхүү нийгэмд харилцаа холбоо үүсгэх, хамтран ажиллах, хэлэлцэн тохиролцох, бүтээн босгох болон 21-р зуунд ажиллаж амьдрахад тулгарч болох бэрхшээлийг даван туулахад шаардлагатай чадвар, хандлага, үнэ цэн багтана. Бусадтайгаа эн зэрэгцэн, энх тайванч, хүндэтгэлтэй хандан, сэтгэл хангалуун, үр бүтээлтэй амьдрахад нь шаардлагатай өөрийгөө таньж, эргэцүүлэх чадвар, үнэ цэн, хандлага болон идэвх, урам зоригийг мөн энэ айгаар эзэмших боломжтой.
- Зан үйлийн айгаар суралцагч энэрэнгүй, хүндэтгэлтэй, хүчирхийлэл үл хэрэглэсэн үйлдэл хийх, бүтээлч харилцаа бий болгох

чадвараа хөгжүүлнэ. Өөрийн шууд болон шууд бус хүрээлэлд тогтвортой хөгжлийг дэмжсэн хөтөлбөр, арга хэмжээнд (орон нутгийн болон дэлхий нийтийн түвшинд) үр бүтээлтэйгээр оролцож, хувь нэмрээ оруулах, үйлдэл хийх чадвар мөн багтана. Эцсийн үр дүнд өөрийн сурсан зүйлээ орон нутгийн хэм хэмжээний хүрээнд, эсхүл өргөн утгаар нь нийгмийн хэм хэмжээний хүрээнд хэрэглэхэд зан үйлийн ай нь тусалдаг.

Өнгөрсөн хугацаанд хийгдсэн ЮНЕСКО-ийн (e.g. UNESCO 2015, UNESCO MGIEP 2017; UNESCO 2017), болон бусад судалгаанд (e.g. UNFPA 2018) дээрх гурван айн судлагдсан байдал энэхүү судалгааны үндсэн хүрээг тодорхойлж байна.

Судалгааны үр дүнд хувь нэмэр оруулах бусад судалгааг мөн харгалзан үзсэн болно (e.g. see CASEL 2013; Durlak et al. 2011; Greenberg et al. 2003; Leach, Dunn and Salvi 2014; O’Conner et al. 2017; Wenger 2009).

УЛС ОРНУУДЫГ СОНГОСОН БАЙДАЛ

Судалгаанд дэлхийн өнцөг булан бүрээс 10 улсыг сонгон авсан. Үүнд, Коста Рика, Япон, Кени, Ливан, Мексик, Марокко, Португал, БНСУ, Руанда болон Швед Улс. Эдгээр улс орон нь ТХБ болон ДИБ-ыг тууштай хэрэгжүүлж байгаа бөгөөд боловсролын тогтолцоо нь харьцангуй төвлөрсөн, тогтвортой тул бодлого, хөтөлбөр нь төлөвлөсний дагуу хэрэгждэг хэмээн үзэх үндэслэлтэй байна. Үүний зэрэгцээ эдгээр улсын хөгжлийн түүх харилцан адилгүй,

хүн ам, газар нутгийн хэмжээний хувьд ялгаатай ба суурь боловсролд баримтлах бодлого, элсэлт болон сургууль дүүргэлтийн хувь хэмжээ ялгаатай байна.

Дэлхийн бүс нутаг тус бүрээс нэг улс сонгосон хэдий ч судалгааны үр дүнд тухайн бүс нутгийн онцлог хэв шинжийг илрүүлж гаргасан гэж хэлэх нь учир дутагдалтайг дурдах нь зүйтэй.

АРГА ЗҮЙ

Судалгаагаар сургуулийн өмнөх, бага, дунд, бүрэн дунд боловсролыг хамарсан үндэсний хэмжээний хууль, бодлого болон сургалтын хөтөлбөрийг судалсан. Ингэхдээ мэргэжлийн боловсрол, насанд хүрэгчдийн болон албан бус боловсролтой холбогдох бичиг баримтыг хөндөөгүй болно. Хичээл судлагдахууны сургалтын хөтөлбөрийг шинжилсэн ба хөтөлбөрийн хэрэгжилт (анги танхимд зааж байгаа байдал), сурах бичиг болон суралцагчийн амжилтын асуудал нь энэхүү судалгааны хүрээнээс давсан учир энэ талаар мэдээлэл цуглуулаагүй болно.

Судалгааны хүрээнд нийт 263 баримт бичгийг шинжилсэн бөгөөд үүнд боловсролын хууль тогтоомж, боловсролын салбарт баримталж буй үндэсний стратеги, үндэсний сургалтын хөтөлбөрийн бүтэцчилсэн хүрээ (national curriculum frameworks), үндэсний хэмжээнд баримталж буй ТХБ/ДИБ-ын холбогдолтой баримт бичгүүд болон тодорхой судлагдахууны үндэсний сургалтын хөтөлбөрүүд орсон. Ингэхдээ хүчин төгөлдөр үйлчилж буй, олон нийтэд нээлттэй тавигдсан баримт бичгийг ашигласан бөгөөд энэ нь тухайн улс орны бодлого, зохицуулалтыг бүрэн илэрхийлж чадахгүй байхыг үгүйсгэхгүй юм. Бичиг баримтын судалгааг хийхдээ боловсролын яам, тамгын газрын болон бусад холбогдох газруудын олон нийтэд нээлттэй цахим хуудаснаас хайлтыг гараар оруулж, мэдээлэл цуглуулсан. Үндэсний зөвлөх экспертүүд баримт бичгийг баталгаажуулсан бөгөөд тэдний санал болгосон нэмэлт баримт бичгийг мөн шинжилсэн. Нээлттэй эх сурвалжаас

олдохгүй баримт бичгүүдийг тухайн улсын яамтай шууд холбогдон электрон, эсхүл цаасан хэлбэрээр авч ашиглалаа. Нийт 263 баримт бичгийн (нэг улсаас 19-39 хүртэлх баримт бичиг ашигласан, дунджаар нэг улсаас 26) гуравны хоёр нь судлагдахууны сургалтын хөтөлбөр байна.

Өмнө хийгдсэн судалгаануудад ТХБ, ДИБ-той холбогдох сэдвүүдийг дараах 8 ангилалд хувааж, кодлосныг ашигласан (UNESCO 2015; European Commission 2017a,b; UNESCO-IBE 2016; UNESCO-MGIEP 2017). Үүнд:

1. Соёлын олон янз байдал, түүнийг хүлээн зөвшөөрөх
2. Энх тайван ба үл хүчирхийлэл
3. Хүний эрх, жендэрийн эрх тэгш байдал
4. Хүрээлэн буй орчны тогтвортой байдал
5. Тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэл
6. Хүн төрөлхтөн оршин тогтнох, сайн сайхан байдал
7. ТХБ-ын тулгуур гурван зарчим
8. ТХБ, ДИБ-той хамааралтай бусад (UNESCO 2016b).

1-6 дугаарт кодлогдсон сэдвүүдийг 1974 оны “Олон улсын ойлголцол, хамтын ажиллагаа, энх тайвны төлөөх боловсрол болон хүний эрх, үндсэн эрх чөлөөтэй холбоотой боловсролын тухай” зөвлөмжийг хянан шалгахад ашигладаг. 1974 оны 11 сарын 14-ны өдөр ЮНЕСКО-ийн 18-р ерөнхий хуралдаанаар гишүүн орнууд уг зөвлөмжийг дагаж мөрдөхөөр тогтсон билээ (UNESCO 1974; 2016; 2018). 7 дугаар сэдэв нь ТХБ-ын “нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчны”

боловсролыг (ТХБ-ын тулгуур гурван зарчим) хөндөж байгаа бол 1-7 дугаарт хамааруулж ангилж болохооргүй, хөндөгдөөгүй бусад сэдвийг, жишээ нь ёс зүйн (moral) боловсрол, зан төлөвийн (character) боловсролтой холбогдох сэдвийг 8 дугаарт кодлож ангилав.

Суралцахуйн айг дараах байдлаар ангилж, кодлов. Үүнд:

1. Танин мэдэхүйн ай
2. Нийгэм, сэтгэл хөдлөлийн ай
3. Зан үйлийн ай
4. Бусад (хоёр ба түүнээс дээш айг хавсруулсан, салгаж үл болох хандлага)

ХЯЗГААРЛАГДМАЛ БАЙДАЛ

- Улс орнуудын эксперт, зөвлөхүүдийг оролцуулан, шаардлагатай бүх баримт бичгийг нэгтгэж, нарийн няхуур цуглуулсан боловч зарим улс орны баримт бичгийн тоо, тухайн баримт бичигт анхаарч хөндсөн асуудал, агуулгын урт богино зэрэгт зөрүүтэй байдал үүссэн. Мөн өгөгдсөн хугацаанд 263 бичиг баримтыг 7 ялгаатай хэл дээр шинжилсэн тул чанарын судалгааг илүү гүнзгий түвшинд хийх, эсхүл судалгаанаас гарсан дүгнэлтэд шинжилгээ хийх, тайлбарлахад хувь нэмэр болгох үүднээс холбогдох талуудаас ярилцлага авах боломжгүй байсныг дурдах нь зүйтэй.
- Шинжилгээ хийх, кодлох явцдаа ТХБ, ДИБ-д бүхэлд нь, тэдгээрийн суралцахуй тал дээр илүү төвлөрсөн бөгөөд ТХБ болон ДИБ-ыг салангид, тус тусдаа зарчим хэмээн авч үзээгүй болно.

Ийнхүү боловсролын дөрвөн түвшинд (сургуулийн өмнөх, бага, дунд, бүрэн дунд боловсрол) суралцахуйн танин мэдэхүйн, нийгэм, сэтгэл хөдлөлийн болон зан үйлийн ай нь ТХБ, ДИБ-ийн дээрх сэдвүүдтэй хэрхэн холбогдож байгааг илрүүлэхийг зорилоо. Судлаачид албан эх сурвалжаас авсан баримт бичгийг шинжлэхдээ тодорхой нэг түлхүүр үг, тодорхойлолт гэхээс илүү түлхүүр зарчим бүрийн утга агуулгыг нь баримталж хайлт хийсэн. Кодлохдоо эхийг бүхэлд нь шинжлэн, “нэгж мэдээлэл”-ийг илрүүлж, утгаар нь кодлосон. Зарим тохиолдолд нэг өгүүлбэр кодлогдсон байхад зарим тохиолдолд хэд хэдэн өгүүлбэрээс бүрдсэн урт агуулгыг нэг кодоор кодлосон болно.

- Зарим улс орон нэг зарчимд нь илүү төвлөрсөн байдаг боловч эдгээр хоёр ойлголт нь цогц, ээдрээтэйгээс гадна ихэнхдээ давхацдаг. Зарим улс орны хувьд одоо хүчин төгөлдөр хэрэгжиж буй хөтөлбөрөөс харахад “ТХБ”, “ДИБ” гэсэн нэр томъёог өргөн хэрэглэдэггүй байна.
- ТХ-ийн зорилго 4.7-д ТХБ, ДИБ-ыг тодорхой зааж өгсөн билээ. ТХЗ 4 батлагдахаас өмнө гарсан баримт бичиг олон байна. Олон улсын болон үндэсний түвшинд ТХБ, ДИБ-ын танилцуулга, жишээ материал гарсны дараа батлагдсан сүүлийн үеийн бичиг баримтад эдгээр зарчим тусгагджээ. Сургалтын хөтөлбөрөө шинэчлэн боловсруулж байгаа хэд хэдэн улс байна. Гэвч албан ёсоор батлагдаагүй байгаа тул судалгаанд тусгагдаагүй болно.

- Судалгааны үр дүнгээс бодлого, сургалтын хөтөлбөрийн баримт бичигт урьдчилсан байдлаар дүгнэлт хийх боломжтой. Харин хөтөлбөрийн хэрэгжилт, анги танхимд хэрхэн хэрэгжиж байгааг дүгнэх нь учир дутагдалтай юм.

Энэхүү судалгаа нь дараа дараагийн судалгаанд мэдээлэл болохоор

3. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Сонгогдсон улс орнууд сургуулийн өмнөх, бага, дунд, бүрэн дунд боловсролын түвшинд ТХБ болон ДИБ-ыг хэрэгжүүлэхдээ суралцахуйн гурван айг (танин мэдэхүйн, нийгэм-сэтгэл хөдлөлийн, зан үйлийн) чухалчлан тусгасан, хэр өргөн цар хүрээтэй тусгасныг тогтоохыг зорьж шинжилсний эцсийн үр дүнг энэ хэсэгт авч үзлээ.

ТХБ, ДИБ-д холбогдох төрөл бүрийн сэдэв болон суралцахуйн хүчин зүйлсийг боловсролын түвшинд бүрд хамааруулж шинжилсэн ба баримт бичгийн төрөл, тодорхой судлагдахууны сургалтын хөтөлбөр болон хэвлэгдэн гарсан цаг хугацаагаар нь мөн хамааруулж шинжилгээ хийсэн болно.

ТАЙЛБАР

Тайлангийн дараагийн хэсэгт үзүүлсэн тоо баримтад байгаа “тусгагдсан хувь” (percentage of references) гэдэг нь тухайн хүчин зүйл/ойлголт нь судалгааны хүрээнд шинжилсэн баримт бичигт тодорхой тусгагдсан тоо хэмжээ юм.

загварчлагдсан бөгөөд бодлого, сургалтын хөтөлбөрийн баримт бичиг нь сурах бичиг, багшийн/сурагчийн гарын авлага, багшийн заах арга барил, сурагч-багшийн харилцаа, сургуулийн орчин болон суралцагчийн амжилтад хэрхэн тусч, хэрэгждэгийг цаашид судлах боломжтой юм.

Түлхүүр үгсийн доод талд дурдагдаж буй “N” үсэг нь тухайн ойлголт улс орнуудын баримт бичигт хэдэн удаа илэрч, кодлогдсоныг харуулна.

Илэрсэн тоо хэмжээ бага (10-аас доош) байгаа тохиолдлыг тайлбарлахдаа түүврийн хэмжээ бага байгааг харгалзан болгоомжтой хандах хэрэгтэй юм. Судалгааны хүрээнд баримт бичгийн бүхий л төрлийг тусгасан бөгөөд хэрэв тусгаагүй тохиолдолд тусгайлан тайлбар хийсэн болно.

Зарим тохиолдолд суралцахуйн айг ангилж, хувиар тооцсон тоо хэмжээ 100% хүрэхгүй байж болох юм. Энэ нь дараах шалтгаанаас үүдэлтэй байх магадлалтай. Үүнд:

- Суралцахуйн айн “Бусад” гэсэн ангилалд багтаан ангилагдсан хүчин зүйл/ойлголт байгаа боловч графикт тусгаагүй байж болно.
- ТХБ, ДИБ-ын “Бусад” гэсэн ангилалд багтаан ангилагдсан хүчин зүйл/ойлголт байгаа боловч графикт тусгаагүй байж болно.

ҮР ДҮН №1

Боловсролын түвшин ахих тусам суралцахуйн нийгэм - сэтгэл хөдлөлийн айд төвлөрсөн байдал багасч танин мэдэхүйн айд илүү төвлөрч байна.

Судалгаанд хамрагдсан 10 улс орны хувьд сургуулийн өмнөх боловсролоос бага боловсролд, бага боловсролоос дунд боловсролд, улмаар бүрэн дунд боловсролын түвшинд шилжих үед ТХБ, ДИБ-ын суралцахуйн нийгэм-сэтгэл хөдлөлийн айд төвлөрөх нь багасч танин мэдэхүйн айд төвлөрөх нь ихэсч байна. Зан үйлийн айд төвлөрөх байдал нь бага зэрэг ихэссэн байдал ажиглагдаж байна.

Ихэнхдээ бага боловсролын түвшнээс эхлэн сургалтын хөтөлбөрийн нэлээд хэсэг нь зан үйлд төвлөрсөн байх бөгөөд сурагчийн өдөр тутам хийдэг үйлдэл, үйл ажиллагааг оролцуулан хүрээлэн буй орчинд (нийгмийн хүрээлэл, байгаль орчин гм.) төвлөрч байна.

Бага боловсролын төгсөх ангиудад, ялангуяа дунд боловсролын түвшинд сурагчдыг тогтвортой хөгжил, дэлхийн иргэншлийн талаар илүү цогц ойлголттой болгох бөгөөд танин мэдэхүйн айд илүү төвлөрч, мэдлэг эзэмшүүлэхэд чиглэж байна.

Гэсэн хэдий ч суурь, бүрэн дунд боловсрол эзэмших явцад нийгэм-сэтгэл хөдлөлийн болоод зан үйлийн чадваруудыг хөгжүүлэх шаардлагатай байгаа юм.

Тогтвортой хөгжил, дэлхий иргэний суурь зарчмыг ойлгож, нийгэмд хувьсал өөрчлөлт хийхэд, тухайлбал, жендэрт суурилсан хүчирхийллийн асуудал, цэвэр усны хүртээмж,

бохирдлын асуудал зэрэгт шийдэл эрэлхийлэхэд шаардлагатай хамтран ажиллах арга хандлагад суралцахад дээрх чадварууд тусална.


Үүнтэй адилаар бага ангид танин мэдэхүйн болон зан үйлийн айд нийгэм-сэтгэл хөдлөлийн айтай адил хэмжээнд төвлөрөх нь чухал юм. Ингэснээр сурагчийн насны онцлогт тохирсон арга хэлбэрээр тогтвортой байдал, дэлхийн иргэншлийн ойлголтыг эзэмшүүлж болно.

Зураг 1-д судалгааны хүрээнд шинжилсэн ТХБ, ДИБ-ын суралцахуйтай холбоотой бичиг баримтад танин мэдэхүйн айг тодорхой тусгасан 1,192 илэрц, нийгэм-сэтгэл хөдлөлийн айг тусгасан 1,085, зан үйлийг айг тусгасан 635 илэрц байсныг харуулж байна.


Боловсролын түвшнээр нь ангилж үзвэл сургуулийн өмнөх боловсролд танин мэдэхүйн айтай холбоотой илэрц 29%, нийгэм-сэтгэл хөдлөлийн айтай холбоотой илэрц 52%, зан үйлийн айтай холбоотой илэрц 17% байна. Суралцахуйн ай бүрийг боловсролын түвшнээр нь харгалзуулан жагсааж харуулбал түвшин ахих тусам суралцахуйн ямар айг чухалчилж тэдгээр нь хэрхэн өөрчлөгдөж байгааг (Зураг 1-ээс) харж болно. Тухайлбал, бүрэн дунд боловсролын түвшинд танин мэдэхүйн айтай холбоотой илэрц 48% буюу өмнөх түвшнүүдийн илэрцээс 29%-42% илүү байна.

Зураг 2-г суралцахуйн айн харьцаа тухайн боловсролын түвшин ямар хувь хэмжээтэй байгааг харууллаа.

Зураг 1. Боловсролын түвшин бүрд (сургуулийн өмнөх, бага, дунд, бүрэн дунд) ТХБ, ДИБ-ын суралцахуйн илэрцийн хувь (суралцахуйн айгаар)



Зураг 2. Боловсролын түвшин бүрд суралцахуйн танин мэдэхүйн, нийгэм-сэтгэл хөдлөлийн болон зан үйлийн айн илэрцийн хувь (сургуулийн өмнөх, бага, дунд, бүрэн дунд)



● Танин мэдэхүйн ай ● Нийгэм-сэтгэл хөдлөлийн ай ● Зан үйлийн ай

ҮР ДҮН №2

Улс орнуудын ТХБ, ДИБ-ын суралцахуйн гурван айд төвлөрсөн байдал нь ихээхэн ялгаатай байна.

Улс орнууд суралцахуйн айд төвлөрч буй байдлаараа, ялангуяа танин мэдэхүйн болон нийгэм-сэтгэл зүйн айд төвлөрч буй байдлаараа ялгаатай байна (Зураг 3).

Зарим улс орон суралцахуйн гурван айн нэгэнд нь илүү төвлөрч байгаа нь ажиглагдлаа.



Тухайлбал, Швед, Мексик, Коста Рика (сүүлийн хоёр улсад нь зөрүү нь харьцангуй бага) улсуудын баримт бичигт танин мэдэхүйн айг нийгэм-сэтгэл хөдлөлийн болон зан үйлийн айнаас илүү тусгасан байна. Гэтэл Ливан, Кени, Марокко болон БНСУ-д нийгэм-сэтгэл хөдлөлийн айг илүү тусгажээ. Япон Улсын хувьд бусад баримт бичигтэй харьцуулахад зан үйлийн айг илүү тусгасан байдал

ажиглагдаж байна².

ТХБ, ДИБ-ын суралцахуйтай холбоотой нийт 5,000 илэрцээс суралцахуйн гурван айд харгалзуулах боломжтой илэрцүүдийг хувиар илэрхийлж харахад ойролцоогоор 40% нь танин мэдэхүйн, 35% нь нийгэм-сэтгэл хөдлөлийн, 24% нь зан үйлийн айд хамаарч байна.

Энэхүү зүй тогтол нь олон янзын учир шалтгаантай байж болох ба ихэнх тохиолдол /кейс дээр ажиглагдаж болох байхад зарим үед нэг тодорхой тохиолдол/-д кейс дээр ажиглагдах боломжтой. Тухайлбал, “Шалгалтад зориулж заах” ерөнхий бодлого баримталдаг, анги танхимд зааж байгаа хандлага нь ийм чиглэлтэй тохиолдолд баримтад суурилсан мэдлэг олгох үйл ажиллагаа давамгайлах нь ойлгомжтой юм. Иймээс судалгаанд авч үзсэн улс орнуудын хувьд танин мэдэхүйн айд илүү төвлөрдөг байж болох зүй тогтол ажиглагдлаа.

Зураг 3. Танин мэдэхүйн, нийгэм-сэтгэл хөдлөлийн, зан үйлийн айн илэрцийн хувь (улсаар)



² Япон Улсын Боловсрол, Соёл, Спорт, Шинжлэх Ухаан, Технологийн Яамнаас бидэнд ирүүлсэн мэдээллээс үзэхэд хууль журам, сургалтын хөтөлбөрийг сургууль дээр хэрэгжүүлэхдээ тэнцвэртэй байдлаар хэрэгжүүлдэг байна.

ҮР ДҮН №3

Улс орнуудын сургалтын хөтөлбөрийг судалж үзэхэд ТХБ, ДИБ-ын суралцахуйн гурван айд харилцан адилгүй төвлөрсөн байдал нь боловсролын түвшний хувьд ялгаатай байна.

ТХБ, ДИБ-ын суралцахуйн айд улс орнууд ялгаатай анхаарч байна. Судалгаанд авч үзсэн улс орнуудын 60% нь боловсролын түвшин ахих тусам танин мэдэхүйн айд төвлөрөх нь ихэсч, нийгэм-сэтгэл хөдлөлийн айд төвлөрөх нь багасч байгаа зүй тогтол ажиглагдлаа.


Улс орнуудын суралцахуйн айн илэрцийг хувиар илэрхийлж, боловсролын түвшин бүрд харгалзуулсныг (Зураг 4-13-т) үзэж болно.

Руанда, БНСУ зэрэг улсад сургуулийн өмнөх боловсролоос бүрэн дунд боловсролд дэвшин суралцах үед танин мэдэхүйн айд илүү төвлөрч, нийгэм-сэтгэл хөдлөлийн айн нь буурч байгаа үзэгдэл нь үндэсний хэмжээний бодлого, тогтолцоотойгоо нийцэж байна. Япон улсын хувьд хэдий бага хэмжээтэй боловч мөн адил зүй тогтол ажиглагдаж байна.


Кени улсын хувьд нөхцөл байдал бусад улсаас өөр харагдаж байна. Сургуулийн өмнөх боловсрол, бага боловсролын түвшинд нийгэм-сэтгэл хөдлөлийн айд төвлөрсөн байдал нь өндөр, танин мэдэхүйн айд төвлөрсөн байдал нь бага байна.

Ливан, Марокко зэрэг улсын хувьд ерөнхий зүй тогтлоос нэлээд ялгаатай бөгөөд боловсролын ихэнх түвшинд нийгэм-сэтгэл хөдлөлийн айд илүү төвлөрсөн байдалтай байна.


Зураг 4. Кени: Танин мэдэхүй, нийгэм-сэтгэл хөдлөл, зан үйлийн айн илэрцийн хувь (боловсролын түвшинээр)




Зураг 5. Руанда: Танин мэдэхүй, нийгэм-сэтгэл хөдлөл, зан үйлийн айн илэрцийн хувь (боловсролын түвшинээр)




Зураг 6. Ливан: Танин мэдэхүй, нийгэм-сэтгэл хөдлөл, зан үйлийн айн илэрцийн хувь (боловсролын түвшинээр)




Зураг 7. Марокко: Танин мэдэхүй, нийгэм-сэтгэл хөдлөл, зан үйлийн айн илэрцийн хувь (боловсролын түвшинээр)




Зураг 8. Япон: Танин мэдэхүй, нийгэм-сэтгэл хөдлөл, зан үйлийн айн илэрцийн хувь (боловсролын түвшинээр)




Зураг 9. БНСУ: Танин мэдэхүй, нийгэм-сэтгэл хөдлөл, зан үйлийн айн илэрцийн хувь (боловсролын түвшинээр)




Зураг 10. Португал: Танин мэдэхүй, нийгэм-сэтгэл хөдлөл, зан үйлийн айн илэрцийн хувь (боловсролын түвшинээр)




Зураг 11. Швед Улс: Танин мэдэхүй, нийгэм-сэтгэл хөдлөл, зан үйлийн айн илэрцийн хувь (боловсролын түвшинээр)



Зураг 12. Коста Рика: Танин мэдэхүй, нийгэм-сэтгэл хөдлөл, зан үйлийн айн илэрцийн хувь (боловсролын түвшинээр)



Зураг 13. Мексик: Танин мэдэхүй, нийгэм-сэтгэл хөдлөл, зан үйлийн айн илэрцийн хувь (боловсролын түвшинээр)



ҮР ДҮН №4

Судалгаанд хамруулсан 10 улсаас 8 улсын хувьд хамгийн багадаа нэг суралцахуйн ай нь 15-аас бага хувийг эзэлж байна.

Судалгаанд хамруулсан 10 улсаас 8 улсын хувьд хамгийн багадаа нэг суралцахуйн ай нь 15%-д хүрэхгүй байна (Хүснэгт 1). Энэ нь тухайн суралцахуйн айтай холбоотой илэрц нь нийт илэрцийн 15-аас бага хувь эзэлж байна гэсэн үг юм. Нийт тохиолдлын дөрөвний гурав нь зан үйлийн айтай холбоотой илэрц байна. Талаас илүү тохиолдол нь дунд, бүрэн дунд боловсролын түвшинд илэрч байгаа ба энэ түвшинд суралцахуйн гурван айгаас (хамгийн багадаа) нэг айд нь бага төвлөрч байна гэсэн үг юм. Хамгийн их төвлөрсөн, хамгийн

бага төвлөрсөн суралцахуйн айн ялгааг ерөнхийд нь болоод боловсролын түвшин бүрээр нь авч үзвэл 3-63% байна. Япон болон БНСУ-ын хувьд боловсролын бүхий л түвшинд гурван суралцахуйн ай бүрийг их бага хэмжээгээр тууштай тусгажээ.

Боловсролын дөрвөн түвшинд бүгдэд нь гурван суралцахуйн айг адил хэмжээгээр тусгасан улс байхгүй байна (20% дотор). Коста Рика боловсролын гурван түвшиндээ харьцангуй адил хэмжээгээр тусгасан ажиглагдаж байгаа бол Япон болон БНСУ хоёр боловсролын түвшиндээ суралцахуйн гурван айг жигд тусгажээ. Коста Рикагийн хувьд сургуулийн өмнөх боловсролд суралцахуйн гурван айн зөрүү нь 6% байгаа нь гурван айг адил төстэй хэмжээгээр хэрэглэж, харьцангуй жигд төвлөрдөг гэдгийг харуулж байна. Кени улсын хувьд 46%-ийн зөрүү ажиглагдаж байгаа бөгөөд энэ нь тухайн боловсролын түвшинд суралцахуйн айд хамгийн их болон хамгийн бага төвлөрсөн илэрцийн зөрүү бөгөөд зарим суралцахуйн айд хэт чухалчилж байгааг харуулж байна.

Хүснэгт 1-д тухайн боловсролын түвшинд уг суралцахуйн айд төвлөрсөн илэрц 15% хүрэхгүй байгаа 24 нүдийг саарлаар тодруулсан байна. Үүний 16 нь зан үйлийн айд хамаарах ба 11 нь дунд, бүрэн дунд боловсролын түвшинд хамаарч байна.

Хүснэгт 1. Суралцахуйн гурван айг боловсролын түвшин бүрд харгалзуулж үзсэн байдал (улсаар)

СУРАЛЦАХУЙН АЙ



		Танин мэдэхүйн ай	Нийгэм -сэтгэл хөдлөлийн ай	Зан үйлийн ай	% Зөрүү
КОСТА РИКА	СӨБ	35%	29%	35%	6%
	ББ	72%	12%	16%	60%
	ДБ	31%	34%	32%	3%
	БДБ	34%	37%	28%	9%
	Нийт	44%	28%	27%	17%
ЯПОН	СӨБ	26%	36%	38%	12%
	ББ	32%	28%	40%	11%
	ДБ	41%	18%	42%	24%
	БДБ	45%	20%	35%	25%
	Нийт	39%	23%	38%	16%
КЕНИ	СӨБ	27%	59%	12%	46%
	ББ	9%	72%	19%	63%
	ДБ	56%	38%	6%	50%
	БДБ	70%	7%	23%	63%
	Нийт	33%	52%	13%	39%
БНСУ	СӨБ	20%	56%	22%	36%
	ББ	26%	45%	27%	19%
	ДБ	39%	37%	23%	16%
	БДБ	52%	21%	24%	31%
	Нийт	36%	38%	24%	14%

ТХБ, ДИБ-ын суралцахуйн зан үйлийн айд төвлөрсөн хандлага харьцангуй доогуур үзүүлэлттэй байгааг олон өнцгөөс тайлбарлаж болох юм. Үйл ажиллагаанд суурилсан (activity-oriented) заах арга зүй, суралцахуйн үр дүнд илүү анхаарал хандуулах болсон хэдий ч ихэнх сургалтын хөтөлбөр хийсвэр мэдлэгийг чухалчилсан, танин мэдэхүйн суралцахуйн айд төвлөрсөн хэвээр байгааг юуны өмнө дурдах нь зүйтэй. Мөн шалгалтад бэлтгэхэд чиглэдэг уламжлалт боловсролын тогтолцоонд зан үйлд төвлөрсөн суралцахуйгаар суралцагчийн амжилтыг үнэлэхэд хүндрэлтэй байх магадлалтай. Цашилбал сургуулийн өмнөх насныхны хувьд сургаж, хийлгэж болох зүйлс нь хязгаарлагдмал тул ТХБ, ДИБ-д тэдний насанд тохирсон зан үйлийг тодорхойлоход бэрхшээл тулгарч байна. Хүүхэд бага насандаа сургууль дээрээ (найрсаг харилцах), гэртээ (хогоо ангиллах), хороо, дүүрэгтээ (ахмад настны асрамжийн газар сайн дурын ажилд оролцох) гэх мэт зан үйлийн чухал чадваруудыг эзэмшдэг хэдий ч өргөн утгаар олон нийт рүү чиглэсэн үйл ажиллагаанд оролцоход суралцах тал дээр хязгаарлагдмал байдаг. Нөгөөтэйгүүр гадна орчинд суурилсан, хороо, дүүрэг, олон нийтийн үйл ажиллагаанд суурилсан зан үйлийн заах арга зүй сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролд хамрагдаж буй бүхий л насны суралцагчдын хувьд амжилттай хэрэгжих боломжтой юм.

СУРАЛЦАХУЙН АЙ



		Танин мэдэхүйн ай	Нийгэм -сэтгэл хөдлөлийн ай	Зан үйлийн ай	% Зөрүү
ЛИВАН	СӨБ	0% ¹	100% ¹	0% ¹	100% ¹
	ББ	44%	51%	5%	46%
	ДБ	40%	48%	12%	36%
	БДБ	28%	65%	8%	58%
	Нийт	37%	55%	8%	47%
МЕКСИК	СӨБ	41%	43%	14%	29%
	ББ	58%	35%	6%	52%
	ДБ	37%	47%	15%	32%
	БДБ	49%	17%	34%	32%
	Нийт	46%	35%	18%	27%
МАРОККО	СӨБ	43%	29%	29%	14%
	ББ	46%	50%	4%	46%
	ДБ	41%	45%	14%	31%
	БДБ	31%	49%	20%	29%
	Нийт	40%	46%	14%	32%
ПОРТУГАЛ	СӨБ	42%	33%	25%	17%
	ББ	39%	19%	42%	23%
	ДБ	65%	19%	15%	50%
	БДБ	74%	11%	15%	63%
	Нийт	56%	19%	25%	38%
РУАНДА	СӨБ	27%	73%	0%	73%
	ББ	26%	58%	16%	42%
	ДБ	45%	36%	19%	25%
	БДБ	49%	31%	18%	31%
	Нийт	41%	40%	18%	24%
ШВЕД	СӨБ	0% ¹	0% ¹	0% ¹	0% ¹
	ББ	54%	25%	21%	32%
	ДБ	55%	10%	35%	45%
	БДБ	83%	17%	0%	83%
	Нийт	66%	18%	16%	51%

³ Ливан болон Швед Улсын хувьд сургуулийн өмнөх боловсролын түвшний илэрцийн хувь маш бага тул (10-аас бага) анализ, дүгнэлт хийхдээ харгалзан үзэх нь зүйтэй.

Тайлбар: Дээрх гурван баганад улс тус бүрийн боловсролын түвшин бүрд суралцахуйн гурван айн илэрцийг хувиар илэрхийлж харуулав. Саарлаар будаж тодруулсан нь тухайн боловсролын түвшинд, тухайн суралцахуйн айд төвлөрсөн илэрц 15% буюу түүнээс бага байгааг харуулж байна. “% Зөрүү” баганад тухайн боловсролын түвшний хамгийн их илэрц, хамгийн бага илэрцийн зөрүүг бодож гаргасан. Зөрүү нь бага (жиш, Коста Рика Улсын сургуулийн өмнөх боловсролын түвшин) гарсан улсын хувьд гурван суралцахуйн ай тус бүрд харьцангуй жигд төвлөрсөн байгааг харуулж байгаа бол зөрүү их байгаа нь (жиш, Кени болон Швед Улсын дунд, бүрэн дунд боловсролын түвшин) төвлөрөл нь харилцан адилгүй байна гэсэн үг юм. “Бусад” ангилалд орсон илэрцийг дүн шинжилгээнд оруулаагүй тул боловсролын түвшин дэх хувь хэмжээ 100% хүрэхгүй байж болно.

ҮР ДҮН №5

ТХБ, ДИБ-ын суралцахуйн айг боловсролын баримт бичигт тусгасан байдал ялгаатай байна.


Боловсролын хууль тогтоомж нь суралцахуйн танин мэдэхүйн болон зан үйлийн айд төвлөрөхөөс илүүтэйгээр нийгэм-сэтгэл хөдлөлийн айд илүү төвлөрсөн байх бөгөөд баримт бичгийн бусад төрөлд энэхүү харьцаа мөн адил төстэй ажиглагдлаа. Мөн түүнчлэн баримт бичгийн төрөл бүрд ДИБ-той холбоотой илэрц ТХБ-той холбоотой илэрцээс ойролцоогоор хоёр дахин илүү байна (Зураг 15).

Сонгосон улс орнуудын хууль тогтоомж болон бусад баримт бичигт суралцахуйн гурван айг тусгасан харьцаа ойролцоо байгааг (Зураг 14-өөс) харж болно. Бодлогын бүхий л түвшний баримт нийгэм-сэтгэл хөдлөлийн айд илүү төвлөрсөн байгаа нь харагдаж байна. Хууль журам нь үндсэн хуулийн болон ёс зүйн хэм хэмжээний хүрээнд батлагддаг тул нийгэм сэтгэл хөдлөлийн ай илүү илэрцтэй байх нь зүй ёсны хэрэг гэж үзэж болох талтай.


Зураг 15-д үзүүлсэн ДИБ болон ТХБ-ын бичиг баримтад тусгагдсан харьцаа анхаарал татаж байна. Бичиг баримтын төрлөөр нь харвал ДИБ, ТХБ-ын агуулга тусгагдсан байдал маш ялгаатай байгааг

энд дурдах нь зүйтэй. Бичиг баримтын илэрцийг N үсгээр тэмдэглэн оруулсан.

Зураг 14. Танин мэдэхүй, нийгэм-сэтгэл хөдлөл, зан үйлийн айн илэрцийн хувь (баримт бичгийн төрлөөр)




Зураг 15. ТХБ, ДИБ-ын суралцахуй айг баримт бичигт тусгасан байдал (хувиар)



ҮР ДҮН №6

Судалгаанд хамрагдсан улсуудын “нийгмийн ухаан”, “байгалийн ухаан” -ы сургалтын хөтөлбөр нь бусад сургалтын хөтөлбөртэй харьцуулахад танин мэдэхүйн айд илүү төвлөрсөн байна.

Зураг 16. Танин мэдэхүй, нийгэм-сэтгэл хөдлөл, зан үйлийн айн илэрцийн хувь, судлагдахууны төрлөөр (ерөнхий эрдэм, нийгмийн ухаан⁴, байгалийн шинжлэх ухаан, хэл, бусад шаардлагатай)



Нийгэм болон байгалийн ухааны сургалтын хөтөлбөрт ТХБ, ДИБ-ын танин мэдэхүйн айд илүү ач холбогдол өгсөн энэхүү хандлага нь олон улс орны боловсролын тогтолцоонд “академик” агуулгыг дээгүүр тавьж, стандарт тестээр шалгалт авдаг хандлагатай тохирч байгаа юм.

Танин мэдэхүйн айд илүү төвлөрч, нийгэм-сэтгэл хөдлөл, зан үйлийн айг адил хөгжүүлж, тэнцвэртэй эзэмшүүлээгүй тохиолдолд суралцагчид ТХБ, ДИБ-ын стандарт шалгалтыг амжилттай өгч чадах боловч уг мэдлэгээ урт хугацаанд хэрэглэхэд нь шаардагдах зан үйлийн, эсхүл нийгэм-сэтгэл хөдлөлийн хандлага төлөвшихгүй байх магадлалтай юм.

ҮР ДҮН №7


ТХБ, ДИБ-ын суралцахуй, суралцахуйн айг багтаасан баримт бичгүүд нь хэвлэгдсэн огноо, хугацаагаараа хоорондоо ялгаатай байна.

Судалгаанд шинжилгээ хийсэн баримт бичгийг 2006 он хүртэл, 2006-2014 он, 2015 оноос өнөөг хүртэл гэсэн гурван цаг хугацаанд хувааж үзсэн бөгөөд энэ хугацаанд батлагдсан баримт бичгүүдэд ТХБ болон ДИБ-ын сэдвүүд харьцангуй тогтмол тусгагдаж ирсэн байна (Зураг 17). Харин суралцахуйн гурван ай хэрхэн тусгагдсаныг авч үзвэл ялгаатай байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд батлагдсан баримт бичгүүдэд

⁴ “Нийгмийн ухаан” гэдэгт нийгэм судлал, түүх, газарзүй, иргэний боловсрол г.м. холбогдох бүх сургалтын хөтөлбөрийг оруулсан. “Шаардлагатай бусад” гэдэг нь улс орон болгонд ялгаатай хичээлүүд байж болох бөгөөд үндсэн бус, гэхдээ ТХБ, ДИБ-д хамааралтай, зайлшгүй шаардлагатай бусад сургалтын хөтөлбөрийг багтаасан. “Ерөнхий эрдэм” гэдэг нь боловсролын аль ч түвшинд байж болох, тодорхой судлагдахуунаар зааглаагүй, ерөнхий сургалтын хөтөлбөрүүд орох бөгөөд сургуулийн өмнөх, бага боловсролын сургалтын хөтөлбөрүүд орно.


гурван суралцахуйн айг илүү өргөн, тодорхой тусгах болсон нь ажиглагдлаа (Зураг 18).

Зураг 17. ТХБ болон ДИБ тусгагдсан дундаж тоо (хэвлэгдсэн цаг хугацаагаар)



Тайлбар: Зураг 17-д харуулсан дунджийг тооцоолохдоо тухайн цаг хугацаанд тусгагдсан тоог баримт бичгийн тоонд хувааж гаргасан болно.

Зураг 18. Танин мэдэхүй, нийгэм-сэтгэл хөдлөл болон зан үйлийн айн тусгагдсан дундаж тоо (хэвлэгдсэн цаг хугацаагаар)



Тайлбар: Зураг 18-д харуулсан дунджийг тооцоолохдоо тухайн цаг хугацаанд тусгагдсан тоог баримт бичгийн тоонд хувааж гаргасан болно.

ТХБ, ДИБ-той холбоотой бодлогын баримт бичиг, сургалтын хөтөлбөрүүд 1997-2018 оны хооронд батлагдсан байх бөгөөд энэ хугацаанд НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн Боловсролын 10 жил (2005-2014), ДИБ-ын ач холбогдлыг дэвшүүлэн тавьсан НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын “Боловсрол Нэгдүгээрт” санаачилга (2012-2016) зэрэг чухал баримт бичгүүд батлагдан, хэрэгжсэн билээ.

ТХБ, ДИБ-ыг хэрэгжүүлэх тухай дээр дурдсан чухал баримт бичгээс гадна ЮНЕСКО болон бусад олон байгууллагаас үйл ажиллагааны төлөвлөгөө, удирдамжийг боловсруулан гаргасан байна. Улс орнуудын боловсролын яам нь ТХБ, ДИБ-ын үндэсний стратеги, төлөвлөгөөгөө зориулалтын цахим хуудаст байршуулдаг болж, ТХБ, ДИБ-ыг дэмжих, орон нутагт турших зорилготойгоор үндэсний болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулалтад орох нь нэмэгдсэн байна. 2017 онд ТХЗ 4-ын хэрэгжилтийг хэмжих шалгуурт ДИБ-ыг оруулснаас хойш 1981 онд яригдаж байсан “Энх тайвны боловсрол”, 1995-2004 онд хэрэгжсэн “Хүний эрхийн боловсрол”, 1995 (Бээжин) онд хөндөгдөж байсан “Жендэрийн эрх тэгш байдал” зэргийг ДИБ-той холбон тайлбарлах тохиолдол олон байдаг.

Хэдийгээр эдгээр санаачилгууд тусгайлан батлагдаж, хэрэгжиж байсан хэдий ч ТХБ-той холбоотой сэдвүүд харьцангуй тогтвортой байсан бол сүүлийн үеийн баримт бичигт ДИБ-той холбоотой сэдвүүдэд анхаарал

хандуулах нь тодорхой хэмжээнд өссөн байдал ажиглагдлаа (Зураг 17).

Суралцахуйн амжилт, заах арга зүйн практикт нийгэм-сэтгэл хөдлөлийн болоод зан үйлийн айн ач холбогдлыг судалсан судалгаа, туршилт нэмэгдэж байна (e.g. Berman, Chaffee and Sarmiento, 2018; OECD, 2018). Үүнтэй холбоотойгоор (Зураг 18-ын) хувьд сүүлийн үеийн бодлогын баримт бичиг болон сургалтын хөтөлбөр нь 3 суралцахуйн айг багтаах чиг хандлагатай байх болов уу гэсэн хүлээлттэй байсан байна. Үүнийг энэ судалгааны үр дүн баталж байна. 2015 оноос хойших баримт бичгүүд суралцахуйн тодорхой айд төвлөрч, өмнөх жилүүдээс даруй хоёр дахин илүү тусгасныг харж болно. Суралцахуйн ай бүрийг багтаах хандлага баримтлах болсон нь улс орнууд боловсролын үйл явц болон суралцахуйн амжилтын хувьд танин мэдэхүй, нийгэм-сэтгэл хөдлөл болон зан үйлийн тодорхой айд хэр их ач холбогдол өгөхөө тухай бүрд нь тодорхойлоод явах төлөвтэй байна. Тухайлбал, Коста Рика, Япон болон БНСУ сургалтын хөтөлбөрөө саяхан шинэчилсэн бөгөөд хоёр ба түүнээс дээш боловсролын түвшиндөө суралцахуйн гурван айд жигд төвлөрч боловсруулсан байна.

ҮР ДҮН №8

ТХБ-той харьцуулахад ДИБ-той холбоотой агуулга-сэдэвт харьцангуй илүү анхаарал хандуулжээ.

Судалгаанд хамрагдсан улсууд, баримт бичгийн болон боловсролын бүхий л түвшинд ДИБ-той холбоотой илэрц ТХБ-оос хоёр дахин илүү (холбогдох

сэдвийг кодлон илэрцийг шинжилсэн ба 63% болон 32% гэсэн харьцаатай) байгаа нь нийтлэг байна.

Судалгаанд хамрагдсан улс бүрийн хувьд ТХБ болон ДИБ-той холбоотой сэдвүүдийн нийт эзлэх хувь хэмжээ болон ТХБ, ДИБ-ын сэдэв тус бүрийн эзлэх хувийг (Зураг 19-д) харууллаа.

Судалгаанд хамрагдсан 10 улсын баримт бичигт шинжилгээ хийж илрүүлсэн нийт агуулгын 60-аас илүү хувь нь ДИБ-той холбоотой байна. ДИБ болон ТХБ-ын ямар сэдвүүдэд хамгийн их анхаарал хандуулж байгааг дараах дугуй диаграммаас харж болно. БНСУ, Марокко, Ливан улсууд ДИБ-д хамгийн их анхаарал хандуулж байна (нийт илэрцийн 74-79%). Швед, Португал, Коста Рика болон Мексик улс ТХБ-д илүү анхаарал хандуулж байна (нийт илэрцийн 40-50%). ТХБ, ДИБ-той хамааралтай боловч бидний судалгааны хүрээнд тодорхойлогдсон 1-7⁵ сэдэвт харьяалагдаагүй “бусад” илэрцүүд, тухайлбал ёс зүйн боловсрол, зан төлөвийн боловсрол (character education) нийт илэрцийн 5%-ийг эзэлж байна.

Энэхүү үр дүнг тайлж уншихад хэд хэдэн хүчин зүйлсийг анхаарах нь зүйтэй. Нэгдүгээрт энэхүү судалгааны хүрээнд ТХБ, ДИБ болон тэдэнтэй холбогдох сэдвүүдийг бид урьдаас кодлон ангилж, түүнийхээ дагуу шинжилсэн. Олон улс орнуудад “ДИБ”-


⁵ ТХБ, ДИБ болон “бусад” сэдвийг ангилсан нарийвчлалыг Хавсралт 5-аас харна уу. ДИБ-д соёлын олон янз байдал болон түүнийг хүлээн зөвшөөрөх, энх тайван, үл хүчирхийлэл, хүний эрх болон жендэрийн эрх тэгш байдал зэрэг сэдвийг багтаан ангилсан. ТХБ-д хүрээлэн буй орчны тогтвортой байдал, тогтвортой үйлдвэрлэл ба хэрэглээ, хүний төрөлхтөн амьд үлдэх, эрүүл энх байх болон ТХБ-ын тулгуур гурван зарчмыг багтаасан. ТХБ/ДИБ-ын суралцахуйд чиглүүлсэн боловч дээрх 7 ангиллын аль нэгэнд шууд хамаарах боломжгүй сэдвийг “бусад” хэмээн ангилсан.

ын зарим сэдвийг “ТХБ”-ын сэдэв болгон ангилж, хэрэглэдэг байж болно (жишээ нь: хүний эрх болон жендэрийн эрх тэгш байдал).

Хоёрдугаарт, боловсруулагдсан баримт бичиг нь тухайн цаг үеийнхээ хандлага, чиглэлийг тусгасан байх магадлалтай. Жишээ нь, БНСУ-ын баримт бичиг нь Ливан улсынхаас харьцангуй цөөн боловч (19 болон 18 баримт бичиг)

судлагдахууны сургалтын хөтөлбөрүүд хэвлэгдсэн хугацаа нь ойролцоогоор 20 жилийн ялгаатай юм (2015 болон 1997 онд тус тус боловсруулсан). Энэ нь БНСУ-ын сургалтын хөтөлбөр дэх ТХБ, ДИБ-той холбоотой илэрц, Ливан улсынхтай харьцуулахад дөрөв дахин илүү тусгагдсан байх талтай (ТХБ, ДИБ-той холбоотой материал, гарын авлага, хандлага чиглэл нь сүүлийн 10 жилд илүү хэрэглэгдэх болсон).

Зураг 19. ТХБ болон ДИБ-той холбоотой сэдвүүд тусгагдсан хувь (улсаар)



Гуравдугаарт, тухайн түүхэн цаг үедээ ТХБ, ДИБ-ын арга хандлагад хэр тууштай хандаж байсан, төрийн болон төрийн бус байгууллагын зүгээс нарийвчлан боловсруулсан төсөл хөтөлбөр байсан эсэх, хэл, соёлын онцлогт тохирсон хандлага байсан эсэхийг мөн харгалзан үзэх нь зүйтэй. Жишээ нь, Япон Улсын хувьд “ТХБ, ДИБ-д хамаарагдах бусад” ангилалд

багтсан сэдвүүдийн ихээхэн хэсэг нь бага болон бүрэн дунд боловсролын түвшин дэх “ёс зүйн боловсрол”-ын холбогдолтой сэдвүүд байна. 2019 оноос Япон Улс ёс зүйн боловсролыг боловсролын бүх түвшиндээ бие даасан хичээл болгон оруулсан ба энэхүү сургалтын хөтөлбөр нь ДИБ-ыг бараг бүхэлд нь хамруулж үзсэн байна.


ҮР ДҮН №9

ТХБ-той холбоотой түлхүүр үгс нь ялгаатай байна.

Баримт бичигт хайлт хийхдээ ашигласан ТХБ-той гурван түлхүүр үгсээс “тогтвортой хөгжил” (ТХ) гэсэн түлхүүр үг хамгийн их илэрцтэй байсан ба “тогтвортой хөгжлийн боловсрол” (ТХБ) хоёрт “хүрээлэн буй орчны боловсрол” (ХБОБ) гэсэн түлхүүр үг хамгийн бага илэрцтэй байв (Зураг 20).

гэсэн түлхүүр үг хамгийн их илэрцтэй байсан ба “тогтвортой хөгжлийн боловсрол” (ТХБ) хоёрт “хүрээлэн буй орчны боловсрол” (ХБОБ) гэсэн түлхүүр үг хамгийн бага илэрцтэй байв (Зураг 20).

Зураг 20. ТХБ-ын түлхүүр ойлголтуудын илэрцийн хувь (улсаар)



ТХБ-ын түлхүүр үгсийн хайлтыг судалгаанд хамрагдсан бүх улсын хэл дээр хийсэн. ТХБ-ын түлхүүр үгсийн

илэрцийг улс тус бүрээр нь (Зураг 20-д) харууллаа. Зарим улс орны ХБОБ болон ТХБ-д түүхэн арга хандлага,


судалгаа шинжилгээ хийгдсэн байдал болон баримталж ирсэн бодлого чиглэлийг харьцуулж харахад ТХБ-ын (болон ТХ) илэрц ХБОБ-той харьцуулахад бүхий л баримт бичгийн хувьд илүү илэрцтэй байгаа нь сонирхол татаж байна. Судалгаанд хамруулсан улс орнуудад Ливан Улсаас бусдад нь энэ байдал ажиглагдлаа.

ҮР ДҮН №10

ТХБ-ын болон ДИБ-ын сэдвүүдийн суралцахуйн айг тусгасан байдал нь хоорондоо ялгаатай байна.

ДИБ-ын агуулга нь нийгэм-сэтгэл хөдлөлийн айг танин мэдэхүйн айгаас илүү төвлөрсөн ба зан үйлийн айд бага анхаарал хандуулсан байгаа нь баримт бичгүүдэд нийтлэг ажиглагдлаа Зураг 21-т ТХБ-ын агуулга нь танин мэдэхүйн айд зан үйлийн айгаас илүү төвлөрсөн ба нийгэм-сэтгэл хөдлөлийн айд хамгийн бага анхаарал хандуулжээ.

Зураг 21. ДИБ, ТХБ-ын агуулгын илэрцийг танин мэдэхүй, нийгэм-сэтгэл хөдлөл болон зан үйлийн айд харгалзуулсан байдал (хувиар)



Зураг 22-т суралцахуйн ай бүрийг ТХБ, ДИБ-ын сэдэв бүрээр харгалзуулж харууллаа.

Шинжилгээ хийх үед хүчин төгөлдөр үйлчилж байсан баримт бичгийн батлагдсан хугацаанаас хамаарч илэрцийн хувь хэмжээнүүд ялгаатай байна. Жишээ нь, Ливан Улсын хувьд судлагдахууны сургалтын хөтөлбөр нь 1997 онд батлагдсан ба энэ нь ТХБ-ын 10 жил (2005-2014) болон ТХЗ-ууд батлагдахаас (2015) өмнө гэсэн үг юм.

Энд харуулсан үр дүн нь Үр дүн №1-д (Зураг 1, 2)- суралцахуйн айг боловсролын түвшинд харгалзуулан харуулсантай холбоотой байж болох юм. Үр Дүн №1-д харуулснаар бага ангиудад ТХБ, ДИБ-ын нийгэм-сэтгэл хөдлөлийн айд илүү төвлөрч байгаа нь ажиглагдсан ба үүний улмаас сургуулийн өмнөх болон бага боловсролын түвшинд ДИБ-ын сэдвүүдэд илүү анхаарал хандуулсан байх магадлалтай юм.

Харин хүрээлэн буй орчны холбогдолтой сэдвүүдийн хувьд ялгаатай байна. Өнгөрсөн хугацаанд хүрээлэн буй орчны сэдвийг ихэнхдээ байгалийн ухаанд хамааруулж үздэг байсан тул танин мэдэхүйн айд илүү төвлөрдөг байдал ажиглагдлаа.

ТХБ-ын хувьд суралцахуйн танин мэдэхүйн ай өндөр түвшинд байгаа нь үүнтэй холбоотой ба судалгааны хүрээнд шинжилсэн баримт бичгийн баталсан, боловсруулсан хугацаатай хамааралтай байж болохыг харгалзан үзэх нь зүйтэй юм.

Зураг 22. ДИБ, ТХБ-ын сэдвүүдийг танин мэдэхүй, нийгэм-сэтгэл хөдлөл болон зан үйлийн айд харгалзуулсан байдал (хувиар)



Танин мэдэхүйн ай



Нийгэм-сэтгэл хөдлөлийн ай



Зан үйлийн ай

4. ДУГНЭЛТ

1. Зүй тогтлын хувьд ялгаатай байна.

Өөр хоорондоо харилцан хамааралтай суралцахуйн гурван айн (танин мэдэхүйн, нийгэм-сэтгэл хөдлөл, зан үйлийн ай) аль алинд нь адил тэнцүү хэмжээгээр төвлөрч чадвал ТХБ, ДИБ-ыг цогцоор нь эзэмшүүлэх боломжтой. Судалгаанаас үзэхэд суралцахуйн ай бүрд анхаарал төвлөрүүлж буй байдал нь улс орнууд, тэдний соёл болоод боловсролын түвшин зэргээс хамаараад ялгаатай байна. Тухайн улс орны боловсролын тогтолцоо, агуулга, боловсролын түвшин бүрд суралцагчийн хэрэгцээг хангахтай холбоотойгоор аль айд төвлөрөх, боловсролын түвшин ахих бүрд тэдгээрийг хэрхэн хэрэгжүүлэхэд нөлөөлж байна.

2. Суралцахуйн цогц хандлага чухал хэвээр байна.

Улс орнуудын хувьд суралцахуйн гурван айд ялгаатай анхаарал хандуулж байна. Нийгэм-сэтгэл хөдлөлийн болон зан үйлийн айд илүү анхаарал хандуулах шаардлагатай байгааг судалгаанаас харж болно. Эдгээр хоёр ай нь дан дангаараа чухал ач холбогдолтойгоос гадна зорилготойгоор нэгтгэж, аль алиныг нь анхаарвал эерэг үр дүнтэй юм. Танин мэдэхүйн аргаар олж авсан мэдлэгээ нийгэм-сэтгэл хөдлөлийн хүчин зүйлсээр баяжуулах, түүнчлэн суралцагчаар үйлдүүлж, оролцоонд суурилсан заах аргыг хэрэглэвэл сурсан мэдлэг нь илүү утга учиртай, мартагдашгүй байж чадна.

3. Судлагдахууны айнаас хамаарч ялгаатай байна.

Суралцахуйн гурван айд их бага, ялгаатай төвлөрсөн байгаа нь ТХБ, ДИБ-ыг тусган, зааж эзэмшүүлж буй тухайн судлагдахуун нь ямар шинжлэх ухаанд хамаарч байгаагай холбоотой байна. Жишээ нь, байгалийн шинжлэх ухаан, нийгмийн шинжлэх ухааны судлагдахуунууд тодорхой нэг суралцахуйн айд (танин мэдэхүй) илүү төвлөрсөн байна. Тийм учраас бүхий л судлагдахууны сургалтын хөтөлбөр, сурах бичиг, багшийн гарын авлагад суралцахуйн гурван айг жигд тусгах нь зүйтэй. Сургуульд боловсрол олгохдоо судлагдахууныг дангаар нь, богино хугацаанд эзэмшүүлдэг явдал нь суралцахуйн гурван айг бүгдийг нь, цогц байдлаар эзэмшүүлэх боломжийг хязгаарлаж байгааг анхаарч үзэх нь чухал байна. Судлагдахуунуудыг интеграцчилж, судлах хугацааг уртасгах алтернатив арга замыг эрэлхийлснээр, жишээ нь олон нийтийн үйл ажиллагаанд оролцоход суурилсан суралцахуй (community-based action learning)-г хөгжүүлсэнээр, нийгэм-сэтгэл хөдлөл, зан үйлийн чадварыг илүү сайн эзэмшиж, үр дүнд хүрэх боломжтой юм.

4. Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага

ТХБ, ДИБ-ыг эзэмшүүлэхэд СБААХ-ыг хэрэгжүүлэхийг ЮНЕСКО-оос зөвлөдөг. Ингэснээр суралцагчид мэдлэг эзэмшихээс гадна, сурсан зүйлээ нийгмийн бодит орчинд

туршиж, “дадлагажих” боломжтой болно. Хичээлээс гадуурх нэмэлт хөтөлбөрийг хэрэгжүүлснээр ТХБ, ДИБ-ын нийгэм-сэтгэл хөдлөл, зан үйлийн чадварыг эзэмшүүлэх боломжтой. ТХБ, ДИБ-ыг цогц байдлаар эзэмшүүлэх бас нэгэн арга зам нь сургууль болон нийгэм/олон нийт ойр байж, хамтран ажиллах явдал юм. Оновчтой заах арга зүй, багшийн бэлэн байдал чухал ач холбогдолтой болохыг дээрх олон төрлийн арга хандлагууд харуулж байна. Судалгааны хүрээнд бидний шинжилсэн баримт бичигт тусгагдсан зорилго, тэргүүлэх чиглэл зэргийн хэрэгжилтийг сайжруулахад энэ нь чухал үүрэгтэй билээ.

5. Цаашид хийх судалгаа


Энэхүү судалгаагаар боловсролын голлох бодлогын баримт бичгүүд болон сургалтын хөтөлбөрийн хүрээнд шинжилгээ хийсэн. Сурах бичиг, багшийн гарын авлагад нэмэлтээр

шинжилгээ хийвэл ТХБ, ДИБ-ын талаар илүү цогц дүр зурагтай болно. Үүнээс гадна сургуулийн орчин, цаашлаад суралцагчийн гэр бүл, тэдний орчинд ямар үйл явц өрнөж байгааг судалбал суралцахуйн цогц хандлагын үр нөлөө ямар байгааг ойлгож мэдэхэд тустай. Боловсролын бодлого, сургалтын хөтөлбөрт тусгагдсан нийгэм-сэтгэл хөдлөлийн болон зан үйлийн суралцахуйн ай нь сургуулийн үйл ажиллагаанд хэрхэн хэрэгжиж, анги танхимд багш хэрхэн зааж байгааг судалж үзэх хэрэгтэй юм. Хамгийн чухал нь сургалтын үйл явц, жишээ нь, судлагдахуунд суурилсан сургалтын хөтөлбөр нь суралцагчдад бидний хүссэн оюун ухаан, хандлага, үнэ цэн болон зан үйлийг хэрхэн төлөвшүүлж байгааг судалж үзэх нь зүйтэй.

ТХБ, ДИБ-той холбоотой суралцахуйн үйл явц, үр дүнгийн талаар цаашид судалгаа хийх шаардлагатай байна.

ADVANCING EDUCATION FOR
SUSTAINABLE DEVELOPMENT

Key Success Factors for Policy and Practice



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ БОЛОВСРОЛЫГ
БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ

Дэлхийн Ирээдүйн Зөвлөл нь бидний үр хойчид эрүүл дэлхий ертөнц, шударга нийгмийг үлдээхийн төлөө ажилладаг. Энэ зорилгодоо хүрэхийн тулд үр дүнтэй, шударга ирээдүйтэй бодлогын шийдлийг тодорхойлж, түгээн дэлгэрүүлэхэд анхаарлаа хандуулж, түүний хэрэгжилтийг дэлхий дахинд сурталчилж байна. Дэлхийн Ирээдүйн Зөвлөл нь засгийн газар, парламент, иргэний нийгэм, шинжлэх ухаан, урлаг, бизнесийн ертөнцийн нэр хүнд бүхий дэлхийг өөрчлөгч 50 гишүүнтэй. Альтернатив Нобелийн шагналыг үндэслэгч Якоб фон Уекскулл 2007 онд байгуулсан юм.

2016 оны 10 сарын 26–нд Мэриландын Аннаполисд болсон дэлхийн 16 орны байгаль орчин, боловсролын яамны хууль тогтоогчид ТХБ–ын зохистой дадлын туршлагаа хуваалцах зорилгоор хуран чуулсан Дэлхийн Ирээдүйн Зөвлөлийн олон улсын бага хурлын үр дүнг нэгтгэн дүгнэх үед тогтвортой хөгжлийн боловсролын ололт, амжилтын хүчин зүйлийг нэгтгэн гарын авлага болгох санаа бий болсон байна. Энэхүү баялаг санал солилцооны үр дүнг сайтар тунгаан эрдэм шинжилгээний ба кэйсийн судалгаа, хэвлэлийн тойм (ялангуяа ТХБ–ын чиглэлээрх ЮНЕСКО–ын урт хугацааны, өргөн хүрээг хамарсан ажлын), ТХБ–ын олон улсын шинжээчидтэй хийсэн ярилцлагаар нэмж баяжуулан боловсруулжээ.

Энэ баримт бичиг нь олон нийтэд нээлттэй байршиж байна. Хэвлэн нийтлэгчид нь энэхүү гарын авлагыг аль болох өргөн хүрээнд түгээн дэлгэрүүлэхийг дэмжинэ. Хэрэглэгчид бичгээр зөвшөөрөл авалгүйгээр үүнийг татаж авч, хадгалаад цахим, эсвэл өөр хэл рүү орчуулсан байдлаар түгээн дэлгэрүүлнэ үү. Хэрэв энэ баримтыг түгээх бол зохиогчид болон хэвлэлийн байгууллагуудыг зохих ёсоор дурдана уу.

World Future Council

Dorotheenstraße 15

22301 Hamburg, Germany

Tel: +49 40 3070914-0

Fax: +49 40 3070914-14

Email: info@worldfuturecouncil.org

**ТХБ-ЫН БОДЛОГО, ҮЙЛ
АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ
12 ЗӨВЛӨМЖ**

Тогтвортой хөгжлийн боловсролд хөрөнгө оруулах нь хамгийн сайн хөрөнгө оруулалт юм. Ойролцоогоор найман тэрбум хүнтэй, байгалийн хязгаарлагдмал нөөцтэй энэ дэлхий ертөнцийн бүх хүний хувьд чанартай боловсролоос илүү хүчтэй хувиргагч хүч үгүй байна. Ялангуяа ТХБ нь өөрийгөө болон нийгмээ өөрчлөх чадавхтай болгох арга бөгөөд шүүмжлэлтэй сэтгэх, хувилбар дэвшүүлэх, хамтарсан шийдвэр гаргах, хамтран ажиллах, асуудлыг оновчтойгоор шийдвэрлэх зэрэг суурь мэдлэг, ур чадвар, хандлагаа хөгжүүлэхэд тусалж байна. Дэлхий нийтээрээ 2030 онд тавьсан зорилгодоо хүрэхэд 2015 оноос хэрэгжүүлж эхэлсэн Тогтвортой хөгжлийн зорилт (ТХЗ)–д ТХБ чухал болохыг хүлээн зөвшөөрч байна. ТХБ нь ногоон ажлын байр, уур амьсгалын өөрчлөлт, усны менежмент, засаглал зэрэг асуудлуудад хариу өгч, өөрчлөлт хийх цөм үзэл баримтлал болно.

Дэлхийн Ирээдүйн Зөвлөлийн олон улсын бага хурлын шийдвэр. 2016 онд АНУ-д болсон Дэлхийн Ирээдүйн Зөвлөлийн олон улсын бага хуралд дэлхийн 16 орны байгаль орчин, боловсролын яамны төлөөлөл, хууль тогтоогчид хуран чуулж дараах 12 зөвлөмжийг гаргажээ.

- 1. ТХБ-ын бодлого, үйл ажиллагааны улс төрийн хүсэл зориг.** ТХБ-той холбоотой өсөн нэмэгдэж буй нотолгоонд суурилсан суралцахуйн арга аргачлал болон боловсролын үр дүн нь шийдвэр гаргагчдад хүсэл эрмэлзлэлийг бий болгодог.
- 2. ТХБ-ын хэрэгжилт, институтчилах, зохицуулах тогтолцоог бий болгох.** ТХБ-ын талаарх бодлого, хууль, журмууд нь оролцогч талуудад ТХБ-ыг хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх ач холбогдолтой.
- 3. ТХБ-ын хамтын ажиллагааны түншлэл бий болгох.** Оролцогчдын бүлгүүд, бүсийн экспертийн төвүүд, мэдээллийн хэрэгслийн түншлэлүүд болон ТХБ-ыг түгээх олон янзын арга хэрэгслүүд нь хамтын ажиллагаа, түншлэл чухал болохыг харуулж, цаашид шинээр нэвтэрч, өргөжин тэлэх болно.
- 4. ТХБ-ын хөтөлбөрийг сайжруулах, практикт интеграцчилах.** Судлагдахуун хоорондын уялдааг бий болгоход ТХБ-ыг нийтлэг сэдэв болгон ашиглах; дэлхийн иргэншил, шударга ёс, ёс зүй, байгаль орчин зэрэг тогтвортой хөгжлийн сэдвүүд, хоорондын уялдаа холбоог ойлгоход дэмжлэг үзүүлдэг.
- 5. ТХБ-д нийцсэн хувирган өөрчлөх сургалтын арга зүйг сайжруулах.** Бүлгийн хэлэлцүүлэг, асуудалд суурилсан суралцахуй, шүүмжлэлт уншлага, бичлэг, мэтгэлцээн, алсын хараа тодорхойлох дадлага, дүрд тоглох, танхимаас гадуурх үйл ажиллагаа, загварчлал ба кэйс-ийг судлах зэрэг аргыг өргөн ашиглах.

6. **Багшийн боловсрол болон сургалт, нөөц бүрдүүлэлт.** Багш нар нийгмийн тогтвортой үйл явц нь бодит хувирган өөрчлөлтөд чухал үүрэг гүйцэтгэдэг. ТХБ–той холбоотой багшлахуй, суралцахуйн практик үйл ажиллагааг түгээхэд зайлшгүй шаардлагатай мэдлэг, ур чадварыг багш бэлтгэх сургуулын хөтөлбөр болон багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтад тусгах ёстой.
7. **Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага нь тогтолцооны өөрчлөлтийг бий болгодог.** СБААХ нь тогтолцоог хамарсан өөрчлөлтийг хүчтэй болгодог учраас сургалтын хөтөлбөр, сургуулийн орчин, байгууллагын соёл, сурагчдын оролцоо, экологийн ул мөр, суралцахуйн үр дүн ба олон нийттэй харилцах зэргийг өргөн хүрээнд нь сайжруулах арга зам болно.
8. **Сургуулийн итгэмжлэл урам зоригийг өдөөдөг.** Дагаж мөрдөхөд хялбар, зохицуулалт сайтай, хугацааны хувьд хүрэх боломжтой, хариуцлагын тодорхой хуваарилалттай, уян хатан механизмыг нэвтрүүлэх нь үйл явцыг хурдасгадаг.
9. **Орон нутаг, соёлын онцлогтой, “газар зүйн байршил”-д суурилсан суралцахуй.** Орон нутгийн давуу тал, нөөц бололцоо, тэр дундаа уламжлалт болон уугуул иргэдийн мэдлэгийг ТХБ–ын бодлого, үйл ажиллагааны тулгын чулуу болгох нь зүйтэй. Сургалтын хөтөлбөрийг задалж, тодорхой хэсгийг нь орны нутгийн соёл, түүх, мэдлэгт зориулж, тухайн орон нутагт суурилсан сэдвүүдийг багтааж, гадуурхагдсан үзэл бодол, цөөнхийн ирээдүйг тусгах замаар хөгжүүлэх нь чухал.
10. **ТХБ–ын мониторинг ба үнэлгээ.** ТХБ–ыг нотолгоонд суурилан баталгаажуулахын тулд өгөгдөл, үр дүн шаардлагатай. ТХБ–ыг хянаж, үнэлэхэд инноваци ба кэйсийн судалгаа чухал.
11. **Санхүүжилт ба ТХБ.** Чанартай, хүртээмжтэй, тогтвортой боловсролд хөрөнгө оруулах нь үр ашигтай ч санхүүжилт байнга дутагдаж байна. Үүнийг нөхөхийн тулд дотоодын санхүүжилтээ нэмэгдүүлэх ёстой. Ялангуяа бага болон дундаж орлоготой улс орнуудын хувьд хөгжлийн хамтын нөхөрлөл, донор сангуудын санхүүжилт, олон талт түншлэл, Засгийн Газар хоорондын санхүүжилтийг нэмэгдүүлэх, энэ талаарх инноваци, сайн туршлагаас суралцахыг зөвлөж байна.
12. **ТХБ–ыг 21–р зууны ур чадвар, ажил хөдөлмөр ба тогтвортой эдийн засагтай холбох.** Бүх түвшний сургалтад 21–р зууны ур чадварыг хөгжүүлэх, нийгмийн болон сэтгэл хөдлөлийн суралцахуйгаар дамжуулан тогтвортой эдийн засаг, нийгэмд шилжих хувьслыг дэмжинэ. ТХБ–ыг техникийн ба МБ, Дэлхийн ажиллах хүчний тэн хагас нь ногоон эдийн засагт шилжих шилжилтийн нөлөөнд орж, тогтворгүй хэрэглээ ба үйлдвэрлэлээс зайлсхийхэд чухал үүрэг гүйцэтгэж байгаа нь шинээр гарч ирж байгаа ирээдүйн тогтвортой эдийн засгийн загваруудыг дэмжинэ.

ТХБ-ЫГ ҮНДЭСНИЙ БОДЛОГОД ТУСГАЖ БУЙ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Шинэчлэлтийг өдөр бүр бие даасан суралцагчийн түвшинд, дараа нь сургуулийн хөтөлбөрийн түвшинд мэдэрье гэвэл ТХБ-ын чадавх бэхжүүлэлт, зорилтог санхүүжилт, байнгын хяналт, сайжруулалтын тогтолцоо зэрэг нь бодлогын чиг үүрэгтэй нийцэж байх ёстой. Дэлхийн орон бүр ТХБ-ыг дэмжих дээр шинэ туршлага бий болгожээ.

Англи улс. Экологийн ул мөрөө багасгах, эрчим хүчний үр ашигтай аргыг нэвтрүүлэх, сэргээгдэх эрчим хүчийг суурилуулж чадсан сургуулиуд хэмнэлт гарган, их хэмжээний хөрөнгө бий болгодог сайхан мэдээ байна. Бага CO₂ ялгаруулах, үр ашигтай эрчим хүчний хөтөлбөрт хамрагдсан Нэгдсэн Вант Улсын сургуулиуд дунджаар эрчим хүчний үнийг 14%-аар (£2,600 / €3,000) хэмнэж, зөвхөн эхний жилдээ дангаараа нүүрсхүчлийн хийн ялгарлыг 17 тонноор багасгаж чаджээ. Хэрвээ энэ үр дүнг Англи улсын бүх 24,372 сургуульд хамааруулан авч үзвэл сургууль, боловсролын төсвөөс жилд £66 сая (€76 сая) хэмнэгдэж, 414,000 тонн нүүрсхүчлийн хийнээс зайлсхийж чадна гэсэн үг.

Нэгдсэн Вант Улсад СБААХ-аар ажилласан, ногоон арга барилыг нэвтрүүлсэн сургуулиудад сурах чадвар болон сорилын оноо нь 3–5%-аар нэмэгдэж байгааг тогтоожээ. Тогтвортой боловсролын хэлбэрээр зохион байгуулагдсан сургалтад хамрагдсан сурагчдын дөрөвний нэг нь А–С үнэлгээ авах явдал 5 жилийн хугацаанд 69% байснаа 94% болж нэмэгджээ.

АНУ-ын ногоон сургуулиуд ердийн сургуулиудыг бодвол эрчим хүчийг 33%, усыг 32% бага ашиглаж,

сургуулийн 42 жилийн зардлыг хэмнэж байна. Хэрэв АНУ-ын бүх сургууль, байгууллагууд өнөөдөр ногоон болвол дараагийн 10 жилд нийт эрчим хүчний хэмнэлт нь л дангаараа 20 тэрбум ам доллар (€17,7 тэр бум) болно.

Япон. Япон улсад ТХБ-ын арга хандлага бүхэл бүтэн хотыг хамран өргөжин тэлж байна. Окаямагийн “хот бүхлээрээ ажиллах” арга хандлага нь сургууль, засгийн газар, корпораци, иргэний нийгэмлэгийг багтааж, иргэд, олон нийттэй холбож байна. Долоо хоног тутамд сургуулиудын 3-р ангид ТХБ-ын хичээлүүд орж эхэлдэг ба олон нийтийн сургалтын төвүүд нь ТХБ-ын сургалтыг энгийн хүн амд заадаг. Иргэд орон нутгийнхаа нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор хоол, бүжиг, орон нутгийн түүх болон бусад төслүүдийг хамтарч хэрэгжүүлдэг.

Гаяана. Гаяана улсад ойн нөөцөө тогтвортой ашиглахын тулд (Нүүрстөрөгч багатай хөгжлийн стратеги) (Low Carbon Development Strategy (LCDS))-д нийцүүлэн ТХБ-ыг сургалтад интеграцчилан, сургалтын хөтөлбөрөө шинэчилсэн. Тус улсын газар нутгийн 85 орчим хувь нь хөндөгдөөгүй ойгоор бүрхэгдсэн байдаг. Суралцагчдыг ТХБ-д сургаснаар хууль бус мод бэлтгэл, хангалтгүй ойжуулалт, хууль бус олборлолт, хэт их загас агнуур гэх мэт тогтворгүй туршлагыг засч залруулахад тус болж байна.

Коста Рика. Коста Рика уур амьсгалын өөрчлөлтийн талаарх үндэсний стратегид (2009) “Саармаг нүүрстөрөгч 2021” бодлогыг хэрэгжүүлсэн. Энд ТХБ, уур амьсгалын өөрчлөлтийн боловсролын ур чадварт сургах, иргэдийн ухамсрыг дээшлүүлэх, боловсрол ба соёлын өөрчлөлт хийх зорилго тавьсан юм. Уур амьсгалын өөрчлөлтийн бодлого нь Коста Рикад ТХБ-ыг хэрэгжүүлэх суурь болж байна.

ТХБ-ЫН ХЭРЭГЖИЛТ, ИНСТИТУТЧИЛАХ, ЗОХИЦУУЛАХ ТОГТОЛЦООГ БИЙ БОЛГОХ

Улс орнууд системийг бүхэлд нь ажиллуулах замаар ТХБ-ын хөтөлбөрийг дахин төлөвлөх сургуулийг магадлан баталгаажуулах, соёлын онцлог, “газар зүйн байршил”-д суурилан түгээх замаар амжилтад хүрсэн байна.

ТХБ-ын 10 жилийн хугацаанд олсон ололт амжилтын талаар ЮНЕСКО-оос явуулсан 2013 оны судалгаанд 68 улс оролцсоноос дөрөвний нэгээс илүүтэй нь (29%) ТХБ-д өндөр ач холбогдол өгч, үндэсний хууль тогтоомждоо оруулсан гэж хариулжээ. Казахстан, Морокко, Никарагуа, Швед, Оман, Итали зэрэг улс орнууд сургуулийн өмнөх боловсролоос эхлээд дунд сургууль хүртэл боловсролын байгууллагынхаа сургалтын хөтөлбөрт ТХБ, эсвэл түүнтэй ойролцоо сурган хүмүүжүүлэх арга барилыг нэвтрүүлэх асуудлыг бодлого, хууль тогтоомждоо тусгаж өгчээ.

Финланд. Тогтвортой хөгжил бол соёл, хүүхэд залуучуудын бодлогын хөтөлбөр (2012–2015)-ийн өргөн хүрээтэй сэдвүүдийн нэг бөгөөд идэвхтэй иргэн ба дэлхийн иргэн байхад зөвхөн нийгмийн ба иргэний идэвх хамаараад зогсохгүй хариуцлагатай хэрэглэгч иргэн байх, хүний эрхийг хамгаалах, ялгаварлан

гадуурхахгүй байх ба байгаль орчинд хариуцлагатай хандах асуудлуудыг багтаасан байна. Финланд улс бүх сургуулиуддаа 2010 оны эцэс гэхэд тогтвортой хөгжлийн төлөвлөгөөгөө гаргах шаардлага тавьжээ. Энэ төлөвлөгөөнд ТХБ-ыг хэрхэн хэрэгжүүлэх, төлөвлөгөөнд тусгасан зорилтуудад хүрэхийн тулд сургуулийн өдөр тутмын үйл ажиллагааг хэрхэн өөрчлөх, хэрэгжилтийг хэн хариуцах зэрэг хэд хэдэн түлхүүр асуудлыг оруулсан байна.

ТХБ-ын ийм ижил зорилт, бодлого ба эрх мэдэл Кипр, Молдав, Хорват, Люксембург, Шотланд, Грек, Бүгд Найрамдах Чех улс зэрэг Европын олон улс оронд байдаг ажээ.

Хятад. Боловсролын яам нь ТХБ-ын талаарх анхны удирдамж бодлогоо 2003 онд оруулж ирсэн бөгөөд 2008 оны “Бүгд Найрамдах Хятад Ард Улсын эргэлтийн эдийн засгийг дээшлүүлэх хууль”-д тусгасан шинэ эрх үүрэг (чиглэлүүд)-т тохируулан боловсролын удирдамжаа хүчтэй болгохоор ажиллаж байна. Хөгжлийн эдгээр хуулиудтай холбогдуулан “Байгаль орчны боловсролын удирдамж” ба хичээлийн шинэ хөтөлбөрүүдийг боловсруулж бага, дунд сургуулиудад нэвтрүүлжээ. Үндэсний сургалтын хөтөлбөр, бага, дунд, ахлах ба албан бус боловсрол, иргэний нийгэм, олон нийтийн оролцоо зэрэг холбогдох хэвшлүүдэд үүнтэй ижил ТХБ-ын чиг үүргүүд мөн нэвтэрч байна.

КЭЙС 1: Кипр улсын ТХБ хариуцсан байнгын алба

2004 онд Европын холбоонд орох үедээ ТХБ-ыг үндэсний түвшинд хэрэгжүүлж эхэлсэн ба сүүлийн жилүүдэд ТХБ-ын хөгжлөөр жишиг орон болж хүлээн зөвшөөрөгдөөд байна. Боловсролын Яамнаас 2010 оноос эхлэн ТХБ-ыг сургалтын хөтөлбөрт нэвтрүүлж, ТХБ-ыг шинэчлэлийн хурдасгуур болгон ашиглажээ. ТХБ-ын үндэсний стратеги төлөвлөгөөнд сургалтын бүх байгууллагад сургууль бүхлээрээ тогтвортой арга хандлагаар ажиллахыг үүрэг болгожээ. Энэ нь ТХБ-ын багш нарыг мэргэжлийн хувьд өргөн хүрээнд хөгжих боломжийг олгож, янз бүрийн идэвхтэй түншүүдтэй нягт хамтран ажилласнаар орон нутгийн болон үндэстний хэмжээний оролцоог дэмждэг юм байна.

ТХБ-ын үйл ажиллагааг зохицуулах, биологийн олон янз байдал, уур амьсгалын өөрчлөлт, ТХЗ-ыг үндэсний стратегид үр дүнтэйгээр интеграцчилах боломж олгосон нэг онцлог ажил бол салбар дамнасан дэмжлэг үзүүлэх зохицуулалтыг нэвтрүүлсэн явдал юм.

Боловсролын яамны дэргэдэх ТХБ хариуцсан байнгын алба нь албан, албан бус, чөлөөт гээд сургалтын бүх түвшинд тогтвортой хөгжлийг шингээх зорилготой ажиллаж байна. ТХБ-ын туршлага хуримтлуулсан 19 багш, боловсролын мэргэжилтнээс бүрдсэн энэ алба орон нутгийн ард иргэд, их сургуулиуд, төрийн бус байгууллага ба мэргэжилтний бүлгүүдтэй хамтран ажилладаг ажээ. Энэ албаны ажлын туршлага, зохицуулалт нь Кипр улсдаа ТХБ-ын цогц, урт хугацааны, системтэй стратегийг хэрэгжүүлэхэд тусалж байна.

Канадын Манитоба муж.

ТХБ-ын талаар хатуу бодлого баримталснаар шинжлэх ухаан, нийгэм судлал, эрүүл мэнд ба биеийн тамирын боловсролын сургалтын тодорхой үр дүнг СӨБ-оос эхлээд бүрэн дунд боловсрол хүртэлх сургалтын хөтөлбөрт тусгаж өгчээ.

Сурган хүмүүжүүлэгчид болон сургуулийн удирдлагын чадавхийг нэмэгдүүлэх, түүнчлэн тогтвортой байдлын туршлага, зарчим, хөтөлбөр, түншлэлийг хөгжүүлэхэд санхүүжилтийг зориулах нь анги танхим, үйл ажиллагаа, менежментдээ тогтвортой байдлыг нэвтрүүлэхэд сургуулиудад тусалдаг.

Вьетнам. ЮНЕСКО-ийн Дэлхийн үйлийн хөтөлбөр нь Байгаль орчны ТХБ-ын Үндэсний тогтолцоог боловсруулахад дэмжлэг үзүүлэх ба сургалтын шинэчилсэн хөтөлбөрийн сурах бичгүүдэд ТХБ-ыг тусгах асуудлаар шийдвэр гаргагчдын чадварыг нэмэгдүүлэхээс эхлээд олон замаар ТХБ-ыг амьдралд нэвтрүүлэхэд тусалж байна. Энэ нь сургуулийн өмнөх боловсролоос эхлээд дундаас дээш боловсролын шатны суралцагчдад хамаатай, зайлшгүй шаардлагатай тогтвортой хөгжлийн мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлоход тусалдаг юм.

3

ТХБ-ЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТҮНШЛЭЛ БИЙ БОЛГОХ



Хүн төрөлхтний түүхийн туршид хүмүүс нийгмийн өмнө тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд хамтдаа ажиллаж иржээ. Оролцооны уламжлалын олонх нь нийгэм илүү ярвигтай болохын хэрээр алдагдаж эхэлсэн. Шийдвэр гаргах асуудалд дэлхийн улс орнуудын засгийн газар анхаарал хандуулж, сүүлийн хэдэн арван жилд нийтийг хамарсан шийдвэр гаргах үйл явц дахин сэргэж байна. Энэ үйл явц нь тогтвортой байдлын салшгүй хэсэг бөгөөд нийтийг хамарсан, ардчилсан шийдвэр гаргахад олон нийт эсвэл тэдний төлөөлөгчдийг татан оролцуулах зорилготой юм.

Улс орнуудын (жишээ нь, Шотланд, Голландын) ТХБ-ын бодлогод “Тогтвортой байдлын төлөө суралцахуй” гэсэн ойлголтыг оруулж ирснээр сургалт нь зөвхөн сургуулийн “боловсрол”-оор хязгаарлагдахгүйг харуулж байна.

Боловсролыг “хаана” олгож байгаа нь улам бүр зааг ялгаагүй болж байгаа шиг “хэнд” олгож байгаа нь мөн

ялгаагүй болж байгааг тэмдэглэх нь зүйтэй. Албан, албан бус, амьдрах ухааны боловсрол хоорондоо улам бүр хэлхээ холбоотой болж байна. Жишээ нь, Люксембургт танхимаас гадуур явагддаг ТХБ-ын бүх хичээлүүдийг ТББ явуулдаг болжээ. Үүний нэгэн адил Италид тогтвортой хөгжлийн чиглэлээрх боловсролын ихэнх төслүүдийг орон нутгийн албан бус боловсролын байгууллагууд ТББ-тай хамтран, бүс нутгийн ба орон нутгийн байгууллага, цэцэрлэгт хүрээлэн, их сургууль, орон нутгийн байгаль орчны газрууд болон бусад байгууллагууд хэрэгжүүлж байна.

Чили. ТХБ-ыг албан бус боловсролын хөтөлбөртөө интеграцчилахын тулд иргэний нийгмийн байгууллагууд нь олон янзын арга аргачлал ашиглаж байна. ТХБ-ын санал санаачилгыг зах зээлийн эдийн засагтай уялдуулах мөн иргэдийн оролцоо, олон нийтийг дэмжин туслах, нутаг дэвсгэрийн өвөрмөц байдлыг хөхүүлэн дэмжих зэрэг асуудалд анхаарал хандуулдаг ажээ.

2011 оноос хойш Африкийн экспертийн төвийн сүлжээ жил тутам уулзалт зохион байгуулж, ТХЗ-уудыг хэрэгжүүлэхэд тивийн залуучуудыг чадавхжуулах, инноваци, нөөцийг өргөжүүлэх чиглэлээр ажиллажээ. Европын экспертийн төвүүд мэдлэг, туршлагаа ашиглан байгууллага бүхлээрээ ажиллах арга хандлагыг хэрэгжүүлэн сургуулийг хувирган өөрчлөх, багш, сургагчдын чадавхыг бэхжүүлэх, залуучуудад боломж, эрх мэдэл олгох, бүх шатанд ТХБ-ын хэрэгжилтийг түргэсгэх зэрэг үйл ажиллагаа явуулж байна.

Швейцарь. “Тогтвортой байдлын 7 хоног”-ийг хэд хэдэн их сургуулийн оюутнууд нэгдэн их дээд сургуулиудад тогтвортой байдлыг нэмэгдүүлэх зорилгоор доороос дээш чиглэсэн аргачлал ашиглан зохион байгуулдаг.

Перу. Боловсролын Яам нь “Байгаль орчны боловсролын долоо хоног”, “Байгаль дахь боловсролын өдөр”-ийг ТХБ-ыг сургалтын тогтолцоонд интеграцчилах хөтөлбөрийн нэг хэсэг болгон санаачилжээ. Эдгээр санал санаачилга нь багш нарт байгалийг сургалтын хэрэглэгдэхүүн болгон ашиглах, урам зориг өгөх зорилготой цахим хуудас боловсруулах зэрэг бололцоог олгосон.

ВВС телевиз. “Цэнхэр гариг” цувралын хүрээнд гаргасан нэг удаагийн хуванцар савны талаарх нэвтрүүлгийг авч үзэхэд хэвлэл

4

ТХБ-ЫН ХӨТӨЛБӨРИЙГ САЙЖРУУЛАХ, ПРАКТИКТ ИНТЕГРАЦЧИЛАХ

Суурь боловсролын агуулга, зохион байгуулалт нь төвлөрсөн, нэгэн хэлбэрийн, хүнд сурталт зохион байгуулалттай тогтолцооноос ардчилсан, олон янзын, олон ургальч сургуулийн тогтолцоонд шилжсэнээр олон орны боловсролын систем шүүмжлэлтэй сэтгэх чадвар, үнэт зүйлс ба зан төлөвт анхаардаг болжээ. ТХБ-ын үзэл баримтлал, хичээл, суралцахуйг газар зүй, урлаг, биологи, түүх, байгаль орчин, нийгэм зэрэгт тусган сургалтын хөтөлбөртөө оруулах болжээ.

Зарим орон уур амьсгалын өөрчлөлтийн боловсрол, олон соёлын боловсрол, эрүүл мэндийн боловсрол, энх тайвны боловсрол, хүний эрхийн боловсрол, ХДХВ ба ДОХ-ын боловсрол зэрэг “тусгайлсан” боловсролыг бага ба дунд сургуулиудад оруулах замаар ТХБ-ыг бодлогын үндсэн чиглэл болгон ашиглаж байна. Боловсролын бодлого тодорхойлогчид нийгэм дэх боловсролын хамаарал ба зорилгыг

мэдээллийн хэрэгсэл нь хувь хүний зан байдал болон бодлогыг өөрчлөхөд ямар хүчтэй нөлөө үзүүлж, эерэг өөрчлөлт авчирч болдогийг харуулж байна.

Шотланд. Эдинбургийн Их Сургуулийн дэргэдэх Морэй боловсролын сургууль тогтвортой байдлын боловсрол олгох олон нийтийн нээлттэй онлайн сургалтыг 2015, 2018 онуудад зохион байгуулжээ. Сургалт хувь хүний ёс зүйг хөгжүүлэх, харилцаанд хэрхэн оролцох зэрэг сэдвийг хамарч 170 орны 13,000 хүнийг хамарчээ.



тодорхойлохдоо ТХБ-ыг өргөн хүрээнд оруулж, интеграцчилж, боловсролын бодлого, сургалтын хөтөлбөр, суралцахуйн үр дүн, ур чадвар олгохыг боловсролын бүх шатанд эзэмшүүлэхийг зорьж байна. Энх тайвны боловсролыг жишээ болгон авч үзвэл энэ нь суралцагчдад өөрсдийн амьдрал, нийгэм, бүр цаашлаад дэлхий дахинд бий болж буй зөрчлүүдийг ойлгож, өөрчлөхөд тусалдаг. Дэлхий даяарх сургууль завсардсан хүүхдүүдийн 50% нь мөргөлдөөнтэй

улс оронд амьдарч байгаагаас харахад энх тайван тогтоох, түүнийг бэхжүүлэх хүчин чармайлт нь боловсролд маш их хамаатай юм.

Йордан. ТХБ-ыг бага боловсролын шинжлэх ухааны хичээлийн сургалтын хөтөлбөрт, бусад судлагдахуунд тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг интеграцчилсан байна.

Малайз, Филлиппинд ТХБ-ыг уламжлалт бүх хичээлийн бүрэлдэхүүнд оруулах чиглэл барьж байна. Хятадад биологи, физик, түүх, газар зүй, хими зэрэг судлагдахуунд ТХБ-ыг сэдэв болгон сургалтын хөтөлбөрт оруулж байна.

Колумб, Чили, Гватемал, Мексик зэрэг орнууд байгаль орчин ба тогтвортой хөгжлийн сэдвүүдийг бага болон суурь боловсролын түвшинд иргэний боловсролын сургалтын хөтөлбөртөө оруулсан байна. Хэдийгээр “нэмэлтээр оруулах”, эсвэл хичээлд нэгтгэх арга барил нь нэмэр болох ч сургалтын хөтөлбөрийг интеграцчилах нь илүү гүнзгий үр нөлөөтэй юм.

Шинэ Зеланд. Судлагдахуун хоорондын хамааралтай нийтлэг сэдвүүдийг судлах нь ирээдүйн асуудлуудыг шийдвэрлэх, суралцахуйн хүрээ болон үнэт зүйлсийн хоорондын холбоог бий болгож, суурь цогц чадамжийг хөгжүүлэхэд хувь нэмэртэй гэж үзэж байна.

Кипр. ТХБ-ын сургалтын хөтөлбөрийн бүтэц нь судлагдахууны дагуу зохион байгуулагдаагүй боловч судлагдахуун хоорондын хамааралтай нийтлэг 12 сэдэв (ой мод, эрчим хүч, ус, хог хаягдлын менежмент, хотын хөгжил, үйлдвэрлэл ба хэрэглээ, цөлжилт, тээврийн систем, ядуурал, соёл ба байгаль орчин, биологийн төрөл зүйл ба аялал жуулчлал)-ийг багтаадаг.

Шинэ Зеланд. Засгийн Газар сургуулиудад зориулан “Энх тайван судлалын удирдамж” гарган 1987 оноос “Энх тайван ба зэвсэглэлгүй байх боловсролын сан”-г байгуулж энх тайвны боловсролыг үндэсний болон олон улсын хэмжээнд хэрэгжүүлж ирсэн. Сургалтын хөтөлбөр, албан бус сургалтаар дамжуулан үл хүчирхийлэл, шударга ёс, энх тайванч шийдэл, туршлагыг өнөөдөр ч үргэлжлүүлэн түгээж байна.

Финланд. Финландад тогтвортой байдлын асуудлууд нь чадвартай, өөртөө итгэлтэй “тогтвортой амьдралын хэв маягийг баримталдаг байгальд ээлтэй иргэн” бэлтгэх сургалтын чухал хэсэг гэдгийг хүлээн зөвшөөрчээ. 2006 оноос эхлэн суурь боловсролын цөм хөтөлбөрт онцолсон 7 сэдвийн нэгэнд тогтвортой хөгжлийг оруулж улмаар 2016 оны шинэчилсэн хөтөлбөртөө ТХБ-ын үүргийг өргөн хүрээнд оруулсан. “Тогтвортой ирээдүйг бүтээх” судлагдахуун хоорондын ур чадварыг бүх хичээлдээ оруулжээ. Сургуулийн соёлыг эко-нийгмийн хүрээнд хөгжүүлэхээр зорьж, сургууль байгаль орчны хариуцлагатай, ирээдүйд чиглэсэн сургалтын орчны үлгэр жишээ болгохыг зорьж байгаа юм.

КЭЙС 2: МАНИТОБА: Суралцагчдыг тогтвортой амьдралд бэлтгэж байгаа нь

Канадын Манитоба муж ТХБ-ыг сургалтын бодлого, сургалтын хөтөлбөр, арга зүй, чадавх бэхжүүлэх хүрээнд хэрэгжүүлсэн анхны мужуудын нэг юм. 2009 онд Боловсрол, ахисан шатны сургалтын яамныхаа хэтийн зорилгод тогтвортой байдлыг тусгаж, “Манитобагийн боловсрол нь суралцагчдыг тогтвортой хэв маягаар амьдрах туршлагатай болоход нь дэмжлэг үзүүлэх” гэж тодорхойлжээ.

ТХБ-ыг цэцэрлэгээс эхлээд 12-р анги хүртэлх сургалтын хөтөлбөрт интеграцчилж, байгалийн ухаан, нийгэм судлал, эрүүл мэнд, биеийн тамирын боловсрол бүрд суралцахуйн зорилгыг тодорхойлон гаргажээ. Боловсролын байгууллагууд, төрийн байгууллагуудын ахлах ажилтнуудаас бүрдсэн “ТХБ-ын Манлайллын зөвлөл” нь ТХБ-ын үйл ажиллагааны 3 жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зөвлөмжөөр хангадаг байна. Муж даяар багш болохоор суралцаж буй болон багшаар ажиллаж буй багш нарын ТХБ-ын талаарх ур чадварыг дээшлүүлэхэд анхаардаг. ТХБ-д зориулсан санхүүжилт нь тогтвортой байдлын үйл ажиллагаа, хөтөлбөр, түншлэлийг хөгжүүлэх, үүнийг цаасан дээрээс практик үйл ажиллагаанд шилжихэд тусалдаг байна.

5

ТХБ-Д НИЙЦСЭН ХУВЬСАЖ БУЙ СУРГАЛТЫН АРГА ЗҮЙГ САЙЖРУУЛАХ



Танхимаас гадуурх туршилт нь арван минут сургуулийн талбайд гарахаас эхлээд онгон зэрлэг байгаль, орон нутгийн музейд хагас өдөр аялах гээд маш олон янз байх ба туршлага бүр суралцагчдад шинэ зүйлийг хийх, түүнээс суралцах сайхан боломжийг олгодог юм. Байгаль дахь дадлага нь суралцагчдын сэтгэл хөдлөлд нөлөөлж, тогтвортой хөгжлийн ярвигтай талыг ойлгоход чухал үүрэг гүйцэтгэж, шүүмжлэлт сэтгэлгээг нь хөгжүүлэхэд тусална.

Байгальтай ойр байх нь эрүүл мэнд ба сайн сайхан аж байдал, бие бялдрыг нь сайжруулах, нийгэм ба сэтгэл хөдлөлийн ур чадварыг нь хөгжүүлэх, сургалтын үр дүнг сайжруулах зэргээр хүүхэд насны эрүүл саруул хөгжилд чухал нөлөө үзүүлнэ. Их Британийн “Mind” буяны байгууллага нь бие бялдрын хувьд идэвхтэй байх нь сэтгэцийн эрүүл мэндэд тустайг онцолсон судалгааг нийтэлсэн бөгөөд байгальд байх нь стрессийг бууруулж,

эрүүл мэндэд тустай төдийгүй тэсвэр тэвчээрийг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг гэжээ.

2017 онд 45 орны багш нарын дунд хийсэн хоёр төрлийн судалгаагаар ихэнх багш нар байгальд сургалт явуулах сонирхолтой байгаа тухай мөн түүнээс мэдэрсэн ашиг тусыг тоочжээ. Үүнд:

- Багш нарын 87% нь гадаад орчинд илүү олон цагаар хичээл орох сонирхолтой байна.
- Хичээлийн өдрийн турш гадаа тоглох, суралцах нь хүүхдүүд ур чадвараа хөгжүүлэхэд чухал байна гэж багш нарын 97% нь үзжээ.
- Багш нарын 89% нь хүүхдүүд байгальд хичээл орсны дараа илүү аз жаргалтай болж байна гэжээ.

Шинэ Зеланд. Танхимаас гадуурх сургалтыг эрүүл мэнд, биеийн тамирын хичээлүүдэд оруулсан байна. Сурагчдыг ангиас гаргахад багш нарт дэмжлэг

үзүүлж, зөвлөмж, арга хэрэгсэл, үйлчилгээ үзүүлэгчийн хаяг, эх сурвалж бүхий өргөн хүрээний вэб сайтаар дамжуулан дэмжлэг үзүүлдэг.

Скандинавын орнууд. “Байгаль дахь амьдрал” нь сургуулийн үйл ажиллагаанд түгээмэл үзэгдэл болж байна. 1960–аад оны эхээр дэлхийд анх удаа танхимаас гадуурх сургалтыг албан ёсны болгосон Шотланд орон энэ чиглэлдээ анхдагч нь болдог. Энэхүү манлайлал нь 2010 онд хэвлэгдсэн “Байгаль дахь сургалтын хөтөлбөр” боловсруулснаар үргэлжилсэн нь олон улсын хэмжээнд сургалтын хөтөлбөрийн зорилтыг байгаль дахь сургалттай холбосон анхны албан баримт бичиг болсон юм. Улмаар Шотландын Засгийн Газрын “Шотландад боловсрол эзэмшиж байгаа бүх хүүхдийг төлөвлөгөөтэй, чанартай байгаль дахь сургалтад хамруулах” ёстой гэсэн бодлогоор үргэлжилсэн. Германы ойн цэцэрлэг ч олон улсад алдартай жишээ болж байна.

6

БАГШИЙН БОЛОВСРОЛ БА СУРГАЛТ, НӨӨЦ БҮРДҮҮЛЭЛТ



Багш бэлтгэх байгууллагууд чанартай боловсрол, ТХБ–ыг бүх түвшинд түгээх хариуцлагыг боловсролын бодлого, үйл ажиллагаандаа өргөн нэвтрүүлж байна. Багш бэлтгэх сургалт, багшийн дээд сургуулиудад мэргэжлийн шинэчлэгдсэн стандарт, боловсролын салбар, факультетийн хэтийн зорилгыг тодорхойлоход ТХБ–ыг оруулах, ТХБ–ын шинэ хичээл нэмэх, гэрчилгээ ба зэрэг олгох хөтөлбөрүүдийг нэвтрүүлж байна.



Барбадос, Малайз, Монтенегро. ТХБ–ыг багшийн сургалтын бүрэлдэхүүн хэсэг болгон бэхжүүлэх, ТХБ–ыг заах тусгай удирдамж боловсруулах зэрэг аргаар ТХБ–ыг интеграц хэлбэрээр заахад үүсч буй тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэж байна.

Бельги, Этиоп, Швед. ТХБ–ыг багшийн боловсролын хөтөлбөрт заавал оруулах заалттай юм байна.

ТХБ-д тууштай хандаж, боловсролын өндөр амжилт үзүүлдэгээрээ хүлээн зөвшөөрөгдсөн

Финланд, Канад улсын аль аль нь өндөр боловсролоос гадна багшлах ажилд тохирох, эсэх болон сурагчдын сурах сэдлийг нь төрүүлж өгдөг бэлтгэл сургалтуудыг маш нарийн чанд явуулдаг ажээ.

Шотланд. Мэргэжлийн заах аргын стандартуудаа 2012 онд шинэчлэхдээ тогтвортой байдлыг гол стандартын нэг болгон оруулсан бөгөөд түүгээрээ багш нараа магадлан итгэмжилдэг ажээ. “Мэргэжлийн үнэт чанар ба стандарт”-д “Тогтвортой байдалд суралцах”-ыг оруулж, бүртгэлтэй бүх багш нар, боловсролын ажилтнууд нь албан тушаалын зэрэг дэвээс үл хамааран дадлага туршлагаа үзүүлэх/шалгуулах ёстой гэжээ. Энэ нь Шотландын багш нарын ерөнхий зөвлөлийн хэрэгжүүлсэн чухал дэвшилтэт ажил бөгөөд мэргэжлийн бүх багш нар ажилд орохоосоо өмнө болон ажлаа хийж байх үедээ мэргэжлээ дээшлүүлж байхыг үүрэг болгосон байна.

Зимбабве. Засгийн газар нь ТХБ-ыг гол чиглэл болгохын тулд түүнийг “Багшийн мэргэжлийн стандартуудын гарын авлага”-д оруулсан ба энэ баримтыг ажилд томилогдохоос өмнөх багш нарын сургалтад ашигладаг юм байна. Эдгээр стандарт нь багш нарыг ubuntu/hunhu философийг анги, цех, туршилтын талбайд хэрхэн ашиглах (хамтран ажиллах, хуваалцах, оролцох ба олон

КЭЙС 3: ЯМАЙК. ТХБ-ын төслүүдээр дамжуулсан багшийн боловсрол

Ямайкын Монагийн Вест Индианы Их Сургуульд “Тогтвортой хөгжлийн боловсрол, уран зохиол”-ын хичээл хэлний боловсролын төгсөлтийн дараах хөтөлбөрт үндсэн хичээл, багшийн боловсролын төгсөлтийн дараах хөтөлбөрт сонгон суралцах хичээл болж ордог юм байна. Тогтвортой хөгжлийн ойлголт, чиг хандлага, зарчимтай танилцуулах, тогтвортой дэлхий ертөнцийг бүтээхэд ТХБ-ын гүйцэтгэх үүргийг судлах боломжийг оюутнуудад олгоход энэ хичээлийн зорилго оршино. Энэ хичээл нь 3 зүйлээс бүрдэнэ. Үүнд:

1. Оюутнууд орон нутгийн ба дэлхий нийтийн тогтвортой хөгжлийн тулгамдсан асуудлыг судлахад мөрдлөг болгох дэлхий нийтийн чиг хандлага
2. Уран зохиолын судалгаа нь нинжин сэтгэлийг хөгжүүлэх, оюутнуудад хамтын нийгэмлэгийн мэдрэмжийг өгөх, үнэт зүйлсийг тодруулах, тогтвортой байдлыг олон талаас нь ойлгох, тэднийг үйлдэл хийхэд өдөөх хэрэгсэл болно.
3. Олон нийтийн үйл ажиллагааны хөтөлбөрт нэгдэх. Гол даалгавар нь тогтвортой байдлын сорилтуудыг олон нийтийн орчин руу чиглүүлэх шаардлагыг оюутнуудад тавина. Цөөхөн хэдээс нь нэрлэвэл оюутнууд хүчирхийлэл, ядуурал, байгаль орчны доройтлын асуудлыг энх тайвны төсөлтэй холбох, орон гэргүй хүмүүстэй ажиллах, сургуулийн цэцэрлэгжүүлэлт, зөгий үржүүлэх зэрэг асуудлаас сонгоно. Бодит ертөнцийн асуудалд анхаарал хандуулах, олон нийтгүйгээ ойр дотно ажиллахдаа оюутнууд ТХБ-ын гол зарчим, арга замыг судалж, эргэн тойрныхоо амьдралаас сурах зүйл, мөн амьдралын чанарыг сайжруулахад хэрхэн тусалж чадахаа ойлгож авна.

нийтийн сонирхолд ТХБ-д ээлтэй байдлаар хандах) удирдамжаар хангадаг ажээ.

Швейцарь. Их сургууль, техник мэргэжлийн боловсролын сургуулиудад магадлан итгэмжлэлд орох шаардлага тавьдаг. Таван жил хэрэгжиж байгаа энэ үйл ажиллагааны дүнд тогтвортой

байдлын асуудал багш нарыг сургадаг дээд сургуулиуд, ордог хичээлүүдийн аль алиных нь гол чиглэл болжээ.

Хятад, Пакистан. Багш нарыг бэлтгэдэг их, дээд сургуулийг магадлан итгэмжлэх стандартдаа тогтвортой байдлын элементүүдийг оруулжээ.

7

“СУРГУУЛЬ БҮХЛЭЭРЭЭ АЖИЛЛАХ АРГА ХАНДЛАГА” ТОГТОЛЦООНЫ ӨӨРЧЛӨЛТИЙГ БИЙ БОЛГОХ



СБААХ нь ТХБ-ыг сургалтад интераграцчилах механизм бөгөөд өдөр тутмынхаа үйл ажиллагаагаар тогтвортой хөгжлийн үлгэр дууриал болж ажиллахад чиглэгддэг. СБААХ нь юуг заасан, хэрхэн заасан, асуудлыг шийдвэрлэж зохицуулсан арга зам, биет барилга, байшин, хөрс, орон нутгийн байгаль орчин, сургалтын хөтөлбөрөөс гадуурх арга хэмжээ, иргэд олон нийттэй харилцах гэх мэтийг нэгтгэдэг. Энэ нь байгууллагыг бүхэлд нь нийгэм ба олон нийтийн хэрэгцээнд нийцсэн шинэчлэгч, ардчилсан, байгаль орчин руу хандсан чиглэлд баримжаатай болгох зорилготой.



Шинэ Зеланд, Хятад. ТХБ-ыг бага ба дунд шатны боловсролдоо нэвтрүүлэхдээ сургууль бүхлээрээ ажиллах арга хандлагыг анхдагч арга болгон ашиглаж байна. Европын эдийн засгийн НҮБ-ын хороо (UNESCO)-д багтдаг Европын бүс нутаг, Хойд Америк, Төв ба Баруун Ази, гишүүн улсуудын 76% нь ТХБ-ын сургууль бүхлээрээ ажиллах арга хандлагыг боловсролын тогтолцоондоо нэвтрүүлж байна.

Суралцагчид зан харилцааны өөрчлөлтийн толь (нүд, чих) болдог учраас сургууль тэднийг дэмжих үйл ажиллагаа, системийг бий болгох хэрэгтэй. Эко-сургууль хөдөлгөөний хүрээнд суралцагчдаар манлайлуулсан өөрчлөлт, эрх мэдлийг хуваарилахын ач холбогдол зэргийг шийдвэрлэж болно.

Жимс, хүнсний ногоо ургуулах нь эрүүл хооллолт, фотосинтез зэрэг биологийн олон үйл явцын талаар хичээл заахад ногоон төслийг түгээмэл ашиглаж байна.

Мэрилэнд, Шотландын сургуулиуд. Суралцагчдаа бизнес эхлүүлэх, эрхлэхэд нь сургах зорилгоор хүнсний ногооны тариалан, тахианы жижиг аж ахуйгаа ашигладаг ажээ. Ийм маягаар үйлдвэрлэсэн өндөг, чанамал зэргээ орон нутгийн дэлгүүрт худалдаж, данс хөтлөх, удирдах зэрэг ажлыг оюутнууд өөрсдөө хийдэг юм байна.

Франц. Хамтаараа хэрэгжүүлдэг “Хотхоноо ногооруулах” хүчин чармайлт мөн ихээхэн нөлөө үзүүлнэ. Парист 2017 онд 50°C хүртэл онцгой халснаас болж сургуулиа хэдэн өдрөөр хааж байжээ. Одоо Оазис төслийн хүрээнд хотын бүх 800 сургуулийн хотхоныг “Арлын сэрүүн”-ийг мэдрэх орчин болгон хувиргах төлөвлөгөө гаргажээ.

Канадын Манитоба муж. Хотхоныг ногооруулах ажил мөн хийгдэж байгаа ба “Эрчим хүч, байгаль орчны дизайны

манлайлал” (Leadership in Energy and Environmental Design (LEED)) стандартыг шинэ сургууль барих, хуучин сургуулийг боловсронгуй болгож өөрчлөхдөө ашиглаж байна. Гадаа сургалт явуулах орчин бүрдүүлэх ба экологид ээлтэй тоглоомын талбай бий болгох санхүүжилтийг бүх сургуульдаа өгчээ.

КЭЙС 4: Индонези, Балигийн ногоон сургууль

Сургуулийн орчныг “Суралцагчдад ээлтэй” болгосон үлгэр жишээ загвар сургууль бол Индонезийн Балигийн Ногоон Сургууль юм. Сургууль нь “ханагүй, байгалийн орчинд нийгэмд нэгдсэн, энтерпренёр сургалт явуулах замаар тогтвортой байдлын боловсрол олгох” зорилго тавьжээ. Балигийн ногоон сургууль нар, уснаас өөрийн хэрэглээний эрчим хүчээ гаргадаг. Тэд ялзмагжуулдаг жорлон ашиглаж, тогтвортой таримал хүнсээ ургуулж, үртгээр галлаж хоолоо болгон, 100% байгалийн материалаар хийсэн тавганд хийж үйлчилдэг юм байна. Сургуулийн доторх ба эргэн тойрон дахь бүх хайс, хашааг ногоон материалаар хийжээ. Ангиуд нь ханагүй, багш нар нь хулсан самбар ашиглаж, эсвэл машины салхины хуучин шилний цаад талд нь цаас тогтоон цагаан самбар болгон ашигладаг юм байна. Сургууль суралцагчдаа ногоон манлайлын чиглэлээр урамшуулж, чадваржуулахын тулд төвлөрсөн цогц арга барилыг ашигладаг ажээ.

Балигийн ногоон сургууль бол судлах, сурах, эрэл хайгуул хийх газар бөгөөд сургууль бүхлээрээ ажиллах арга хандлагыг үйл хэрэг болгосны хамгийн анхны жишээ юм.

СУРГУУЛИЙН ИТГЭМЖЛЭЛ НЬ УРАМ ЗОРИГИЙГ ӨДӨӨДӨГ



Итгэмжлэх буюу хүлээн зөвшөөрөх тогтолцоо нь сургуулийн хотхон, сургалтын хөтөлбөр, сургуулийн соёлд өргөн хүрээтэй өөрчлөлт оруулах нэгэн хөшүүрэг юм. “Тогтвортой сургууль”, “Эко-сургууль”, “Цэвэр сургууль” гэх мэт системтэй өөрчлөлт хийх нь сургуулиудад хүсэл зорилгоо бодит зүйл болгоход тусалдаг юм.

Эко-сургууль

Эко-сургууль бол 67 орны 19,5 сая хүүхдүүдийг нэгтгэж, тогтвортой байдлыг бий болгохоор ажиллаж байгаа хэдэн арван мянган сургуулийг итгэмжилсэн томоохон хөтөлбөрийн нэг юм.

Эко-сургуулийн хөтөлбөр биологийн олон янз байдал, эрчим хүч, далайн байгаль орчин, хаягдал, дэлхийн иргэншил, эрүүл амьдрал, сургуулийн газар, тээвэр, хог, ус зэрэг сэдвийн хүрээнд сургалт, үйл ажиллагааг хамардаг юм. Оролцож буй сургуулиуд Ногоон дарцаг шагналыг авахын тулд долоон үе шаттай тодорхойлогдсон үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.



Эко-сургууль

Ногоон дарцаг гардах амжилтын 7 үе шат

ЮНЕСКО–ийн Хамтын ажиллагаатай сургуулиудын сүлжээ (ASPnet)

Хамтын ажиллагаатай сургуулиудын сүлжээ нь олон улсын ойлголцол, энх тайван, соёл хоорондын харилцан яриа, тогтвортой хөгжил, чанартай боловсролыг дэмжих чиглэлээр дэлхийн 182 орны 11 500 боловсролын байгууллагыг нэгтгэдэг юм. Хүмүүнлэг, ёс зүйтэй, соёлтой, олон улсын хэмжээний боловсрол олгох сургуулийн амлалт ба албан ёсны хяналт дээр үндэслэн гишүүнчилж баталдаг.

Сүлжээ нь гурван нэмэлт арга барилыг хэрэглэдэг. Үүнд:

1. **Бүтээх:** Инноваци шингэсэн сургалтын материалыг хөгжүүлэх, турших, дэлгэрүүлэх ба заах, сурах шинэ арга барилыг дэмжих
2. **Заах ба сурах:** Ур чадварыг бүтээх шинэлэг арга зүй ба тодорхой сэдвүүдийг сурах аргууд нь сургуулийг орчиндоо үлгэр жишээ болох боломжийг олгох.
3. **Харилцан үйлчлэх:** Сургууль, хувь хүн, олон нийт, шийдвэр гаргагчид болон нийгэмтэй мэдлэг, туршлага, зохистой дадлаа хуваалцан холбогдох боломжийг оролцогчдоо олгох.

9

ОРОН НУТАГ, СОЁЛЫН ОНЦЛОГТОЙ, “ГАЗАР ЗҮЙН БАЙРШИЛ”-Д СУУРИЛСАН СУРАЛЦАХУЙ



Орон нутгийн давуу тал, нөөц бололцоо, тэр дундаа уламжлалт болон уугуул иргэдийн мэдлэгийг ТХБ-ын бодлого, практикийн үндэс суурь болгох нь эмзэг байдлыг бууруулах ба нийгмийн уян хатан байдлыг бий болгоход боловсрол чухал үүрэг гүйцэтгэнэ. Жишээ нь, далайн түвшин нэмэгдэх, ойгүйжих, хууль бус уул уурхай зэрэг эрсдэл ихтэй

улсууд Гаяана ба Доминиканы Бүгд Найрамдах Улсад хэрэгжүүлсэнтэй адилаар сургуулийн тогтолцоондоо хэрэгжүүлж буй “цөлжилтийн эрсдлийг бууруулах”, “уур амьсгалын өөрчлөлтийн боловсрол” хөтөлбөрүүдийн ашиг тусыг хүртэж болно.

Бутан, Гватемал, Замби. Эдгээр улсын орон нутгийн соёлын дадал, итгэл үнэмшил нь ТХБ-ын практиктай хэрхэн сүлжилдэж байгааг харуулж байна. Зүүн болон Зүүн өмнөд Азийн хэд хэдэн улс шиг орон нутгийн болон соёлын асуудлыг хамрахын тулд сургалтын хөтөлбөрийн тодорхой хэсгийн төвлөрлийг сааруулах арга хэлбэрийг хэрэгжүүлж байна. Үүнийг хэрэгжүүлэх хамгийн үр дүнтэй арга бол орон нутгийн бодлогын түвшинд уян хатан хэрэгжүүлэхүйц арга хэмжээ авах явдал юм.

Тайланд, Хятад, Индонези, Вьетнам. Эдгээр улс сургалтын орчинг практик, бодит байдал руу тэлэх ба ард иргэдийн

оролцоог нэмэгдүүлэхийн тулд үндэсний сургалтын хөтөлбөрийн төвлөрсөн бус, газарзүйн байршилд суурилсан бүрдэл хэсгийн үзэл санааг дэлгэрүүлэн нэвтрүүлжээ.

Индонез. “Боловсрол, хөгжил, эрх мэдлийн төлөө төв”-ийг улс орон даяараа байгуулсан байна. ТХБ-д тусгайлан төвлөрсөн эдгээр төв нь газар зүйн байршилд суурилсан сургалтын модуль ба сургалтын материал боловсруулах замаар багш, сурган хүмүүжүүлэгчдэд гол дэмжлэгийг үзүүлдэг ажээ.

Хятад. Сургалтын нийт цагийн 10%-ийг орон нутгийн тэргүүлэх чиглэлд суурилсан байдлаар өөрсдөө тодорхойлох боломжийг сургуулиуддаа олгожээ. Олон сургуулиуд “ТХБ-ын дөрвөн зүйл: Бүгдийг хүндэтгэх, Соёлын олон янз байдлыг хүндэтгэх, Байгалийг хүндэтгэх, Шинжлэх ухааныг хүндэтгэх” сэдвүүдийг ашигладаг олон нийтийн сургалтын хөтөлбөрөөр дамжуулан ТХБ-ын гол үнэ цэнийг шингээхээр сонгосон байна.

Замби. Гар урлал ба урлагийн бүтээл нь соёлын өвөрмөц байдал, бизнес эрхлэлтийг дэмжих боломжийг бий болгож байгаа учраас орон нутгийн ард түмний уламжлал ба гар урлал нь албан ба албан бус боловсролын сургалтын процессын нэг хэсэг болж байна.

Гватемал. Маяагийн уламжлалт мэдлэгийг инженерчлэл, одон орон зэргийг сургалтын хөтөлбөрт оруулах, түүнийг олон нийтийн оролцоотой хамгаалахад ТХБ-ын дэмжлэгийг бий болгох чиглэлээр ажилладаг боловсролын сүлжээ үйл ажиллагаагаа явуулж байна.

КЭЙС 5: Тайланд улсын орон нутгийн ТХБ-ын сургалтын хөтөлбөр

2008 оноос хойш Тайландад ТХБ-ыг нэвтрүүлсэн 5 арга замын нэг бол нийт сургалтын хөтөлбөрийн хичээлийн 30% төвлөрсөн бус, орон нутгийн сэдэвтэй байна гэсэн заалтыг нэвтрүүлжээ. Хичээл болон заах арга нь тухайн орон нутгийн нөхцөл байдалд тохирсон сэдвүүдийг хөнддөг бөгөөд ихэнхдээ тогтвортой амьдралын хэв маягийн асуудлууд ба “хангалттай байх эдийн засгийн” философи, тогтвортой хөгжлийн орон нутгийн тайллыг багтаадаг ажээ. Орон нутгийн сургалтын хөтөлбөр нь Тайландын алслагдмал хойд хэсэгт орших уулын сууринд байдаг Бансунконг Сургуультай ижил сургуулиудад сурагчдын 90% нь харьяалагддаг. Аха (Akha) үндэстний уламжлалт мэдлэг, зан үйлийг ашиглах боломжийг олгодог юм. Энэ туршлагыг сургуулийн хэрэглээний хөдөө аж ахуйн шинжлэх ухааны хөтөлбөрүүдэд орон нутгийн тогтвортой байдалтай холбоотой асуудлуудын шийдлийг боловсруулах зорилгоор хэрэглэдэг юм байна. Сургууль мөн урлагийн талын хичээлүүдээрээ дамжуулан Ахагийн соёлын өвд анхаардаг учраас олон нийтэд хүрэх үр дүн нь нэмэгддэг ажээ. Сургуулийн олон нийтийн сургалтын нэгдсэн төвд жилийн турш үргэлжлэх ТХБ-д суурилсан хичээлээс гадуурх үйл ажиллагаа нь сурагчид болон орон нутгийн иргэдэд хүртээмжтэй байгаа нь Бансунконг бүх насны хүмүүст зориулсан “амьдралын их сургууль” болон жинхэнэ соёлын төв болж байгааг харуулж байна.

КЭЙС 6: Японы сургуулиуд орон нутгаа дэлхий дахинтай холбож байна

Япон улс салбар бүрийн боловсролыг ТХБ-той холбон өөрчлөх замаар 2011 оны газар хөдлөлт зэрэг аюултай гамшгийн эсрэг хариу арга хэмжээ авч байна. Японы Айчи мужид орон нутгийн нүүрс хүчлийн хийн концентрацийг хэмждэг болох замаар уур амьсгалын өөрчлөлтийн тухай ойлголтоо гүнзгийрүүлэхэд нь тусалж байна.

Суралцагчид сургуулийн орчны талбайд нүүрс хүчлийн хий байгаа эсэхийг индикатор ашиглан хэмжиж, хүлэмжийнхийн түвшин хэлбэлзлэлтэй байгааг тогтоодог ажээ. Олон машины утаа их ялгардаг гудамжны ойролцоо энэ хий их, ургамалжилт сайтай газар хий бага байгааг хараад сурагчид уур амьсгалын өөрчлөлтөд оролцдог нэгэн хүчин зүйлийн талаар болон фотосинтез ба ногоон ургамал нь түүний үр нөлөөг бууруулахад үүрэг гүйцэтгэдэг тухай мэдэж авдаг. Энэ бол өөрийн хүрээлэн буй орчноосоо цуглуулсан өгөгдлийг ашиглан залуу хүмүүсийг дэлхийн ирээдүйн байгаль орчны асуудалд санаа тавьдаг болгож байгаагийн сонгодог жишээ юм. Ийм маягийн туршилт нь ноцтой асуудалд бие дааж, эсвэл хамт олноороо хэрхэн хандах, ажиллах талаарх шинэ ойлголтыг суралцагсдад олгодог. Тайван, эх газрын Хятадад энэ аргыг одоо мөн хэрэгжүүлсэн байна.

10

ТХБ-ЫН МОНИТОРИНГ БА ҮНЭЛГЭЭ ХИЙХ



Дэлхийн улс орнуудын засгийн газар нь тухайн улсын болон олон улсын доноруудын хэрэгжүүлсэн боловсролын бодлогын үр дүнгийн хүрээнд хариуцлага хүлээх явдал нэмэгдэж байгаа учраас боловсролын хяналт, шалгалт, үнэлгээ сүүлийн 10 жилд хурдан өргөжин тэлж байна. Дэлхийн 72 орны 15 настай 1,5 сая хүүхдийг хамруулан хийсэн гурван жил тутмын PISA (сурлагын амжилтын олон улсын үнэлгээ) зэрэг үнэлгээнд ТХБ-ын асуудлуудыг оруулж эхэлж байна.

2006 оны судалгаа нь шинжлэх ухааны боловсролд чиглэж, сургуулийн сургалтын хөтөлбөрт байгалийн шинжлэх ухааны сэдвүүдийг оруулсан талаарх мэдээллийг цуглуулжээ.

КЭЙС 7: ДАНИ. ТХБ–ын сургалтын салбар дундын үнэлгээ

Дани улсад Боловсролын яамнаас ТХБ–ыг олон салбар, хөтөлбөрүүдэд нэгтгэх хүчин чармайлт гаргасны дүнд зарим шинэлэг хөндлөнгийн үнэлгээний аргуудыг боловсруулж, нэвтрүүлсэн байна. 2016 оны байдлаар, суралцагчид 9–р ангиа төгсөхдөө салбар дундын шинжлэх ухааны шалгалт өгдөг ба тогтвортой байдалтай холбоотой шинжлэх ухааны асуудлуудыг боловсруулах, бие дааж болон баг бүлгээр асуудлыг задалж, судлахын тулд биологи, физик, хими, газарзүйн холбогдох туршилт, асуудлыг шалгалтад ашигладаг. Үнэлгээний энэ арга нь ТХБ–той холбоотой салбар дундын шинжлэх ухааны 6 чиглэл (байгалийн нөөцийн тогтвортой хэрэглээ, тогтвортой эрчим хүч, технологи, хүний эрүүл мэнд ба үе хоорондын асуудал гэх мэт)–ийг хоёр жил судалсны дараа гарч ирсэн ба салбар дундын ТХБ–ын мониторингийн асуудлыг шийдвэрлэхэд урт замыг туулж байна.

зарцуулсан байна. Нөгөө талаас бага ба дунд орлоготой орнууд ДНБ–ий 4–6% гэсэн Инчеоны тунхаглалын дээд хэмжээнд хүрэх, эсвэл түүнээс давуулах зорилт тавьж байна. Хэрэв шаардлагатай хэмжээнд сайжруулья гэвэл зардлын 15–20%–ийг дотоодын ба гадаадын санхүүжилтэд тусгах ёстой.

Бага ба дунд орлоготой улсуудад зориулсан санхүүгийн нөөц гаргуулах чиглэлээр хөгжиж буй улсуудын түншлэл, олон улсын санхүүгийн байгууллага, улсын хувийн доноруудын үйл ажиллагаа урагшилж эхэлж байна. Боловсролын олон улсын санхүүжилтийн сан (The International Finance Facility for Education–IFFEd) олон талт санхүүжилтээ улсын төсөвт

11

ТХБ БА САНХҮҮЖИЛТ

Боловсрол нь маш их үр дүн өгдөг хөрөнгө оруулалт боловч боловсролд санхүүгийн дэмжлэг байнга дутагдалтай байдаг тул санхүүжилтийн хоосон зайг нөхөх хэрэгтэй. Олон засгийн газар энэ чиглэлд томоохон амлалтууд авсан.

Филиппиний Засгийн Газар 2005–2014 оны хооронд суурь боловсролд бүтцийн томоохон шинэчлэл хийж, энэ салбарт зарцуулах зардлаа 2 дахин өсгөсөн байна. Жишээ нь, 2017 онд Боловсролын хэлтэст хуваарилах санхүүжилтээ 25%–аар нэмэгдүүлсэн байна. 2018 онд боловсролын салбарын санхүүжилтийн хуваарилалтаа 533,31 тэр бум Филлиппиний песо (10,26 ам. доллар)–аар нэмэгдүүлжээ.

ЭЗХАХБ–ын гишүүн, аж үйлдвэржсэн улс орнуудыг авч үзвэл сүүлийн таван жилд засгийн газар нь дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ дунджаар 5%–ийг анхан шатнаас гурав дахь шатны боловсролдоо

боловсролыг тэргүүлэх чиглэл болгох амлалттай хослуулдаг

Норвеги. Боловсролын салбар дахь дотоодын ба олон улсын санхүүжилт нь мөн ижил хариуцлага ба манлайллыг харуулж байна. Дотоодын нийт бүтээгдэхүүн дэх засгийн газрын зардал нь ЭЗХАХБ (Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага)–ын гишүүн орнуудын дунд хамгийн өндөр нь бөгөөд 2012–2017 онд 6,4% байжээ.

БНСУ. Эдийн засгаа дэмжих, ядууралтай тэмцэх хүчин чармайлтынхаа дүнд 2012–2017 оны хооронд дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ 5,1%–ийг боловсролдоо зарцуулжээ.

Итали. 2017 онд “ТХБ–ын стратеги”–аа шинэчлэхдээ 4 макро талбарын 20 үйл ажиллагааг оруулсан ба тэдний олонх нь тусгай төсөвтэй байдаг. Жишээ нь, систем бүхлээрээ ажиллах арга хандлагаар ажиллаж байгаа сургууль, их сургууль зэрэг Боловсролын Яамны бүх байгууламжийг баталгаатай болгох ажиллагааг эхлүүлэхэд 5 сая Еврог хуваарилжээ. Түүгээр ч үл барам ТХБ–оор чадварыг бий болгох ойлголтын талаар багш, ажилтнуудад сургалт явуулахад 20 сая евро төлөвлөжээ.

Кипр. ТХБ–ын бодлого, дэд бүтэц, дэмжлэгийн тогтолцооны талаар

хатуу үүрэг зорилт тавьж, нийт бүтээгдэхүүнийхээ 6,1%–ийг боловсролд зарцуулахаар зорьж байгаа нь Европын холбооны дундаж үзүүлэлтээс өндөр байна. Боловсролын төсвийн ихээхэн хэсэг нь багш нарын цалин ба ТХБ–ын талаарх сургалтад зарцуулагддаг.

Канадын Манитоба муж. Тогтвортой байдлын талаарх олон янзын санал санаачилга, суралцагчид, сургууль, орон нутгийн иргэдийн бүтээлч үйл ажиллагааг дэмжихийн тулд жил тутам сургуулиудад ойролцоогоор 2000 канад долларын ТХБ–ын тэтгэлгийг олгодог.

12

ТХБ–ЫГ 21–Р ЗУУНЫ УР ЧАДВАР, АЖИЛ ХӨДӨЛМӨР БА ТОГТВОРТОЙ ЭДИЙН ЗАСАГТАЙ ХОЛБОХ



Суралцагчдад түлхүүр цогц чадамж, буюу “21–р зууны ур чадвар” эзэмшүүлэхэд дэлхий дахинаараа анхаарал хандуулах нь ихэсч байна. “21–р зууны ур чадвар” нь суралцагчдад боловсрол, хувь хүний хөгжил, ажил эрхлэлтийнхээ явцад хөгжиж, мэдлэгийн нийгэмд орох боломжийг олгодог юм. Үүнд: задлан шинжлэх, үр дүнтэй харилцаа, хамтран ажиллах, шүүн тунгаах сэтгэлгээ, асуудал шийдвэрлэх, дижитал бичиг үсгийн болон дэлхийн иргэний ур чадвар зэрэг багтана.


21–р зууны ур чадвараас гадна орчин үеийн нийгэмд ажиллаж, амьдрахад шаардлагатай олон тооны танин мэдэхүйн бус онцлог, чанар, үйл явц байдаг. Үүнд цагийн менежмент, нэгдмэл байдал, сэтгэл хөдлөлийг ойлгох, зорилгоо тодорхойлж түүндээ хүрэх, хариуцлагатай байх, бусдыг өрөвдөх, бусдын сэтгэл хөдлөлийг мэдрэх зэрэг багтана. Заримдаа “зөөлөн”, эсвэл “хөдөлмөр эрхлэлтийн” ур чадвар гэж нэрлэдэг эдгээр ур чадвар нь нийгмийн ба

сэтгэл хөдлөлийн сургалтын нэг хэсэг болдог бөгөөд хувийн хэвшил, иргэний нийгмийн аль алиных нь ажил олгогчид үүнд ихээхэн ач холбогдол өгдөг юм.

Тогтвортой эдийн засагт хүрэх

Инноваци, ногоон ур чадвар, өөрчлөлтийг даван туулах чадамж нь эдийн засгийн салбар бүрийн чухал чиглүүлэн жолоодогч болдог юм.

Ногоон эдийн засаг руу шилжих шилжилтийн дүнд хэдэн арван сая ажил хөдөлмөр бий болоод байна. Жишээ нь: дэлхий дахинд сэргээгдэх эрчим хүчний салбарт одоо 7,7 сая хүн ажиллаж байна. Энэ нь 2006–2010 оныхоос 2 дахин их тоо юм.



Building the future of education

2021



БОЛОВСРОЛЫН ИРЭЭДҮЙГ ЦОГЦЛООХ НЬ

ТАНИЛЦУУЛГА

Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн байгууллагаас (ЭЗХАХБ) өнгөрсөн 60 жилийн хугацаанд улс орнуудын боловсролын тогтолцоог шинэчлэхэд дэмжлэг үзүүлэн, олон чиглэлээр харьцуулсан судалгаа, бодлогын зөвлөмжийг гаргасан билээ. ЭЗХАХБ-ын энэхүү үйл ажиллагаа нь чанарын өндөр түвшинд явагддаг, олон талт харьцуулсан судалгаа, үнэлгээ, хөтөлбөр, дүн шинжилгээ, бодлогын зөвлөмж зэрэг нь олон улсын боловсролын хамтын ажиллагааны салбарт манлайлах үүргийг гүйцэтгэж ирлээ. Ялангуяа харьцуулсан судалгаа хийх, мэдээлэл цуглуулах, харилцан бие биеэсээ суралцах, үнэлгээ дүгнэлт өгөх шаардлагатай олон улсын тулгамдсан асуудлыг тодорхойлон, бодлого боловсруулагчид болон бусад талуудыг оролцуулан хэлэлцүүлэг өрнүүлэх зэргээр үр дүнтэй ажиллаж ирснийг дурдаж болно.

Боловсролд чухал гэгдэх мэдлэг, чадвар, хандлага, үнэ цэн ирээдүйд хэрхэн өөрчлөгдөх, тэдгээрт амьдралынхаа туршид суралцахад ямар орчин шаардлагатай болох, ямар боломж нээгдэх зэргийг нухацтай эргэцүүлэх цаг болжээ. Ирээдүйд гадаад орчны талаас ирэх аливаа эрсдэлд тэсвэртэй байхын сацуу инновацлаг байх сорилттой бид тулгарч байна. Одоо бид энэхүү асуудлаар хэлэлцэхэд тохиромжтой цаг мөч юм. Цар тахлаас үүдэлтэй танхимын сургалт зогсож, онлайн сургалтад шилжсэн явдал нь боловсролын салбарыг ил тод болгон, яаралтай арга хэмжээ авах шаардлагатай болсон. Хөдөлмөрийн зах зээлийн нийлүүлэлт тасалдаж байгаа тул насан туршдаа суралцах

(lifelong) болон боломжит бүх арга хэлбэрийг ашиглан суралцахын (lifewide) ач холбогдлыг чухалчлах болсон бөгөөд шинэ боломжууд нээгдсээр байна.

Дээд боловсролын хувьд цар тахлын нөхцөл байдал оюутанд төдийгүй их сургуулиудын хувьд хүнд цаг мөч байлаа. Дунд сургуулийн хувьд хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байдаг бөгөөд зардлын ихэнх хувийг төрөөс санхүүжүүлдэг бол их, дээд сургуулийн (ИДС) хувьд суралцагчид сонгон суралцдаг ба өөр бусад суралцахуйн арга хэлбэр, ажлын байртай байнга өрсөлдөж байдаг. Мөн сургуулийн хувьд төрийн санхүүжилт тасалдахгүй байх магадлал өндөр бол ИДС-ын хувьд төрийн санхүүжилт тасалдах эрсдэлтэй. Суралцагчийн тоо буурахад төрөөс үзүүлэх дэмжлэг буурах ба өрхийн орлого мөн буурсантай холбоотойгоор ИДС сургалтын төлбөрөө өсгөхөд хэцүү болно. Гэвч нь ерөнхийд нь харвал энэхүү хямрал ИДС-ийн жинхэнэ үнэ цэнийг харууллаа гэж хэлж болно. Суралцагчид онлайн контентод их хэмжээний цаг хугацаа, зардал мөнгийг зарцуулахгүй байх магадлалтай. Суралцагч шилдэг сайн хүмүүстэй уулзах, танилцах, урам зориг өгсөн хэлэлцүүлэг, ярилцлагад оролцох, судлаачидтай хамтарч лабораторид ажиллах, сургуулийн орчинд нийгмийн харилцаанд орох гэж ИДС-д суралцдаг. Сургалт илүүтэй цахимжин, танхимын сургалтыг баяжуулж байгаа хэдий ч багш суралцагчдын болон суралцагчид хоорондын харилцааг хэзээ ч орлохгүй бөгөөд цаг үеэсээ хоцрохгүйн тулд ИДС-ууд суралцахуйн орчныг дахин төлөвлөх, өөрчлөх шаардлагатай юм.

ИДС-ийн судлагдахууны агуулга, агуулгаа хүргэх суваг, мэдлэгийн баталгаажуулалт зэрэг нь цахим технологийн үр дүнд илүү төвлөрсөн бус болж байгаа тул асуудал тулгарах нь ойлгомжтой юм. Агуулга талаасаа мэргэжлийн өндөр түвшинд өргөн хүрээтэй үйл ажиллагаа эрхэлдэг боловсролын агуулга зохиогчидтой (content provider) өрсөлдөх хэцүү даалгавартай тулна. Хосолсон суралцахуйн утга агуулга өргөжин тэлж байгаа өнөө үед ИДС-ийн эрдэмтэн багш нар боловсролын нээлттэй эх сурвалж болон мэргэшсэн байгууллагаас боловсруулсан арга зүйд тулгуурлан ажиллах учраас судлагдахууны боловсруулалт, дизайн болон үнэлгээг хийх арга хэлбэр зэрэг нь өөрчлөгдөх магадлалтай байна. Магадлан итгэмжлэгдэх нь нь ИДС-ийн хувьд чухал эрх мэдэл нь юм. Гэвч цахим технологийн үр дүнд ач холбогдлоо алдаж магадгүй байна. Жишээлэхэд, гэрчилгээ олгодог цөөн цагийн (micro-credentialling) болон блок чейн технологид (blockchain technologies) суурилсан сургалт гм. боломж байгаа бөгөөд суралцагч хэзээ, юуг, хэрхэн сурахаа өөрөө шийдэж, сурсан зүйлээ бие даан хүлээн зөвшөөрүүлэх боломжтой.

Цаашид ЭЗХАХБ хэрхэн ажиллах талаар энэхүү тайланд өгүүлнэ. Энэхүү баримт бичгийг өнөө үед тулгарч буй

бодлогын асуудлуудыг шийдвэрлэх, цар тахлын дараа хүртээмжтэй, тогтвортой нөхөн сэргээх олон талт хандлагыг боловсруулахад чиглэсэн ЭЗХАХБ-ын ерөнхий стратегийн чиг баримжаа, тэргүүлэх чиглэлийн дагуу боловсруулсан болно. ЭЗХАХБ-ын стратегийн зорилтыг хэрэгжүүлэхэд боловсрол болон чадвар онцгой чухал үүрэг гүйцэтгэнэ. Ирээдүй хойч үедээ мэдлэг, чадвар эзэмшүүлж, хандлага, үнэ цэнийг төлөвшүүлээгүй тохиолдолд урт хугацаанд тэгш хүртээмжтэй өсөн дэвжих, технологийн ахицыг үргэлжлүүлэх, цаг уурын асуудлыг шийдвэрлэх болон тэгш хүртээмжтэй, эв нэгдэлтэй нийгмийг бий болгох боломжгүй юм. Энэхүү баримт бичиг нь Боловсрол болон чадварын асуудал хариуцсан газрын (Directorate for Education and Skills) доороос дээшээ, дээрээс доошоо чиглэсэн үе шатаар дамжсан, оролцоог хангасан, давтамжит үйл явцын үр дүн юм. Нарийн Бичгийн Газрын (Secretariat) хамрах ажлын хүрээнд ирээдүйд байж болох нөхцөл байдалд тохирсон стратегийн талаар хэлэлцэхэд чиглэсэн. ЭЗХАХБ-ын бусад газрууд (Directorate) үүнийг хянасан бөгөөд гишүүн орнуудад цаашид хийх ажлынхаа төслийг боловсруулахад санаа, урам зориг өгөх зорилготой юм.



Боловсролын хөгжлийн ололт, бэрхшээл

Өнгөрсөн хугацаанд хүмүүсийн боловсролын түвшин сайжирч, сургалтын үйл ажиллагаа урьд өмнө байгаагүй хэмжээгээр өргөжиж байна. Сүүлийн 200 жилийн хугацаанд боловсролын тогтолцоо улам бүр боловсронгуй болж, эдийн засгийн хөгжил, нийгэм, төр болон олон нийт, хамт олны ахин дэвших гол хөдөлгүүр нь болжээ. Боловсрол нь нийгэмд зайлшгүй шаардлагатай мэдлэг, чадвар, хандлага, үнэ цэнийг бий болгож, нийгмийн эв нэгдлийг хадгалж, хүмүүсийг чадварлаг ажилтан, идэвхтэй иргэн болон төлөвшүүлж, тэр хэрээр ажиллаж, амьдрах чадвартай болгосноор бидний өнөөгийн амьдарч буй нийгмийг үндсээр нь бүрдүүлж өгсөн.

Ялангуяа, боловсрол өргөжин тэлж, чадварлаг ажилтан, иргэдийг бэлтгэх болсноор ардчилал цэцэглэж, нийгэм, эдийн засгийн байгууллагууд тэгш

хамруулах зарчмыг эрхэмлэх болж, инновацад баримжаалсан, мэдлэгт суурилсан нийгэм болон хувиран өөрчлөгдөхөд гол үүрэг гүйцэтгэж байна. ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын адилаар хөгжиж буй орнууд ч боловсролын боломжийг өргөжүүлэх арга замыг эрэлхийлж байгаа ба зарим тохиолдолд илүү хурдтай урагшилж байна. Хөгжиж буй зарим оронд боловсролын чанар болон тэгш хүртээмж нь ЭЗХАХБ-ын гишүүн орнуудынхаас давуу үзүүлэлтэй байх болжээ.

Үүнтэй зэрэгцээд хязгааргүй өсөн нэмэгдэх хэрэгцээ болон эх дэлхийн маань хязгаарлагдмал нөөц; санхүү, эдийн засаг болон бодит эдийн засаг; баян болон ядуу; дотоодын нийт бүтээгдэхүүн болон хүн амын сайн сайхан байдал; техник технологи болон нийгмийн хэрэгцээ; засаглал болон хүн амын дуу хоолойгоо хүргэж чадахгүй байгаа байдал зэргийн хоорондох ялгаатай байдал ихсэж байна. Үүний шалтгаан нь боловсрол гэж хэлж

болохгүй ч хүн амын мэдлэг, чадвар, хандлага, үнэ цэн нь нийгэм, эдийн засгийн хөгжилд хэрхэн нөлөөлж, соёлыг бий болгогчийг санах хэрэгтэй юм. Эдийн засгийн хувьд мэдээлэл болон ачаа барааг глобал хэмжээнд гинжин хэлхээгээр дамжуулан татаж, бүс нутгийн хэмжээнд үйлдвэрлэл явуулах хандлага руу шилжиж байна. Гэхдээ хамгийн давуу тал хаана байна тэнд илүү төвлөрнө. Энэ нь мэдлэг, баялгийг түгээх асуудал чухал болохыг харуулж байгаа бөгөөд боловсролын боломж нэмэгдэж буйтай шууд холбоотой.

Хүн төрөлхтний өв уламжлалыг хойч үедээ өвлүүлэн үлдээх, шинэ залуу

үеийг амьдралд бэлтгэхэд алсын хараа, цаг хугацаа шаарддаг тул боловсрол нь нийгмийн консерватив тогтолцоо болж хувирах шаардлагатай байна. Гэвч боловсрол нь ирээдүйг урьдчилан харах, ирээдүйд бэлтгэх хамгийн чухал нийгмийн тогтолцоо юм. Хүүхэд цэцэрлэгт юу сурснаас тэдний ирээдүйн хүсэл тэмүүлэл, нийгэмд оруулах хувь нэмэр, тэдний эрүүл мэнд, зан үйл болон ахмад настай болоход эрүүл мэндийн салбарт зарцуулах зардал шалтгаална. Боловсрол ийнхүү өнгөрсөн болон ирээдүйг хамтад нь авч үзэхийг шаардаж байна.

Тодорхой бус ирээдүйн төлөөх суралцахуй

Ирээдүйг урьдчилан харахад түвэгтэй. VUCA (volatility, uncertainty, complexity, ambiguity) гэдэг нь тогтворгүй байдал, тодорхойгүй байдал, эдрээтэй байдал, хоёрдмол байдал гэсэн дөрвөн үгийн товчлол бөгөөд үнэндээ бид ирээдүйгээ урьдчилан мэдэх аргагүйг илэрхийлж байна. Сурган хүмүүжүүлэгчид болон боловсролын бодлого тодорхойлогчдын хувьд таагүй л мэдээ. Одоогоор бий болоогүй байгаа ирээдүйн гэгдэх ажлын байранд хэрхэн бэлдэх вэ?, зохиогоогүй байгаа техник технологийг яаж заах вэ?, эсхүл бидний төсөөлөлд ч байхгүй нийгмийн асуудлыг хэрхэн шийдэхийг яаж заах вэ? Өнөөдрийн бидний амьдарч буй цаг хугацаа маш их өөрчлөлт, санаанд оромгүй зүйлсээр дүүрэн байна. Бидний ирээдүй бүрхэг болон гэгээтэй аль алианаар нь харагдаж байна. Гэхдээ бид өөрчлөлтийн золиос, өөрсдөө юу ч хийж чадахгүй хүмүүс бишээ. Бид өөрсдийн ирээдүйг өөрсдөө л бий болгодог. Ирээдүй үргэлж өөрчлөгдөж байдаг нь бидний л бүтээл юм.

Боловсрол салаа замын уулзварт оршин байгаа бөгөөд цар тахлын улмаас төөрөгдөлд орсон мэт сэтгэгдэл илүү

хүчтэй мэдрэгдэж байна. Өнгөрсөн хэдэн зууны турш хадгалж ирсэн боловсролын тогтолцоогоороо ирээдүйд амжилт олохгүй хэмээн зарим хүмүүс үзэж байна. Зарим хэсэг нь боловсролын инновацууд амжилтгүй хэрэгжсэн ба өмнө нь амжилттай хэрэгжиж байсан сахилга бат, цээжлэн тогтоож суралцах зэрэг туршлагаа ахин сэргээхийг дэмжиж байна. Үүнээс гадна боловсрол нь шударга ёс, тэгш хүртээмжтэй байдал болон нийгэмд байр сууриа ахиулах боломжийг нээх ёстой гэсэн амлалтдаа хүрч чадахгүй байна хэмээн олон хүн үздэг. Боловсрол нь ирээдүйн хөрөнгө оруулагч бөгөөд ирээдүйд итгэх итгэл юм. Харин гутрангуй цөхрөнг үзэл боловсролыг сүйрүүлнэ. Хэрэв “бодит” амьдралын хэрэгцээнд нийцэхгүй зүйлсийг зааж, сургаж байна гэж үзвэл залуучууд илүү боловсрол эзэмшихийн төлөө цаг хугацаа, эрч хүчээ зарцуулахаа болих магадлалтай юм. Хэрэв ажилтан нь илүү сайн ажлын байр хайж ажлаасаа гараад байвал бизнесийн байгууллагууд ажилтныхаа насан туршийн боловсролд хөрөнгө зарцуулах нь багасна. Хэдийгээр бодлого боловсруулагчид боловсролыг

ирээдүйдээ хийж буй хөрөнгө оруулалт гэж үздэг боловч, заримдаа хойш тавин, яаралтай арга хэмжээ авах өөр бусад асуудлыг эн тэргүүнд тавьж шийдвэрлэх магадлалтай юм.

Хүн төрөлхтөнд цаг уурын өөрчлөлт, хиймэл оюун ухаан, шинэ технологийн үр нөлөө, олноор шилжин суурьших

үзэгдэл, глобал татвар зэрэг мега сорилтууд тулгарсан өнөө үед хүний саруул ухаан гол түлхүүр нь юм. Судалгаа шинжилгээ хийж, өгөгдөл мэдээлэл болон туршлага дээрээ суурилан мэдлэг мэдээллээ нэгтгэж, хамтдаа төсөөлж, алсыг харж чадсанаар илүү сайн сайхан ирээдүйг бид цогцлоож чадна.

Технологийн өөрчлөлтийн сөрөг үр дагавар

Технологийн өөрчлөлтөөс үүдээд боловсролд олон бэрхшээл тулгарч байгаа хэдий ч шинэ боломж нээгдсээр байгаа нь боловсролыг өөрчлөх шалтгаан юм. Технологийн өөрчлөлтийн үр нөлөөг цаг алдалгүй тооцоолж, урьдчилан харахын тулд бодлого тодорхойлогчид алсын хараатай, зоригтой хандах төдийгүй боловсон хүчнээ бэлтгэх хэрэгтэй болж байна. Хиймэл оюун ухаан, үүлэн технологи, их өгөгдөл, Юмсын интернэт (Internet of Things), виртуал ертөнц болон цахимжилтын бусад хэлбэр нь дэлхий ертөнцийг үндсээр нь өөрчлөх болж байгаагийн зэрэгцээ бидний юуг, ямар арга замаар сурахыг өөрчилж байна. Цар тахлын үр дүнд цахимжилт улам эрчимжсэн. Өнөөдрөөс ердөө 10-15 жилийн дараа биднийг “хайпер-дигитал” ирээдүй хүлээж байна. Энэ нь дэлхий даяараа нэг сүлжээнд хандах боломжтой, хэрэглээний тоног төхөөрөмжүүд интернэтэд холбогдсон, үйлдвэрлэл автоматжиж, виртуал ертөнцөд ажиллах нь нэмэгдэж, олон улсын бизнесийн гэрээ хэлэлцээр цахим хэлбэрт шилжиж, шинэ, цахимжсан бизнес моделиуд бий болно гэсэн үг юм. Энэ бүхэн нь зах зээл, бизнесийн үйл ажиллагаа болон ажлын мөн чанар, ур чадварын эрэлт хэрэгцээ, түүнчлэн бидний биечлэн болон виртуал орчинд хоорондоо харилцах арга хэлбэрийг хувирган өөрчилж байна. Цахимжилт нь хүний, ялангуяа, хүүхдийн, аюулгүй

байдал, хувийн орон зай, эрүүл мэнд болон сайн сайхан байдалд нөлөөлж байна. Цаашлаад нийгмийн харилцаа, эв нэгдэл болон ардчиллын үйл явцад нөлөөлж байна. Хэдийгээр цахим технологи, даяаршил нь дэлхийн эдийн засаг, нийгмийн бүтцэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй ч үүнийг урьдчилан таамаглах боломжгүй байна. Бидний хамтын хүчин чармайлт нь тэрхүү сөрөг үр нөлөөг багасгахад тусална. Технологийн салбарын өөрчлөлттэй дасан зохицох замаар технологи болон соёл, нийгэм, эдийн засгийн, боловсролын хүчин зүйлсийн хооронд тасралтгүй харилцан урвал явагдаж байна.

Өнөөгийн технологийн эрин үед хүмүүс юу сурах хэрэгтэй байна вэ? түүнчлэн тэд ямар арга замаар сурах вэ? гэдгийг шийдэхэд цахим технологи боломжийг олгож байна. Тухайлбал, ахмад настан, хөдөлмөр эрхлээгүй, сургалт, боловсролд хамрагдаагүй байгаа залуучууд, тусгай хэрэгцээтэй иргэд зэрэг хүн амын бүлэгт цахим технологийн тусламжтайгаар бүрэн хүрч үйлчлэх боломжтой юм. Сурган хүмүүжүүлэгчид, суралцагчдын хувьд цаг хугацаа, орон зайнаас үл хамааран мэдлэгийг янз бүрийн хэлбэрээр эзэмших боломжтой боллоо. Цахим технологийн тусламжтайгаар суралцагчийг мэдлэг эзэмших үйл явцын идэвхтэй оролцогч болгон харж, шинэ заах аргыг хэрэгжүүлж болно. Танхимын сургалтыг цуцлан

боловсролын үйлчилгээг бусад арга хэлбэрээр хүргэх шаардлагатай болоход энгийн түвшний технологи болон өндөр түвшний цахимжсан технологиор дамжуулан багш, сургууль, боловсролын бүхий л тогтолцоо зайн хэлбэрт шилжсэн. Бүгдийг урьдчилан тооцоолж хөгжүүлж чадсан, шилдэг тогтолцоонууд нь технологийн тусламжтайгаар, төсөл болон шинжлэн судлах аргад суурилан, суралцагчдын идэвхтэй оролцоонд тулгуурлан хамтран суралцах боломжоор ханган, явцын үнэлгээг шууд зохион байгуулах зэргээр суралцахуйн арга хэлбэрийг улам баяжуулж чаджээ. Суралцахуйг интерактив байдлаар, туршилт, симуляц үүсгэх боломжтой программ зохиосон, мэдлэг сорьсон тоглоом, нийгмийн сүлжээг ашигласан хамгийн шинэлэг сургалтын дизайнд (instructional design) тулгуурлан сургалтын курс агуулгыг шугаман бус байдлаар (non-linear courseware) судлах боломжтой технологийг хөгжүүлсэн зэрэг сонирхолтой жишээ байна. Энэ бүхэн XXI зууны мэдлэг, чадварыг эзэмшүүлэхэд зайлшгүй шаардлагатай сургалтын хэрэгсэл юм. Нэг багш өнөөдөр сая сая суралцагчдад хүрч, өөрийн санаа бодлыг дэлхий дахинтай хуваалцах боломжтой. Цар тахлын үр дүнд боловсролын цахим шилжилт эрчимжсэн. Гэнэтийг өөрчлөлт хийж, илүү олон зүйлийг шинээр суралцах шаардлагатай болсон ба өөрчлөлт нь зайлшгүй байх ёстой хүчин зүйл болж байна.

Цахим технологи нь зөвхөн нэг суралцагч, нэг багшид зориулагдахгүй харин суралцахуйн экосистемийг бий болгох боломж олгодог гэдэг нь магадгүй түүний хамгийн чухал шинж гэж болно. Экосистемийг бий болгохын тулд хамтын ажиллагаа шаардлагатай. Технологийн тусламжтайгаар суралцагчид нэгэн хамт олон (community) болж, хамтран

суралцах боломжтой ба ингэснээр зорилгоосоо хазайхгүй, илүү тууштай, идэвхтэй суралцахаас гадна үр дүнтэй суралцах стратеги, арга барилаа боловсронгуй болгож чадна. Үүний адил багш, сурган хүмүүжүүлэгчид мөн адил технологийн тусламжтайгаар хамт олонтой болж, өөрсдийн нөөц, туршлагыг хуваалцах, баяжуулах болон хамтын ажиллагааны үр дүнд мэргэжлийн хувьд өсөн дэвжиж, институтчилэх боломжтой юм. Боловсролын удирдлага, төр засгийн түвшинд сургалтын хөтөлбөрийн загвар, бодлого болон заах аргын сайн туршлагыг хуваалцах, илүү боловсронгуй болгох боломжтой болно. Гэсэн хэдий ч суралцахуйн цахим экосистем, боловсролын үйлчилгээний нийгэм, харилцааны чиг үүрэг болон суралцахуйн биет орчин зэргийн хооронд зөрчилдөөн үүсэж болох юм.

Аажмаар үүссэн ч бай, гэнэтийн цочмог байдлаар гарч ирсэн ч бай өөрчлөлт хийгдэх нь зайлшгүй байна. Боловсролын үйлчилгээг хүртдэг хүүхэд, залуучууд, гэр бүл, олон нийтийн санаа зовнил, итгэл найдвар нь боловсролоос юуг хүлээж буйг тодорхойлдог бөгөөд суралцахуйг хэрхэн зохион байгуулахыг ч мөн тодорхойлно. Боловсрол нь сурагчдад ямар нэгэн зүйл заагаад орхих бус харин тэдэнд улам ээдрээтэй, хувирамтгай, тодорхой бус болж байгаа дэлхий ертөнцөд итгэл төгс амьдрахад нь хэрэг болох найдвартай луужин, багаж хэрэгслийг өөртөө урлаж, эзэмшихэд нь тусалж дэмжих үйл ажиллагаа болжээ. Өнөөгийн өнцгөөс харахад боловсролын амжилт нь өөрийгөө таньсан бие хүн, амьдралд хэрэгтэй арга хэрэгсэл (agency) болон зорилго хэмээн тодорхойлж болохоор байна. Боловсрол нь сониуч зан (нээлттэй оюун ухаан), энэрэнгүй сэтгэл (зүрх сэтгэлээ нээх) болон зориг тэмүүллийг (танин мэдэхүй, нийгэм,

сэтгэл-хөдлөлийн нөөц, чадвараа ашиглан хариу үйлдэл үзүүлэх) хөхиүлэн дэмжих явдал юм. Эдгээр нь манай цаг үед бидэнд тулгараад байгаа хамгийн том аюул болох үл

тоомсорлолт (хаалттай оюун ухаан), үзэн ядалт (зүрх сэтгэл нь хаалттай) болон айдсын (арга хэрэгслийг ашиглах боломжгүй болгодог) эсрэг тэмцэх хамгийг чухал зэвсэг юм.

Боловсрол ба нийгмийн шинэ гэрээ

Нийгмийн давхраажилт, бүтцээс хамааран нийгмийн ялгаатай бүлгүүдийн зүгээс боловсролыг янз бүрээр харж байна. Өнгөрсөн хугацаанд нийгэмд байр сууриа ахиулах, үр хүүхдийнхээ нийгэмд эзлэх байр суурийг бэхжүүлэх хамгийн гол арга зам нь боловсрол эзэмших явдал байсаар ирсэн. Гэвч ЭЗХАХБ-ын гишүүн хэд хэдэн улс орны хувьд нийгмийн байр сууриа ахиулах нь улам түвэгтэй болж, ялангуяа дундаж давхаргын хувьд нийгмийн байр суурь буурахвий гэсэн айдас илүү тархсан байдал ажиглагдаж байна. XX зууны нийгмийн халамжийн системтэй, нийтийн боловсролыг чухалчлан үздэг байсан улс орнуудын эрин үе дууссан, эсхүл хэрэгцээг нь хангахаа больсон хэмээн хүн амын ихэнх хэсэг үзэх болжээ. Боловсрол эзэмшиж, өөрийн авьяас, хүч хөдөлмөрөөрөө эцэг эхийнхээ амьдарч байснаас илүү сайн сайхан амьдарч чадна гэсэн итгэл үнэмшил нь XX зууны II хагаст боловсролын тогтолцоо өргөжин тэлэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн. Гэвч нийгэмд байр сууриа ахиулах боломж хязгаарлагдаад ирмэгц сургуулийн тогтолцоонд итгэх итгэл алдарч, ар гэрийн боломжгүй суралцагчид сургуульд суралцахгүй болох магадлалтай. Үүний үр дагавар нь зөвхөн боловсролын салбарт мэдрэгдээд зогсохгүй хүн ам “нийгмийн гэрээ”-нд итгэх итгэл алдарч, “тогтолцоо”-г эсэргүүцэж, популизм руу хошуурч, ардчиллаас холдоно.

Нийгмийн бүлгүүд, улс үндэстэн бүхэлдээ ахиж дэвших, ядуурал,

нийгмийн гадуурхлаас ангид байх арга зам нь боловсрол байсаар ирсэн хэдий ч зарим тохиолдолд боловсрол өөрөө тэгш бус байдлыг бий болгох хэрэгсэл болдог талтай. Боловсрол эзэмших боломж улс орон бүрд шударга байж чадахгүй байна. Үе хойчдоо давуу тал, эд баялгаа дамжуулан үлдээхэд боловсрол чухал үүрэг гүйцэтгэнэ. Орчин үеийн боловсролын тогтолцоонд сурагчийг сонгон шалгаруулахдаа ихэнх тохиолдолд авьяасыг нь ар гэрийн боломж, нийгмийн гарал үүсэлтэй нь андуурч хардаг.

Гэсэн хэдий ч боловсрол нь нийгмийг нэгтгэн барьж байгаа гол институтчилалын бүтэц хэвээр байх болно. Энэ нь боловсролоор дамжуулан шинээр төрж буй залуу хойч үеийг нийгмийн харилцаанд оролцуулж, нийгмийн эв нэгдлийг бий болгоно гэсэн үг юм. Нэгэн түгээмэл агуулгаар суурь мэдлэг олгож, зан үйл, үнэ цэнийг нэгдмэл байдлаар төлөвшүүлж, бие биеэсээ хамааралтай байх байдал үүснэ. Залуу хүн бүрд суурь чадвар, чадамжийг олгож, хөдөлмөрийн зах зээлд хөл тавих гарааг нь нээж өгнө. Боловсролын институтүүд эдгээр үүрэг амлалтаа биелүүлж чадахгүй байгаа тохиолдолд шахалт шаардлага нэмэгдэх төдийгүй сөрөг үр дагавар их байна. Чадваргүй иргэн бэлтгэх, хүн хоорондын харилцан итгэлцэл болон нийгмийн эв нэгдэл буурах нь маш өндөр өртөгтэй ажил бөгөөд улс орнууд ихэнхдээ үүнийг анхаардаггүй ирлээ.

Боловсрол нь тэгш бус байдлыг бууруулж, нийгмийн эв нэгдлийг тэнцвэртэй байлгахад ач холбогдолтой

болохыг цар тахлын үеэр бид сайтар ойлголоо. Танхимын сургалтыг зогсоож, зайн сургалт, гэрийн сургалт эхлэх үед ажиглагдсан шууд үр дагаврын нэг нь тэгш бус байдал нэмэгдсэн явдал юм. Сургууль нь нийгмийн тэгш бус байдлыг тодорхой хэмжээнд тэнцвэртэй барьж байдаг нийгмийн институт юм гэдгийг одоо нийтээр хүлээн зөвшөөрөөд байна. Боловсролын тогтолцоо уян хатан, олон янз, хувь хүний хэрэгцээнд чиглэсэн байх тусам нийгмийн ялгарал, тэгш бус байдал өсөх хандлагатай

байна. Цар тахлын дараах үеийн боловсрол нь тэгш бус хүртээмж болон шударга байдалтай холбоотой асуудлыг шийдвэрлэх шинэ арга зам эрэлхийлэх шаардлагатай болж байна. Хувь хүний хэрэгцээнд чиглэсэн боловсролыг чухалчлах болсон тул “Нэг загвар бүгдэд нь тохирно” гэдэг арга хандлагаас татгалзах хэрэгтэй болж байна. Энэхүү шилжилтийг дагаад тэгш байдал, олон янз байдалд хандах арга хандлага мөн адил өөрчлөгдөх хэрэгтэй болно.

Боловсролын зорилгыг дахин эргэцүүлэх нь

Боловсролын зорилгыг эргэн харж, эргэцүүлэхийг бидний хүрээлэн буй орчин шаардаж байна. Технологийн өөрчлөлтийн өмнөх үе шаттай харьцуулахад цахимжилт, ялангуяа, хиймэл оюун ухаан бидэнд урд өмнө байгаагүй боломжуудыг нээж байна. Цахим технологи бидний ажил, нийгмийн амьдралд хор хөнөөл учруулаад зогсохгүй бидний чадавхыг мөн өргөжүүлж, баяжуулж байдаг. Ухаалаг тоног төхөөрөмж, биологийн болон тархины үйл ажиллагаанд нөлөөлөх технологи нь хүнийг цоо шинэ түвшинд танин мэддэг, мэдэрдэг болгоно. Нөгөө талаар хүний эдийн засгийн үнэ цэнэ алдагдаж, биологи, компьютер инженерчлэлийн үр дүнд өмнө нь хүний хийдэг байсан олон зүйлийг автоматжуулж, оюун ухааныг ухамсраас ангид байлгах болсон нь боловсролын зорилгод асар их нөлөөтэй юм. Ийм учраас боловсролын ирээдүйг урьдчилан тодорхойлохын тулд технологийн ахиц дэвшил, ялангуяа, хиймэл оюун ухааны салбарт хийгдэж буй өөрчлөлтийг ойлгож, урьдчилан таамаглах шаардлагатай юм.

Маргаашийн боловсролын институтууд нь өөрсдөө бодож шийдвэрээ гарган, бусадтайгаа хамтран ажиллаж, иргэний үүргээ биелүүлдэг иргэн

болгон төлөвшүүлэх хэрэгтэй. Суралцагчдад зөв, буруугийн итгэл үнэмшлийг бат суулгаж, бусдын үзэл бодлыг ойлгон, хүлээж авч сурахад нь тусалж дэмжих хэрэгтэй. Хувь хүмүүс өөрөө өөртэйгөө, бусадтайгаа, эх дэлхийтэйгээ хамт оршин тогтнож, амьдрахад суралцах хэрэгтэй. Хүн гэртээ болоод нийгэм, олон нийтийн дунд хэрхэн бодож, сэтгэдгийг, судлаачид, уран бүтээлчид хэн боловч өөр бусад соёл, заншилд хэрхэн амьдардгийг сайтар ойлгох хэрэгтэй юм. Хүний хийдэг олон ажлыг тоног төхөөрөмжөөр орлуулж болох ч нийгэм, иргэний амьдралд утга учиртайгаар хувь нэмэр оруулах хэрэгцээ, шаардлага байсаар байх болно. Цахим технологи нь биднийг ухаалаг тоног төхөөрөмжтэй тэнцвэргүйгээр дайсагнахын оронд “хүн байх” гэдгээ эргэцүүлэн бодож, амьдралаа хэрхэн цэцэглүүлж болох вэ гэдгээ эргэн харахад уриалж байгаа юм.

Өнөөдөр боловсролд тулгараад буй сорил бэрхшээл хүнд хэцүү мэт санагдаж байгаа боловч эдгээрийг даван туулах олон арга зам бий. Боловсролын тухай мэдлэг өөрөө боловсролын хамгийн үнэ цэнтэй нөөц болоод байна. Шинжлэх ухаан хөгжиж, судалгаа шинжилгээ нэмэгдэх

тусам боловсролын тогтолцоог хувиран өөрчлөх нөөц бололцоо мөн дагаад өснө. Боловсролын тухай шинэ мэдлэг, мэдээлэл маш хурдтай бий болж, суурь мэдлэгийг шинэчилж, хуучин мэдлэгийг хэрэгцээгүй болгож байна. Боловсрол нь шинжлэх ухааны хязгаарлагдмал мэдлэг, туршлагыг сурган хүмүүжүүлэгчдээр дамжуулан суралцагчид хүргэдэг байсан ба хувь хүн ихэнхдээ өөрийн уран сэтгэмж, зөгнөлөөр баяжуулсаар олон жил өнгөрчээ. Боловсролын салбарт гарсан инновац нь танин мэдэхүй, тархи судлалын шинжлэх ухааны нотолгооноос илүүтэй, жишээлбэл, хүүхдийн төрөлхийн сониуч зантай

холбоотой таамаглалд тулгуурлан хийгдэж байв. Боловсролын салбарт олон төрлийн шинэ салбар шинжлэх ухаан үүсэж хөгжсөнөөр энэ байдал өнөөдөр өөрчлөгдөж байна. Танин мэдэхүйн сэтгэл зүй, тархи судлал болон нийгмийн сэтгэл зүй зэрэг салбарыг багтаасан “Суралцахуйн шинжлэх ухаан” шинээр хөгжиж байна. Ийнхүү шинэ салбар шинжлэх ухаан хөгжиж байгаа нь боловсролын практикт огцом өөрчлөлт хийх боломж олгохоос гадна багшлах мэргэжлийг бэхжүүлж, боловсролд итгэх нийгмийн итгэлийг нэмэгдүүлэх боломжийг олгож байна.

БОЛОВСРОЛ БОЛОН УР ЧАДВАР: ОЛОН ТАЛТ БАЙДАЛ



Бид ажил эрхлэхийн тулд суралцдаг байсан бол харин одоо суралцахуй нь өөрөө хөдөлмөр болжээ. Хувь хүн дор бүрнээ болон бид хамтдаа амьдарч буй

орчин нөхцөлөө мэдэж, ойлгож, хэрхэн өөрчлөхөөс бидний ирээдүйн хөгжил цэцэглэлт, сайн сайхан байдал хамаарч байна. Үүнд одоогийн байдлаар цар

тахлын нөхцөл байдлыг ойлгож болох боловч ирээдүйд технологи, цаг уур, хүн ам зүйн болон нийгмийн өөрчлөлт, эсхүл байгалийн гамшгаас үүсэн гарч болох эрсдэл, гэнэтийн цохилтыг ойлгоно. Хэдийгээр техник технологи нь хүний чадварыг нэмэгдүүлж, баяжуулж байгаа ч хүний гараар бүтээсэн зүйлс хүн төрөлхтний соёл иргэншилд сөргөөр нөлөөлж байна. Бид бие биеэсээ харилцан хамаарах нь нэмэгдсэн ба дэлхий дахинтай нягт холбогджээ. Хүний суралцахуй бол өөрийн потенциал болон боломжоо нэмэгдүүлэх явдал юм. Ирээдүйд суралцахуйгаар дамжуулан хувь хүн, нийгэм, байгууллага, олон нийт боломжийг үйлдэл болгон хувиргаж, бүгдийн сайн сайхан амьдралын төлөө шаардлагатай алхмыг хийж, арга хэмжээ авна. Суралцахуй нь хувь хүн, нийгэм, олон нийтийн сайн сайхны төлөө алхам хийх, арга хэмжээ авах арга хэрэгслийг (agency) эзэмшүүлэх явдал юм.

Боловсролын институтүүд

Хүний үндсэн үйл ажиллагаа болох суралцахуй нь цаг хугацаа, орон зайд баригддаггүй боловч суралцах үйл явагддаг институтүүд хувиран өөрчлөгдсөөр байна. Түүхэн явцад үр дүнтэй суралцах орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилготой сургууль, их сургууль зэрэг институт үүсэн бий болжээ. Өнгөрсөн хэдэн зууны туршид эдгээр институт нь цөөнхийн суралцах хэрэгцээг хангадаг байснаас олонход боловсролын үйлчилгээ үзүүлдэг байгууллага болон өөрчлөгдсөнөөс гадна албан ёсны болж, мэргэшсэн байна. Эдгээр байгууллага нь шинэ үеийнхнийг нийгэмшүүлэх; улам чадавхиж буй ажиллах хүчнийг бэлтгэж ажлын байр, нийгэмд эзлэх байр суурьтай нь залгуулах; нийгэмд байр сууриа ахиулах, ахиж дэвшихэд нь дэмжлэг үзүүлэх; хувь хүн болон

иргэний чанарыг хөгжүүлэхэд чиглүүлж ирсэн байна. Эдгээр үүргийг хэрэгжүүлэхдээ боловсролын байгууллагууд танин мэдэхүйн хувьд өсөн дэвжиж, мэдлэгийг зааж эзэмшүүлэхэд мэргэжлийн дэмжлэг үзүүлэхээс гадна зан чанарыг хөгжүүлж, зан үйлд сургаж, үнэ цэн, ёс зүйг төлөвшүүлдэг. Харин олон нийтийн зүгээс уламжлалт боловсролын институтийн (албан боловсрол) ач холбогдол, бодит хэрэгцээнд нийцтэй эсэх, боловсролыг “жинхэнэ” утгаар нь олгож чадаж байгаа эсэхэд шүүмжлэлтэй хандаж байна. Энэхүү шүүмж шинэ зүйл биш боловч яагаад ийнхүү шүүмжилж байгаагийн шалтгаан нь илүү тодорхой болж ирлээ (жишээ нь, албан боловсрол эзэмшээгүй, сургуулиа хаяж тэрбумтан болсон технологийн салбарын хүмүүс; боловсролын институтүүдийг шинэ үеийн хөдөлмөрийн талбар, технологит тохиромжгүй гэж үзэж буй олон нийтийн үзэл бодол, шүүмж). Эцэст нь хэлэхэд оюун ухаан болон сэтгэл зүрхээ өгч, бодож эргэцүүлэх ёстой болжээ. Шилжилт хийгдэж буй энэ цаг мөчид ЭЗХАХБ өөрийн байр суурийг дахин тодорхойлж, манлайлах болно.

Боловсролын институтүүдийн экосистем

Суралцах орон зай, боломжийг бий болгодог гэдэг утгаараа институтчилэгдсэн тогтолцооны ач холбогдол өндөр хэвээр байгаа боловч монополь байдлаа алдаж байна. Суралцахуйн бусад хэлбэр, сувагтай танилцаж, нэвтрүүлэх шаардлагатай болж байна. Цар тахлын уршгаар танхимын сургалт хаагдаж, сургуулийн үйл ажиллагаа бусад байдлаар тасалдах үед боловсролд урьдчилан таамаглаагүй технологийн болон нийгмийн харилцааны инновацууд

нэвтэрсэн тул бодлого тодорхойлогчид болон сурган хүмүүжүүлэгчид энэхүү шинэ нөхцөл байдалд суралцахуйг хэрхэн дэмжих вэ гэдгийг хүмүүс, орон зай, цаг хугацаа, технологийн хүчин зүйлсийг харгалзан тооцоолж, шинэ арга замыг эрэлхийлэх шаардлагатай болж байна. Технологийн болон институтийн хувьд боловсрол ийнхүү олон янз байдалтай болж ирсэн энэхүү туршлагаас суралцаж, үнэлгээ дүгнэлтийг нарийн няхуур хийх нь боловсролын ирээдүйд чухал ач холбогдолтой.

Цар тахал бидэнд сургууль нь тусгаарлагдсан орчин биш юм гэдгийг ойлгууллаа. Сургууль болон багш нар суралцахуйн бусад олон хүчин зүйлстэй харилцах болж, хамтран ажиллаж байна. Гэр бүл болон хувь хүн хоорондын харилцаа холбоо нь мөн адил байнга өөрчлөгдөж байдаг ба суралцахуйг нөхцөлдүүлдэг гол хүчин зүйл юм. Сургууль нь гэр бүл, хувь хүмүүстэй байнгын харилцдаг. Танхимын сургалт цуцлагдсан үед суралцах үйлийг тасалдуулахгүй, амжилттай үргэлжлүүлэх цор ганц, хамгийн чухал хүчин зүйл нь эцэг эхийн дэмжлэг байсан. Эрүүл мэнд, халамжийн тогтолцоо, улс төр, шашин, шинэ болоод хуучин олон нийтийн сүлжээ зэрэг нийгмийн институт нь хүнийг нийгэмшүүлэх, сургах орон зайгаар хангахад илүү чухал үүрэгтэй оролцох боллоо. Мэдлэг чадварыг эзэмших (сургуульд) болон хэрэглэх (ажлын байранд) хоёрын ялгаа улам бүр багасаж, суралцахуй, үнэлгээ болон эзэмшсэн чадварыг ахин тодорхойлох шаардлага бий болж байна. Ажил олгогчид ажилчдаа сургалтад хамруулж, ажлын байранд албан бус боловсрол олгохоос гадна боловсролын зорилго, нийц, мөн чанарыг ахин тодорхойлоход илүү идэвхтэй оролцох нь чухал ач холбогдолтой юм. Гадаад ертөнцөд сатаарах болон урам зориг өгөх зүйлс нэмэгдэж байгаа өнөө

үед залуу үеийн сургуулийн орчинд суралцах хүслийг өндөр байлгах нь улам хэцүү болж байна.

Хаанаас ч суралцах боломж

Технологийн тусламжтайгаар боловсролын институтээс гадуур суралцах шинэ, өөр сувгууд бий болж байна. Нөөц бололцоо, багшийн хүрэлцээ хязгаарлагдмал үед тодорхой орон зай, цаг хугацаанд баригдаж суралцдаг байсан бол одоо боломж бололцоо түгээмэл байдаг болсноор заавал институтээс хамаарахгүй болжээ. Суралцахуйг технологиор баяжуулж, өргөжүүлснээр аажмаар албан бус хэлбэрт шилжиж, наснаас шалтгаалсан хамаарал үгүй болно. Улс орнууд юуны түрүүнд эзэмшсэн боловсролыг баталгаажуулах чиглэлийг баримталдаг байсан бол эдүгээ амьдралынхаа туршид суралцах, чадвараа хөгжүүлэх шинэ хэлбэрт шилжиж байна. Технологийн тусламжтайгаар амьдралын туршид суралцах боломжийг дэмжихээс гадна сурсан зүйлийг нь үнэлэх, хүлээн зөвшөөрөх боломжтой болно. Ийнхүү суралцахуй нь институт болон насны хязгаараас үл хамаарах үед бодлогын түвшинд шийдвэрлэх шаардлагатай асуудлууд гарч ирэх ба эрэлт болон нийлүүлэлт талаасаа инновацлаг шийдэл, арга хэмжээг авч, суралцахуйг дэмжих түншлэлийг шинээр бий болгох хэрэгтэй болох юм.

Суралцагчийн хувьд суралцах үйлийг нь хөнгөвчилж, баялаг болгож, давуу тал үүсгэж чадаж байгаа тохиолдолд сургууль, их сургууль зэрэг институтчилэгдсэн албан боловсрол ирээдүйтэй хэвээр байна.

Суралцахуйн гол мөн чанар нь мэдлэг эзэмших үйл явц бус харин нийгэм, харилцааны үйл явц юм. Бид бусадтайгаа хамт болон бусдаасаа суралцаж байдаг. Үүнээс гадна зөвхөн

суралцах зорилгыг өмнөө тавьж, нэг цаг хугацаа, орон зайд төвлөрсөн нөхцөлд хүн хамгийн сайн суралцдаг байна. Суралцагчийн дотоод хүсэл зоригийг гадаад хүчин зүйлсийн тусламжтайгаар өдөөж, идэвхжүүлэн суралцагч өөрөө ганцаараа хүрч, хэрэгжүүлж чадахгүй зүйлсэд нь сургууль дэмжлэг үзүүлж, оюун ухааныг нь тэлж байдаг. Үүний зэрэгцээ дунд сургууль болоод их сургууль нь гадаад ертөнцтэй илүү сайн хамтарч ажиллах хэрэгтэй юм. Сургууль болон орон нутаг хоорондын, их дээд сургууль болон орон нутгийн

бизнес аж ахуйн нэгж хоорондын хамтын ажиллагааг бий болгож, хүмүүс суралцаж болох орон зайг нэгтгэж өгөх нь боловсролын институтийн ирээдүйд чухал ач холбогдолтой. Прагматик болон бодлоготой холбоотой байр сууринаас, энэхүү баримт бичиг нь институтчилэгдсэн боловсрол, түүний дотор голчлон сургууль, их дээд сургууль дээр төвлөрч байна. Гэвч эдгээр институт суралцахуйн бусад боломж маш их болж буй өнөөгийн нөхцөлд оршин тогтноход хэцүү болохыг анхаарах нь зүйтэй.

**БОЛОВСРОЛ БОЛОН УР ЧАДВАР:
ОЛОН УЛСЫН ТҮВШНИЙ ҮЙЛ
АЖИЛЛАГАА, СТРАТЕГИ, ХЭТИЙН ТӨЛӨВ**



Олон улсын түвшинд

XX зууны эхэн үеэс улс орнууд хоорондоо яриа хэлэлцээр хийх, харилцан суралцах боломжийг олгох үүднээс боловсролын институтийн хүрээг бий болгосон. Боловсролын тогтолцоо нь үндэсний түүх, хэл, соёлоо багтай тусгахын хажуугаар

бусад улс оронтой байнга харилцаж байдаг. Сурагч, багш, эрдэмтэд өөр улс оронд зочилж, зарчим, онол болон туршлагаа хуваалцан харилцан урам зориг авч байдаг. Бодлого, туршлагыг боловсруулахдаа аажмаар боловч эргэлт буцалтгүйгээр олон улсын,

харьцуулсан өнцгөөс хардаг болжээ.

Дэлхийн II дайнаас хойш хамтын ажиллагаа, харилцан ойлголцол нь дэлхий ертөнцийг илүү сайн сайхан газар болгож чадна гэсэн санаанд үндэслэсэн энх тайван, эдийн засгийн хөгжил цэцэглэлтийн нийтлэг зорилгын төлөө улс орнуудыг нэгтгэх олон талт байгууллагуудыг байгуулсан. ЭЗХАХБ-ын зарим оронд тэгш бус байдал нэмэгдэж, заримд нь хэвээр байсаар байгаа тул даяаршлыг зарим тохиолдолд элит болон чинээлэг хүмүүсийн ашиг сонирхлыг хамгаалж байна хэмээн үзэх нь бий. Даяаршлын эсрэг үзэл өсөн нэмэгдэж, үүнээс улбаалаад улс төрийн хэд хэдэн шинэ хандлага өрнөсөн ба улмаар үндсэрхэг үзэл, улс орныхоо эдийн засгийг хамгаалсан хаалтын бодлого (protectionist policies) зэргийг хүртэл хэрэгжүүлж байна. Цар тахлын болон түүний дараах үеийн нөхцөл байдалд энэхүү тусгаарлах хандлага илүү нэмэгдэх магадлалтай юм. Өнөөгийн нөхцөл байдалд олон талт үзлийн үнэ цэнийг илүү тодорхой ойлгуулах хэрэгтэй болж байна. ХХ зууны тогтолцоонд тулгараад буй цар тахлаас эхлэн цаг уурын өөрчлөлт, эсхүл хиймэл оюун ухааны эрх зүйн орчныг бий болгох зэрэг бэрхшээлийг шийдвэрлэхэд улс орнууд нягт хамтран ажиллах шаардлагатай юм. Боловсролын хувьд ч мөн адил.

Өнөөдрийн боловсролын удирдлагын тогтолцоонд олон улсын түвшин гэдэг хүчин зүйл маш чухал юм. Олон улсын түвшнийг авч үзэхийн ач холбогдол нь боловсролыг үндэсний хэмжээнд хууль, эрх зүйн зохицуулалтын хүрээнд харахаас гадна бусад орны туршлагатай харьцуулах, хамтран ажиллах, бусдаас суралцах орон зайг ашиглаж байгаа хэрэг юм. Улс орнуудын боловсролын тогтолцоо хоорондоо ялгаатай байдаг учир үр нөлөөг нь үнэлэхэд хүндрэлтэй байдаг. Улс орнуудыг хооронд нь

харьцуулж харвал дотоод бүтэц, тогтолцоог ойлгох боломжтой болно. Хамгийн сайн боловсруулсан мэдлэгээс ашиглаж, харилцан суралцаж, шинэ санаагаа хуваалцаж чадвал улс орнуудад илүү дэмжлэг болох юм. Олон улсын байгууллагын зүгээс улс орнуудад боловсролын бодлогын хэрэгжилт, үнэлгээний талаар зөвлөмж хүргүүлэх үүднээс харьцуулсан судалгааг баримт нотолгоо, судалгаатайгаар дэлгэж, харилцан судалж, туршлагаа хуваалцах боломж олгодог. Боловсролын тогтолцоонуудын харьцуулсан үзүүлэлт, бенчмаркийн мэдээлэл нь өнөө үед боловсролын бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд чухал хүчин зүйл болж байна. Улс орнууд өөрсдийн боловсролын тогтолцоог бусад орныхтой харьцуулж үнэлэх, бенчмаркаа тогтооход найдвартай харьцуулсан судалгаа, шалгуурууд гол эх сурвалж нь болж байна. ЭЗХАХБ энэ салбарт хамгийн том оролцогч болсон юм.

ЭЗХАХБ-ын боловсролын салбарт хэрэгжүүлж буй стратеги зорилт

ЭЗХАХБ-ын боловсролын салбарт хэрэгжүүлэх стратеги зорилтод тодорхойлсноор улс орнууд боловсролын салбарт хамтран ажиллах гол үндэслэл нь улс орон бүр насан туршийн суралцахуйн чанарыг дээд түвшинд сайжруулах, ингэснээр хувь хүний хөгжил, эдийн засгийн тогтвортой өсөлт болон нийгмийн эв нэгдлийг бэхжүүлэх явдал юм. Хамтран ажиллах үндэслэлийг дараах дөрвөн зорилгод дэлгэрэнгүй тусгасан. Үүнд:

- Суралцагчид албан болон албан бус боловсролын орчинд суралцах боломж, бололцоогоор хангагдсан байх
- Боловсрол эзэмших эхний

(хамгийн наад зах нь) үе шатанд мэргэжлийн, чадвартай багшаар хангах

- Боловсролын институтууд өндөр чанартай, тэгш хүртээмжтэй, боломжийн үнэтэй, инновацлаг арга замаар суралцах боломжоор хангах ба бусад сургалтын орчин, байгууллагаар (ажлын байрыг оруулаад) баяжуулж, түншилж ажиллах
- Боловсролын тогтолцоо нь нийгэм, эдийн засгийн үр ашигтай ажиллах, шинэ тулгарах сорил бэрхшээлийг даван туулах, зохицох чадвартай байх

Боломж ба арга хэрэгсэл

Боловсролын зорилго бол хувь хүний болон нийгмийн хувьд суралцагчдыг чадавхжуулах, хүчирхэгжүүлэх (empower) явдал билээ. Нийгэм хувьсан өөрчлөгдөхийн хэрээр боловсрол дасан зохицох шаардлагатай болно. Боловсролын тогтолцоо нь суралцагч бага наснаасаа эхлээд өндөр нас хүртэл насан туршдаа өөрсдийгөө нээн хөгжүүлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, хандлага, үнэ цэнийг хамгийн тохиромжтой байдлаар эзэмшүүлэхийг зорьдог. Хувьсан өөрчлөгдөж буй нөхцөл байдлын дунд суралцагч сурах олон хэлбэрүүдээс эзэмшиж (agency) багштайгаа хамтран ажиллах (co-agency) ёстой юм. Суралцагч нийгмийн харилцаанд идэвхтэй оролцож, хувь нэмрээ оруулах үүргээ ухамсарлаж, зорилгодоо хүрэхийн тулд ирээдүйгээ тодорхойлж, түүнийхээ төлөө идэвхтэй ажиллан, суралцахуйгаа түүндээ чиглүүлэх чадварт суралцах шаардлагатай. Суралцахуйгаа болон амьдралаа удирдан чиглүүлэх чадварыг эзэмшсэн байдал нь боловсролын тогтолцооны чадавхын үр дүнг

илэрхийлнэ. Албан боловсролын институт болон өөрөө сонгон, бие даан суралцах албан бус боловсролын сувгуудаар дамжуулан суралцагч өөрийн суралцахуйн замналыг (learning trajectory) төлөвлөж, хариуцлага үүрнэ.

Иймээс уламжлалт мэдлэгээс гадна илүү өргөн, олон талыг хамарсан чадвар, хандлага, үнэ цэнэ болон метатанин мэдэхүйн чадварыг хөгжүүлэх болж байна. Гэвч арга хэмжээ авах, үйлдэл хийх хэрэгслүүдийг (agency) ашиглан өөрийн суралцахуйн түүх намтрыг (learning biography) тодорхойлоход тэдэнд чиглүүлэг дэмжлэг зайлшгүй хэрэгтэй. Албан боловсролын орчинд суралцагчийн өмнө сурч эзэмшсэн зүйлсийг хүлээн зөвшөөрч, дүйцүүлэх боломжтой байх ёстой ба ингэснээр институтийн/албан боловсрол болон албан бус боловсролын хооронд хийдэл гарахгүй үргэлжлүүлэн сурах боломжтой болно.

Цар тахлын үр нөлөөгөөр суралцагчийн эрх мэдлийн (empowerment) ач холбогдол нэлээдгүй өссөн. Цар тахал нь боловсролын тогтолцоо хэр уян хатан байж, хүнд нөхцөл байдал тулгарсан хэдий ч суралцах боломжоор хангаж чадаж байгаа эсэхийг шалгасан сорил байсан бол суралцагч суралцахуйгаа хэрхэн удирдаж, уян хатан хандаж чадаж байгаа эсэхийг шалгаж харууллаа. Танхимын сургалт хэвийн хэмжээнд эргэн сэргэсэн ч цар тахлын үеийг давж туулсан туршлагаас харахад сургууль болон багш нар өөрийгөө удирдах, үйлдэл хийх, арга хэмжээ авах арга хэрэгслүүдийг (agency) эзэмших, мета-танин мэдэхүйг хөгжүүлэх хэрэгтэйг нотоллоо.

Үүний зэрэгцээ боловсролын тогтолцоо нь тэгш боломжоор хангах, тэгш хамруулах зарчмыг баримталж, нийгэм, соёл, угсаатны байдлын хувьд ялгаатай суралцагчдыг тэгш хамруулах тал дээр сорилт бэрхшээлтэй тулгарч

байна. Бүхий л улс орон өндөр мэдлэг шаардсан эдийн засаг, нийгэм руу шилжиж байгаа өнөө үед боловсролын тогтолцоо нь тэгш хүртээмжтэй байдлыг хангаагүй тохиолдолд авьяас чадварыг нээж, хөгжүүлж чадахгүйд хүрнэ. Цар тахлын үр нөлөөгөөр боловсролын тэгш бус байдал үлэмж нэмэгдсэн. Ар гэрийн боломжтой, эдийн засгийн болон соёлын нөөц бололцоотой суралцагчдын суралцахуй хэвийн явагдаж, зарим тохиолдолд илүү сайжирсан байхад бололцоо муутай, эмзэг бүлгийн суралцагчид нэлээдгүй хохирлоо. Танхимын сургалт тасалдах үед нийгэм, олон нийтээс дэмжлэг үзүүлэх боломжгүй болж, эмзэг бүлгийн суралцагчдад ар гэр, ойрын хүрээллээсээ маш бага дэмжлэг авсан байна. Цар тахлын өмнө ч сорилт бэрхшээл болон тулгарч байсан тэгш хүртээмжийн асуудал цар тахлын үед улам том асуудал боллоо.

Мэргэжлийн сурган хүмүүжүүлэгчид

Хэдийгээр ирээдүйд бие даасан, технологид суурилсан, юуг, хэрхэн сурахаа өөрөө шийддэг суралцахуй илүү давамгайлах хэдий ч суралцахуй нь суралцагч бусад оролцогчидтой (үе тэнгийнхэн, багш, сурган хүмүүжүүлэгч, дасгалжуулагч, ментор гм.) нийгмийн харилцаанд орох үйл явц юм. Багш гэдэг нь суралцахуйн орчныг бүрдүүлж, төлөвлөдөг мэргэжилтэн бөгөөд мэргэжлийн олон янзын арга барилаар суралцахуйд дэмжлэг үзүүлнэ. Багш өөрийн зааж буй агуулга болон суралцагч хэрхэн суралцдаг талаар гүнзгий мэдлэг, ойлголттой байх хэрэгтэй ба суралцахуйг хэрхэн чиглүүлж, нөхцөлдүүлж, дасгалжуулахаа сайн мэддэг байх хэрэгтэй. Боловсролын ажиллах хүчний үндсэн бүрэлдэхүүн нь багш бөгөөд боловсролын тогтолцооны тэргүүн шугамд

ажилладаг мэргэжилтний хувьд асар их академик мэдлэг болон туршлага хуримтлуулсан байдаг.

Багшийн мэргэжлийг хөгжүүлэх нь төрийн бодлогын нэгэн чухал зорилт байдаг. Багшийн мэргэжлийн бодлогод дараах зүйлс тусгагдах учиртай. Үүнд, чадварлаг багш нарыг ажилд авах, тогтвор суурьшилтай ажиллуулах; багш бэлтгэх болон мэргэжлийн тасралтгүй хөгжлөөр хангах; шинэ багш нарыг халамжлан хүмүүжүүлэгчид (ментор) хариуцуулан, ажилдаа дасан зохицоход нь туслах; анхдагч сургалтад хамруулах; санхүүгийн хувьд зохих хэмжээнд цалинжуулж, өсөж дэвших боломжоор хангах; ажлын байрны нөхцөлийг нь зохицуулах; багшийн мэргэжилд итгэх олон нийтийн итгэл болон багшийн ажлын нэр хүндийг нэмэгдүүлэх гм. Үүний зэрэгцээ орчин үед боловсролын харилцаанд оролцож буй дасгалжуулагч, давтлагын багш зэрэг бусад мэргэжлийн сурган хүмүүжүүлэгчид болон суралцагчид, үе тэнгийнхний өөрсдөө зохион байгуулсан бүлгэм, хамт олны үүрэг, ач холбогдлыг мөн хүлээн зөвшөөрөх хэрэгтэй юм.

Боловсролын институт

Улс орнууд суралцагчдыг тодорхой институтэд хамруулан (СӨБ-ын байгууллага, ИДС, МБ олгох төв, насан туршийн боловсрол олгох төв), тодорхой цаг хугацаа, орон зайд төвлөрүүлж боловсрол олгосон хэвээр байна. Боловсролыг институтчилж, хүрээг нь сайжруулах, хэвээр байлгах нь төрийн бодлогын нэгэн чухал үүрэг бөгөөд энэ нь төрийн байгууллага тухайн боловсролын институтийг эзэмшдэг, эсхүл институтээр хангах ёстой гэсэн үг биш юм. Төр нь боловсролын салбарын бусад оролцогч талууд, түншүүдтэй хамтран

өндөр чанартай, тэгш хүртээмжтэй, сургалтын орчныг боломжийн үнэтэй, инновацлаг байдлаар бүрдүүлэх үүрэгтэй.

Боловсролын тогтолцоо

Олон улс орон улам бүр нэмэгдэж буй саад бэрхшээл, сорилттой тулгарч байгаа ч боловсролын тогтолцооны чанар, тэгш байдал, үр ашиг, инновацыг сайжруулах нь нэн чухал юм. Боловсрол өргөжин тэлж байхын эхэн үед бий болсон, уламжлалт дэд бүтэц нь орчин үеийн сургалтын арга хэлбэрт тохирохгүй болж байгаа бөгөөд үүнийг

шинэчлэх шаардлага тулгарч байна. Боловсролын салбарынхаа бүтээмжийг нэмэгдүүлэхийг оролдож буй улс орнуудын хувьд суралцагчид оногдох хувьсах зардал өсөж байгаагийн улмаас санхүүгийн үр ашигтай байдлыг хангах асуудал маш чухал байна. Улс орнууд КОВИД-19 цар тахлын үед хуримтлуулсан туршлагаасаа суралцан сургуульд суурилсан сургалт болон бусад алтернатив арга замыг хослуулан боловсролын тогтолцоогоо санхүүгийн хувьд илүү үр ашигтай, үр өгөөжтэй байдлаар ахин төлөвлөх шаардлага үүсжээ.

ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ АРГА ХЭЛБЭР



Энэхүү бүлэгт ирээдүйд чиглэсэн боловсролын салбарын олон улсын хамтын ажиллагааны дунд болон урт хугацааны боломжийг авч үзэх болно. Юуны түрүүнд боловсролын ирээдүйг эргэцүүлсэн гурван зарчмыг

тайлбарласан ба энэхүү гурван зарчмын үндсэн дээр олон улсын хамтын ажиллагааны шинэ арга хэлбэрүүд бий болох юм. Улмаар ирээдүйд чиглэсэн, хийх шаардлагатай ажлын чиглэлийг гурван хүчин зүйлээр

тодорхойлсон. Ирээдүйд чиглэсэн, инновацлаг олон улсын хамтын ажиллагааны амжилт эдгээр гурван чиглэлд гарах ахицаас шалтгаална. Эцэст нь бодлого боловсруулалтад зайлшгүй шаардлагатай хоёр хүчин зүйлийг танилцуулна. Дор үзүүлсэн зураг нь найман хүчин зүйлийн харилцан хамаарлыг харуулж байна.

Боловсролын болон суралцахуйн ирээдүйг эргэцүүлэхэд чиглүүлэх гурван зарчим

1. Суралцахуйд интеграцчилсан, тэнцвэртэй байдлаар хандах нь

Албан боловсролын зарчим нь танин мэдэхүйн хөгжил, мэдлэг эзэмших үйл ажиллагаатай шууд холбогдоно. Энэхүү зарчим нь сургуулийн боловсролын гол цөмийг бүрдүүлж ирсэн бол сүүлийн хэдэн арван жилд нэлээд шүүмжлэлд өртөж байна. Хийсвэр мэдлэг эзэмших нь чухал бус, харин суралцагч энэ мэдлэгээ хэрхэн хэрэглэх вэ гэдэг нь чухал болоод байна. Сурлагын амжилтын олон улсын үнэлгээ (PISA) болон түүний насанд хүрэгчдийн хувилбар болох Олон улсын насанд хүрэгчдийн чадварын үнэлгээ (PIAAC) амжилттай хэрэгжиж байна.



Эдгээр үнэлгээний ач холбогдол нь суралцагч/иргэн танин мэдэхүйн чадвараа бодит амьдрал дээр хэрхэн хэрэглэж байгааг судлаачийн байр сууринаас үнэлдэг явдал юм. Насанд хүрсэн иргэний насан туршийн суралцахуйн талаарх судалгаанаас харахад суралцахуй нь ажил, хөдөлмөр, нийгмийн харилцаа, бодит амьдралд нийцтэй, холбоотой байх шаардлагатайг харуулж байна. Судлагдахууны мэдлэгийг чухалчилдаг байсан боловсролын парадигмыг засаж залруулахад чадварт-суурилсан боловсрол чухал үүрэг гүйцэтгэсэн.

Үүний зэрэгцээ тархи судлалын шинжлэх ухаанд суралцах процесст хийсэн судалгаанаас харахад чадвар эзэмшихийн тулд суурь мэдлэгийг эзэмшсэн байх шаардлагатай ажээ. Юмсыг ухаалгаар цээжлэх, сэргээн санах дасгал хийх нь тухайн судлагдахууныг амжилттай судлахад чухал ач холбогдолтой байдаг байна. Судлагдахууны мэдлэг болон сэтгэх чадвар хоёрыг тэнцвэртэй эзэмших нь боловсрол болон PISA, PIAAC үнэлгээний өмнө тулгарч буй нэгэн чухал сорилт юм. Олон улсад сургалтын хөтөлбөрийн дизайн, хэрэгжилтийн туршлагаа харилцан хуваалцах нь маш өндөр ач холбогдолтой.

Сүүлийн жилүүдэд ЭЗХАХБ-аас зохион байгуулдаг үнэлгээний хүрээгээ өргөжүүлэн, сургалтын амжилтыг үнэлэхдээ академик мэдлэгийн үндсэн айгаас гадна бусад чухал айг багтаах болсон. 2015 оны PISA үнэлгээнд анх удаа асуудлыг хамтран шийдвэрлэх чадварыг хэмжээсжүүлэн нийгмийн чадварыг үнэлсэн нь олон улсын үнэлгээний хувьд анхны тохиолдол байлаа. Нийгэм сэтгэл хөдлөлийн чадварт суралцах нь танин мэдэхүйн айтай адил чухал юм гэдэгт анхаарал хандуулахад ЭЗХАХБ-ын энэхүү судалгаа анхдагч нь болж, чухал хувь

нэмэр оруулсан юм. ЭЗХАХБ-аас Нийгэм-сэтгэл хөдлөлийн Чадварын (SSES-Survey of Social and Emotional skills) судалгааг зохион байгуулсан нь нийгэм-сэтгэл хөдлөлийн чадварт суралцахуйн анхны олон улсын үнэлгээ байсан.

Нийгэм-сэтгэл хөдлөлийн чадварыг эзэмшүүлэх үүргийг гэр бүл, олон нийт, үе тэнгийнхэн болон сургууль хамтран хүлээнэ. Хувь хүний зан чанарыг зөв хөгжүүлэх нь олон нийтийн боловсролын гол чухал зорилго хэмээн зарим улс орон үзэж байхад зарим тогтолцоонд энэ тал дээр сургуулийн гүйцэтгэх үүргийн хувьд маргаантай байна. Гэвч сургууль энэ чадварыг дангаараа эзэмшүүлэх боломжгүй юм. Танин мэдэхүйн чадвараас ялгаатай нь нийгмийн чадварыг хөгжүүлэхийн тулд олон талын харилцаанд орж, олон янзын нөхцөл байдалд суралцах шаардлагатай. Сургуулиас гадуурх болон спортын үйл ажиллагаанд оролцох, олон нийтийн болон сайн дурын ажил хийх гэх мэт нь хүүхэд, залуучуудыг “хөгжүүлж” байдаг.

ЭЗХАХБ боловсролын үйл ажиллагаандаа нийгэм-сэтгэл хөдлөлийн суралцахуйг нэмж оруулсан нь маш том ахиц юм. Нийгэм-сэтгэл хөдлөлийн суралцахуйг анхааралдаа авахыг сануулсан гол дохио нь цар тахал байлаа. Сургуулиуд үйл ажиллагаа, арга барилаа огцом өөрчлөхөд уян хатан, тууштай, зорилгодоо үнэнч, өөрийгөө удирдах чадвартай сурагчдын хувьд эдгээр чанар нь давуу тал болж байв. Хямралын нөхцөл байдал үүсэхэд тухайн нийгмийн үзүүлэх хариу үйлдэл нь иргэдийн итгэл, хариуцлагатай байдал, бусдын оронд өөрийгөө тавьж үзэх сэтгэлээр тодорхойлогдоно. Зарим улс орон бусадтай харьцуулахад цар тахлын вирусыг илүү амжилттай тогтоон барьж, даван туулсны

шалтгааныг илүү нарийн судалгаагаар илрүүлэх нь тодорхой юм. Гэвч тухайн улсын иргэдийн биеэ авч яваа байдал, зан үйлээрээ үзүүлсэн хариу үйлдлээс харахад тэд өөдрөг, итгэл найдвараа алдалгүй уян хатан байж чадсан нь түлхүүр үзүүлэлт байж болох юм. Нийгэм-сэтгэл хөдлөлийн айн эдгээр болон бусад асуудлын талаар улс орнууд нээлттэй хамтран ажиллах хэрэгтэй ба энэ нь богино болон дунд хугацаандаа хэрэгжүүлэх стратегит ажлууд юм.

Гэвч мэдлэг, чадвар болон зан чанар дангаараа хүний суралцахуйг бүрдүүлдэггүй. Суралцахуйн нэн чухал бас нэгэн ай бол үнэ цэн, ёс суртахууны хэм хэмжээгээр дамжуулан ёс зүйг төлөвшүүлэх явдал билээ. Зарим улс орон үнэ цэнийг төлөвшүүлэх зорилготойгоор хөтөлбөрийн дизайндаа нэлээд гүнзгий тусгаж өгсөн байдаг боловч албан болон албан бус боловсролын орчин үүнд хэрхэн нөлөөлдөг нь тодорхойгүй, одоогоор нарийвчлан судлагдаагүй суралцахуйн нэгэн талбар юм. Үнэ цэн нь танин мэдэхүйн хүчин зүйлийг агуулдаг. Жишээлбэл, хэдийгээр сөрөг үр нөлөө нь холын ирээдүйд урган гарахаар байгаа хэдий ч цаг уурын өөрчлөлтөд санаа тавьж, яаралтай арга хэмжээ авах хэрэгтэйг ойлгож ухаарахын тулд хүрээлэн буй орчны талаар мэдлэгтэй байх хэрэгтэй. Гэхдээ цаг уурын өөрчлөлт, цар тахлаас гадна нийгмийн эв нэгдэл, дэлхий нийтийн хамтын ажиллагааг бий болгоход хувь хүний болон нийгмийн зорилго, түүний урт, богино хугацааны үр ашиг, давуу сул талыг бодож тооцоолох шаардлагатай. Ёс суртахууны ганхашгүй, гүн бат хэм хэмжээ, үнэ цэнийг эзэмшүүлэхэд танин мэдэхүйн болон танин мэдэхүйн бус хүчин зүйлс хэрхэн нөлөөлдгийг илүү нарийвчилсан судалгаагаар тогтоох нь зүйтэй. Бусдын оронд өөрийгөө тавьж үзэх, бусдад итгэх, хариуцлага

үүрэх, бусдыг хүлээн зөвшөөрөх зэрэг нийгэм, сэтгэл хөдлөлийн чадварууд үнэ цэнийг төлөвшүүлэх үндэс суурийг тавьж өгдөг. Жишээлбэл, PISA 2018 глобал цогц чадамжийн судалгаанд залуу үеийнхний нийгэм, сэтгэл хөдлөлийн айн хүчин зүйлсийг судалсан бөгөөд бусад соёлыг хэрхэн ойлгож, үнэлж хүндэлдэг болон соёл хоорондын хэлэлцүүлэгт хэрхэн үр бүтээлтэй оролцоход суралцах уялдаа холбоог авч үзсэн.

Боловсролын зорилгыг эргэн харахад хүргэж буй нэгэн хүчин зүйл бол хиймэл оюун ухаан (ХОУ) юм. ХОУ хөгжихийн хэрээр хүний суралцахуй болон хөгжлийг ахин тодорхойлох хэрэгцээ гарч байна. Компьютерын хүчин чадал болон хүний чадвар хоёр хэрхэн харилцан бие биеэ нөхөж байгааг илүү сайн ойлгож авах нь суралцагч юуг сурах шаардлагатай вэ гэдгийг тодорхойлоход онцгой чухал ач холбогдолтой. Ухаалаг тоног төхөөрөмж, алгоритмаар хийлгэх боломжгүй, хийлгэж болохгүй ямар үйлдэл, үйл ажиллагаа байна вэ? Олон чадварыг компьютероор орлуулаад ирэх үед “хүний” гэх тодотголтой ямар чадвар үлдэх вэ? Өдөр бүр шийдвэр гаргахдаа ёс зүйтэй хандах, шүүгчид хууль зүйн зохих шийтгэл оногдуулах, эмч хүн өвчтөний түүх, илэрч буй шинж тэмдгийг (заримдаа шинж тэмдэг нь бүрэн бус, бүр хоорондоо зөрчилдөх нь ч бий) үзээд хэрхэн оношлох вэ? Эсхүл уран бүтээлчийн гоо зүйн илэрхийллийг хэрхэх вэ? ХОУ хурдтай хөгжиж буй өнөө үед суралцагчид юуг зааж эзэмшүүлснээр тэд хөгжин цэцэглэх вэ? Хүнийг хүн болгож байгаа тэр мөн чанарт суралцах арга, боломжийг ХОУ хангаж өгч чадах уу? ЭЗХАХБ ирээдүйн хөгжлийн төлөв хандлагыг судалж, урьдчилсан таамаглал дэвшүүлдэг ба ирээдүйн хөгжил, цэцэглэлт, нийгмийн ахиц дэвшил, амьдралын чанарыг сайжруулахад хүний суралцахуй чухал

ач холбогдолтой хэвээр үлдэнэ гэсэн алсын харааг тодорхойлж байна.

ХОУ нь бидний суралцах суваг, арга хэлбэр, боловсруулалтыг бүхлээр нь өөрчилж байна. ХОУ-ы давуу тал, өгөгдөл, суралцахуйн аналитик үзүүлэлтүүдийг ашиглан хувь хүн рүү чиглэсэн, түүнд тохирсон суралцахуйг дэлгэрүүлэх нь зүйтэй юм. ХОУ болон цахим технологи нь боловсролын бүтээмжийг нэмэгдүүлж, бүхэлд нь хувирган өөрчилж чадна.

Суралцахуйн эцсийн үр дүн нь зан үйлээ өөрчлөх явдал юм. Мэдлэг, чадвар, зан чанар, хандлага, үнэ цэнийг бодит амьдралд хэрэглэж чадаж байгаа үед нийгэмд нийцтэй боловсролын үйлчилгээ бүрдэнэ. Амьдралд хэрэглэх чадвар нь автоматаар төлөвшдөг зүйл биш юм. Өдөр тутмын амьдралд танин мэдэхүйн болон танин мэдэхүйн бус түвшин өндөртэй хүмүүс зарим тохиолдолд бидний хүлээлтээс өөрөөр биеэ авч явах үе байдаг билээ. Амьдрал дээр бэрхшээлтэй тулгарсан үед хүн сурсан зүйл дээрээ тулгуурлан зан үйлээ өөрчлөх чадваргүй байх тохиолдол

маш их гардаг. Үүнийг танин мэдэхүйн үл нийцэл гэдэг бөгөөд энэ талаар нэлээдгүй судалгаа бий. Өнөөдөр болон ирээдүйд тулгарах бэрхшээлийг даван туулахад боловсролын янз бүрийн ай бүгд хэрэгтэй гэдгийг улс орнуудад зөвлөхдөө зөвхөн танин мэдэхүй, нийгэм-сэтгэл хөдлөл болон ёс зүйн чадварыг харьцуулан судлах нь хангалтгүй юм. Боловсрол энэ бүх айнуудыг хамтад нь хэрэгжүүлж, зан үйлийг өөрчлөхөд хэрхэн чиглүүлэх вэ гэдгийг анхаарч ойлгох хэрэгтэй. Тиймээс орчин үеийн боловсролд арга хэмжээ авах, үйлдэл хийх хэрэгслүүдийг эзэмшиж (agency) сурагч багш хамтран ажиллах нь (co-agency) чухал ач холбогдолтой юм. Дунд болон урт хугацаанд харахад, цаг уурын өөрчлөлтийн улмаас хүн төрөлхтөн хэрхэн өөрчлөгдөх вэ гэдгийг анхаарч ойлгох хэрэгтэй. Тиймээс орчин үеийн боловсролд арга хэмжээ авах, үйлдэл хийх хэрэгслүүдийг эзэмшиж шийдвэр гаргах хэрэгтэй болж байна. Үүний үндэс суурийг боловсрол тавьж өгөх билээ.

Боломжит саналууд

- Суралцахуйн үр дүнг үнэлэхдээ нийгэм-сэтгэл хөдлөлийн суралцахуйг хамт үнэлэх, гарсан үр дүнг сайжруулах талаар үнэлэлт дүгнэлт гаргах
- Үнэ цэн төлөвшиж, ёс зүйд суралцаж байгаа байдалд үнэлгээ хийх арга замыг эрэлхийлэх, гарсан үр дүнг сайжруулах талаар үнэлэлт дүгнэлт гаргах
- Хүний чадварыг компьютер, робот болон ХОУ-ы хүчин чадалтай харьцуулах, үнэлэх, урьдчилсан таамаглал дэвшүүлэх, сургалтын хөтөлбөрийн дизайнчлал, хөгжүүлэлтэд хэрхэн нөлөөлөхийг судлах
- Сургалтын үр дүнгийн үнэлгээний үр дүнг ашиглан сургалтын хөтөлбөр боловсруулалт болон боловсролын бодлого боловсруулахад холистик, тэнцвэртэй өнцгөөс зөвлөмж болгон хүргүүлэх

2. Насан туршийн суралцахуйг гол чиглэл болгох нь

Мэдлэгийн хэмжээ маш хурдтай өсөж байгаа өнөө үед мэдлэг шаардлагагүй болох нь ч хурдан байна. Шаардлагатай ур чадварууд ч өөрчлөгдөж байгаа учраас сургуульд сурсан зүйлээрээ насан туршдаа амьдарна гэдэг нь төөрөгдөл юм. Насан туршийн суралцахуйн зарчим шинэ зүйл биш бөгөөд бодлогын түвшинд хагас зууны туршид байсаар ирсэн боловч аажмаар нэр төдий болж бодлого, практикт хэрэгжсэн нь цөөн байна. Ажлын байр болон ажил мэргэжлийн шаардлагад цахимжилт, ХОУ хүч түрэн орж ирж байгаа өнөө үед насан туршийн суралцахуйн хандлагаа өөрчлөх хэрэгтэй юм. Цахимжилт нь ажлын байранд чадавхажих хөшүүргийг бий болгож, янз бүрийн чадварыг хөгжүүлэх боломжийг олгож байна. Судлаачдын үзэж байгаагаар цар тахлын улмаас ажиллах хүчний шилжилт (эдийн засгийн нэг салбараас нөгөө салбарт) ихээр явагдах төлөвтэй байгаа бөгөөд энэ нь ажилчид шинэ чадварт суралцах, чадвараа сайжруулах хөшүүрэг болох юм.

Бидний өдөр тутмын болон нийгмийн амьдрал улам ээдрээтэй, нарийн болж нийгмийн харилцаанд оролцох, иргэншлийн үүргээ биелүүлэх шаардлага өсөж буй учраас суралцах хэрэгцээ мөн нэмэгдэж байна. Гадаад хэл сурах, эсхүл цахим чадвар эзэмших явдал нэмэгдэж байгаа нь зөвхөн ажлын байртай холбоотой хэрэгцээ биш бөгөөд аялал жуулчлал, иргэний оролцоо зэрэг янз бүрийн шалтгаантай байж болно. Насан туршийн суралцахуйн өнцгөөс харахад ажлын хэрэгцээгээр суралцаж байна уу эсхүл нийгэм, соёл, хувийн сонирхлоороо сурч байна уу гэдэг ялгаа улам багассаар байна.

Насан туршийн суралцахуйг авч үзэхдээ насанд хүрэгчдийн сургалтад хамрагдах боломжийг нэмэгдүүлэх төдийгөөр хязгаарлаж болохгүй. Хүний бүхий л амьдралын туршид боловсрол болон чадвар олгох цаг хугацаа, давтамжийг тогтолцоогоор нь эргэн харж, ахин тодорхойлох шаардлагатай юм. Үүнд суралцах хамгийн эхний шатны боломжоос эхлээд дараа дараагийн боловсролын үе шатанд хамруулахыг багтааж үзнэ. Бүх насны хүмүүсийн суралцахуйн нь илүү цогц, ээдрээтэй байх тул бүх талаас нь харсан, ухаалаг зохион байгуулалт бүхий дэмжлэг шаардлагатай. Хувь хүн амьдралынхаа аль үед, юуг хамгийн сайн сурах вэ гэдгийг тогтоож, суралцах боломжийг амьдралынх нь туршид хэрхэн хуваарилж, нөөц бололцоогоор хангах вэ гэдэг нь бодлогын гол чиглэл болж байна.

Насан туршийн суралцахуйн зарчмын дагуу бид хүний амьдралын замнал, түүнд тохирсон боловсролын хийцийг эргэцүүлэх хэрэгтэй. Шүүмжлэлт сэтгэлгээний зарим чадварыг амьдралын эхэн үед эзэмшихэд илүү тохиромжтой. Тархи судлалын шинжлэх ухаан болон сургуулийн өмнөх боловсролын салбарт хийгдсэн судалгаагаар бага наснаасаа суралцаж эхлэх нь ирээдүй хойшдоо илүү хэрэгтэй ба суралцах боломжийг хязгаарлах нь засаж болшгүй хор хөнөөлтэйг нотолсон. Амьдралын эхний шатанд үндэс суурийг нь баттай тавьж өгч чадсан цагт ирээдүйд суралцах чадвар нь илүү үр дүнтэй байна.

Гэхдээ насан туршийн суралцахуйн суурийг тавьж байна гээд амьдралынхаа дөрөвний нэгийн эхний хэсгийн суралцахуйдаа бүх анхаарлаа хандуулах гэсэн үг биш юм. Амьдрал дээр гарахаасаа өмнө мэдлэг эзэмшдэг явдлыг илүү өргөн хүрээтэй, олон

янз байдалтай болгож ажлын байран дээр болон бусад нөхцөл хүрээлэлд, амьдралынхаа туршид суралцдаг болгон өөрчлөх хэрэгтэй. Гэсэн хэдий ч хөдөлмөр эрхлэхтэй холбоотой бодлого зохицуулалт, цалин хөлс олгох, нийгмийн халамж зэрэг бүхий л тогтолцоо уламжлалт суралцахуйд суурилсан, түүнд зохицсон байдалтай байна. Боловсрол эзэмшсэн гэрчилгээ нь насан туршдаа хүчинтэй байдаг байсан бол одоо хэрэглэж, харуулж байгаа мэдлэг, чадвар, хандлага үнэ цэнийг илүү нийцтэй гэж үзэж байна. Боловсролын үйл ажиллагаанд баримталдаг бусад олон зарчмуудыг бид өнөөдөр эргэн харах шаардлагатай болжээ.

Боловсрол эзэмшсэн болон мэргэшсэн түвшин, түүнийг батлах гэрчилгээ, нотолгоо нь орчин үеийн боловсролын тогтолцооны нэгэн чухал бүрэлдэхүүн юм. Аж үйлдвэржилтийн эрин үед гэрчилгээ, баримт бичиг нь ирээдүйн боловсролын зам мөр, хөдөлмөрийн зах зээл дээр гарах, ажил хөдөлмөр эрхлэх гол үзүүлэлт байсан. Боловсролын амжилтыг нь илэрхийлж, нийгэмд байр суурь ахих болон цаашдын амьдралдаа санхүүгийн тодорхой орлого, амжилтад хүрэхийн баталгаа байв. Маргаашийн мэдлэгт суурилсан эдийн засагт цахимжилт, ХОУ-ны үр нөлөөгөөр мэргэжилд тавигдах шаардлага, ур чадварын шалгуур байнга өөрчлөгдөж байгаатай холбоотойгоор боловсролын аль ч түвшний гэрчилгээ, нотолгооны ач холбогдол буурч байна. Өнөөдрийн байдлаар ЭЗХАХБ-ын гишүүн орнуудад ажиллах хүчнийх нь бараг 40% нь суралцаж эзэмшсэн мэргэжлээсээ өөр салбарт ажиллаж байна. Ажил олгогчид өнгөрсөн хугацаанд олж авсан мэдлэгийг нотлох гэрчилгээг харахаасаа илүүтэйгээр ажилтан одоо хэрэглэж, ашиглаж чадаж байгаа мэдлэг, чадвар, хандлага,

үнэ цэнийг шууд үнэлэхийг илүүд үзэх байдал ажиглагдаж байна. Боловсрол эзэмших уламжлалт замнал өөрчлөгдөн, хувь хүний хэрэгцээнд тохирсон байдлаар зохион байгуулах, хагас цагаар сурах, хослуулж сурах болон үнэлгээ гэрчилгээ олгох шинэ арга хэлбэр (цөөн цаг суралцаж гэрчилгээ авах сургалт/micro credentials, нано-зэрэг/nano degree, цахим ромбо/digital badge гм.) урган гарч байгаа нь үүнийг нотолж байна. Цар тахлын үед боловсрол олгож байсан арга хэлбэр, сувгаас харахад бид суралцагчийн албан, албан бус тогтолцоогоор болон өмнө сурсан мэдлэгийг хүлээн зөвшөөрөх, тооцох, дүйцүүлэх, гэрчилгээжүүлэх үйл явцыг эргэн харах нь зүйтэй юм. Эдгээр өөрчлөлт, шилжилтүүдээс улбаалан өнөөдрийн боловсролын тогтолцооны үндсэн шинж чанарыг эргэн харах хэрэгцээ урган гарч байна.

Сургалтын үр дүнг үнэлэх нь ЭЗХАХБ-ын боловсролын салбарт хийдэг ажлын гол бүрэлдэхүүн хэсэг бөгөөд өгөгдөл цуглуулах, харьцуулсан шалгуур боловсруулах, анализ дүгнэлт хийж, бодлогын зөвлөмж гаргах гол эх үүсвэр байдаг. Суралцахуйн замнал, үе шатыг өргөн хүрээтэйгээр, интеграцчилсан түвшинд ойлгож мэдсэний үндсэн дээр сургалтын үр дүнгийн үнэлгээг төлөвлөдөг. Одоогийн байдлаар ЭЗХАХБ заавал хамрагдах боловсролын төгсөх ангид (PISA үнэлгээг 15 настнуудаас), болон насанд хүрэгчдийн (PIAAC насанд хүрэгчдийн чадварын үнэлгээг 16-64 наснуудаас) үнэлгээ зохион байгуулж, мэдээлэл цуглуулахад төвлөрч байна. 5 настнуудын сургалтын үр дүн, хүүхдийн сайн сайхан байдлын

үнэлгээг анх удаа туршилтын байдлаар зохион байгуулсан. 10-15 настнуудын нийгэм-сэтгэл хөдлөлийн чадварын үнэлгээ боловсруулалтын шатандаа явж байна. Олон улсын өгөгдөл мэдээлэл бүх асуултын хариулт болж чадахгүй юм. Харин улс орнууд үндэснийхээ өгөгдөл, мэдээллийг харьцуулах, хэрэглэх тал дээр олон улстай хамтран ажиллах нь чухал ач холбогдолтой.

Дээрх асуудал, сорилууд бүх улс орнуудад тулгараад байна. Үүнийг даван туулахын тулд суралцах замнал, үе шатыг уян хатан болгох, үнэлгээ, гэрчилгээжүүлэлтийн шинэ арга хэлбэрийг бий болгож, ажиллах болон суралцахын зааг ялгааг багасгах зэргээр насан туршийн суралцахуйн зарчимд тулгуурлан боловсролын тогтолцоогоо шинээр дизайнчлах нь зүйтэй. Суралцахуйтай холбоотой гарах зардал болон түүний үр дүнг хувь хүн, бизнес аж ахуйн нэгжүүд, төр адил тэгш үүрэх/хүртэх үүднээс санхүүжилтийн асуудлыг эргэн харах хэрэгтэй. Санхүүжилтийг зохицуулахдаа төрөөс үзүүлж буй боловсролын үйлчилгээнд амьдралынхаа аль мөчлөгт, ямар арга хэлбэрээр хамрагдсанаас үл хамааран хувийн хөрөнгө оруулалт болон тэгш хүртээмжтэй байдал аль алиныг нь харгалзан үзэх нь зүйтэй. Эдгээр бэрхшээл нь эдрээтэй нарийн боловч бүх улс оронд адил төстэй хэлбэрээр тулгарч буй тул улс орнууд хамтран ажиллах, бодлого, туршлагаа хуваалцах, бодлогын хэрэгжилтийн үр дүнг олон улсад хяналт шинжилгээ хийх боломжтой юм.

Боломжит саналууд

- Суралцахуйн түүх, намтрын мөн чанар өөрчлөгдөж байгаа ба энэ нь эдийн засаг, нийгэм соёлын хувьд ямар үр нөлөөтэй байгаа талаар ойлголтыг нэмэгдүүлэх
- Суралцахуйн түүх намтрын онцгой чухал үе шатанд нь судалгаа, шинжилгээ хийхэд анхаарах, жишээлбэл, сургуулийн өмнөх боловсролын үе шат болон хамгийн чухал шилжилт хийгддэг үе шатууд
- ЭЗХАХБ-ын сургалтын үр дүнг үнэлдэг үнэлгээг амьдралын ямар мөчлөгт авах цаг хугацааны үндэслэлийг нарийн боловсруулах
- Боловсролын амжилтыг урамшуулдаг тогтолцооноос чадвар эзэмшилтийг мөн адил урамшуулдаг тогтолцоонд шилжих бодлого баримтлахад нь улс орнуудад дэмжлэг үзүүлэх
- Сурлагын ахиц, гэрчилгээжүүлэлт болон хүртээмжийн тухайд боловсролын уян хатан байдлыг сайжруулахад улс орнууд харилцан суралцах боломжоор хангах, бодлогын зөвлөмжөөр хангах
- Тэгш хүртээмжийг амьдралынх нь туршид хангах үүднээс төрийн санхүүжилтийн механизмыг шинээр эргэн харах талаар улс орнуудын хооронд хэлэлцүүлэг өрнүүлэх

3. Суралцахуйн нийгэмд үзүүлэх үр дүнг нарийвчлан судлах нь

Боловсролд хөрөнгө оруулах нь үнэ цэнтэй бөгөөд урт хугацаандаа өгөөжөө өгнө гэж үздэг учраас ЭЗХАХБ боловсролын салбарт үйл ажиллагаагаа явуулдаг. Энэхүү үзэл нь өнгөрсөн зууны явцад боловсрол өргөжин тэлэх үеэс үүдэлтэй. Ажил эрхэлж олох орлого нь эдийн засаг, нийгмийн үр ашгийн илэрхийлэл төдийгүй боловсрол болон суралцахуйн ач холбогдлыг харуулж байгаа хэрэг юм. Харин уламжлалт хүний капиталын онол нийцэхгүй болсон нь анхаарал татаж байна. Боловсролын эдийн засаг, нийгмийн үр ашгийг шүүмжлэлтэй өнцгөөс ахин үнэлэх хэрэгцээ шаардлага тулгарч байна. Жишээлбэл, дээд боловсрол эзэмшихэд эдийн засгийн давуу тал байна гэж үзэж болж байна. Учир нь хөдөлмөрийн зах зээл дээр туйлшрал бий болсонтой холбоотой бүрэн дунд боловсролын давуу тал буурч байгаа юм. ЭЗХАХБ-ын зарим гишүүн оронд бүрэн дунд, дээд боловсрол эзэмшсэн ажилчдын илүүдэл үүсэж, хэтэрхий өндөр боловсролтой, харилцан биесээ орлох боломжтой, эзэмшсэн чадвараас нь өөр чадвар шаардлагатай гэх мэт асуудал байгаа нь эдийн засгийн үр дүн болон боловсролын гэрчилгээний хоорондын уялдаа холбоог анхаарах болсныг илэрхийлж байгаа юм. Зарим улс оронд дээд боловсрол эзэмшсэнээс илүү мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшвэл хувь хүн, нийгэм, бүс нутаг болон тухайн улсад илүү ашигтай байна. Уламжлалт хүний капиталын онолоор дээрх үзэгдлүүдийг үндэслэлтэй, дүн шинжилгээтэй тайлбарлах боломжгүй юм. Боловсролын эдийн засгийн үр

ашгийг үнэлэх хүрээг шинэчлэх, эргэн харах ажлыг ЭЗХАХБ хийж байна.

Боловсролыг өргөн хэмжээгээр тэлж, технологийн хөгжилд ахиц гаргаж, ажиллах хүчин, эдийн засгийн салбарт мэдлэг, чадварыг ахиулах үүднээс оролтыг (input) нэмэгдүүлбэл бүтээмж өснө гэж тооцоолж болохоор байна. Гэвч ЭЗХАХБ-ын ихэнх гишүүн оронд бүтээмж бага, зарим тохиолдолд зогсонги байдалтай байна. Үүнийг дээд боловсролтой хүмүүсийн тоо ихсэж, шаардлагатай байгаа чадварын хэмжээ, тоо өсөхгүй байгаатай холбож тайлбарлаж болох юм. Үнэхээр ч насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдалтын судалгаа (IALS – Adult Literacy Survey), насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдалт, амьдрах чадварын судалгаа (ALL – Adult Literacy and Life-skills Survey) болон насанд хүрэгчдийн чадамжийн судалгаанаас (PIACC) харахад ихэнх улс оронд ажиллах хүчний бичиг үсэг тайлагдалт, тоо тооллын дундаж чадвар нэмэгдээгүй ба харин ахисан түвшний боловсрол эзэмшсэн хүний тоо ихээр нэмэгджээ. Хэт өндөр боловсролтой, шаардлагатай чадварыг эзэмшээгүй хүмүүс олширч, боловсролын зэргийн ач холбогдол унаж байгаагийн улмаас бүтээмж өсөхгүй, зогсонги байдалд орсон гэж үзэж болох юм. Боловсролын эдийн засгийн үр ашиг, давуу талыг зөв үндэслэлээр гаргаж ирэх нь стратегийн чухал ач холбогдолтой. Хэрэв бодлого боловсруулагчид болон хамгийн чухал талууд болох суралцагчид, гэр бүл болон ажил олгогчид боловсролын эдийн засгийн үр ашигт эргэлзэж эхэлбэл олон нийтийн итгэл буурч, боловсролд оруулах хөрөнгө оруулалт багасаж эхлэх эрсдэлтэй.

Хүний капитал нь голчлон эдийн засгийн бүтээгдэхүүн болдог бөгөөд боловсрол нь мөн нийгмийн капиталыг үйлдвэрлэдэг. Боловсрол зөвхөн мэдлэг, чадвар эзэмшүүлж, хандлага,

үнэ цэнийг төлөвшүүлэх бус мөн нийгмийн хэм хэмжээг тогтоож, нийгэм болон хувь хүмүүсийг хооронд нь нэгтгэж, сүлжээ холбоо, утга учрыг зааж сургадаг. Нийгэм улам задарч байгаа өнөө үед, жишээлбэл, хүмүүс дор бүрнээ өөрсдийн ертөнцдөө тусгаарлагддаг нийгмийн сүлжээний үр нөлөөгөөр, нийгмийн капиталыг бий болгох нь илүү үнэ цэнтэй байж болох юм.

Сүүлийн жилүүдэд ЭЗХАХБ боловсрол болон суралцахуйн нийгмийн үр дүнд анхаарч, хэлэлцүүлэг өрнүүлж байгаа нь боловсролын салбарын нэг амжилт юм. Эзэмшсэн боловсрол нь эрүүл мэнд, улс төрийн оролцоо, сайн дурын ажил, хүн хоорондын итгэлцэл болон бусад нийгмийн үр дүнд хэрхэн нөлөөлж байгааг нэлээдгүй судалж, хүлээн зөвшөөрсөн байдаг. Нийгмийн боломж, давуу талыг түгээн дэлгэрүүлэх гол хэрэгсэл нь боловсрол юм. Нөгөө талаар эрүүл мэнд, нийгмийн оролцоо болон амьдралын чанарыг тодорхойлох бусад хүчин зүйлсийн хүртээмж тэгш бус байгаа явдалд боловсролын оруулсан хувь нэмэр бас бий. Хүн амын дунд боловсролын нийгмийн үр дүн адил бус түвшинтэй байна гэдэг нь тэгш бус байдлыг илэрхийлж байна. Макро түвшинд авч үзвэл, нийгмийн эв нэгдэлд боловсролын үзүүлэх үр нөлөө өргөн утгаараа эерэг боловч нийгмийн хуваагдал, задралд хүргэж буй хандлага мөн байгааг ихэнх судлаачид хүлээн зөвшөөрдөг. Боловсролын нийгмийн үр нөлөө, давуу тал болон энэхүү үр дүн нь адил бус түвшинтэй байгаа талаар өгөгдөл мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийж, бодлогын зөвлөмж гаргах нь боловсролын салбарт хийх стратегийн чухал ач холбогдолтой ажил мөн юм.

Боловсролын эрүүл мэндэд үзүүлэх үр нөлөө нь маш чухал үзүүлэлт юм. Цар тахлын үед халдвар авах, вирусээр

өвчилж нас барах эрсдэлд орох эсэхэд эзэмшсэн боловсрол болон чадвар маш чухал нөлөөтэй байсныг нотлох баримт хангалттай байдаг. Эрүүл аж төрөх ёсны хэвшил нь (behaviour) мэдлэг, танин мэдэхүйн болон танин мэдэхүйн бус чадвар, үнэ цэн, хандлага зэрэг олон зүйлийн нэгдлээр, ихэвчлэн боловсрол болон суралцахуйгаар дамжин төлөвшинө.

Боловсролын шууд үр дүн нь ажил хөдөлмөр эрхлэх, орлого олох явдал мөн боловч эрүүл мэндийн үр дүн ч мөн боловсролын үр дүн юм. Боловсролын хөрөнгө оруулалтын гол чухал өгөөж гэдэг утгаараа эрүүл мэндийн үр дүн нь төрийн төсөв санхүүд маш чухал ач холбогдолтой үзүүлэлт юм.

Боловсролын үр дүнг зөвхөн эдийн засгийн үр дүнгийн үзүүлэлтээр бус нийгэмд үзүүлэх бусад үр нөлөөг харгалзан тооцоолох болсон нь том амжилт боловч ЭЗХАХБ-ын анализ шинжилгээнд авч үзсэн нийгмийн үр дүнгийн үзүүлэлт нь нийгмийн ахиц, амьдралын чанарын зөвхөн нэгэн хэсгийг харуулж буй юм. Жишээлбэл, ТХЗ-ын 4.7-д тусгагдсан хүрээлэн буй орчинд хандах хандлага, иргэншил, бусдын оронд өөрийгөө тавих чадвар зэрэг хүлээгдэж буй боловсролын үр дүнд бодлого талаасаа анхаарал хандуулж байгаа боловч судалгаа шинжилгээ хийгдсэн нь цөөхөн байна. Олон улс орны хувьд улс үндэстнийг нэгтгэн цогцлоох, шилжин суурьшигчдыг төлөвшүүлэх (identity development), шинэ соёлд дасан зохицох боломжоор хангах зэрэг боловсролын бусад зорилт мөн эн тэргүүнд тавигдаж

Боломжит саналууд

- ЕСО-той нягт хамтран ажиллаж боловсролын эдийн засгийн үр өгөөжийн шинжлэх ухааны хүрээг эргэн харах
- Бүтээмжийг нэмэгдүүлэхэд боловсролын түвшин болон чадвар эзэмшилтийн гүйцэтгэх үүрэг, ач холбогдлыг сайжруулах, ойлголтыг нэмэгдүүлэх
- Боловсролын үр дүн, ялангуяа эрүүл мэнд болон иргэншлийн үр дүнгийн талаар дүн шинжилгээ хийж, өгөгдөл мэдээлэл цуглуулах үйл явцыг бэхжүүлэх
- Улс орон, нийгэм, соёлын нэгэн хэсэг болохын хувьд суралцагч өөрийн хувь хүний шинж чанарыг нээн илрүүлэхэд боловсрол ямар үүрэгтэй оролцож байна вэ? Бид технологийн тусламжтайгаар амьдралаа улам бүр өөрийн хэрэгцээнд нийцүүлэн хэлбэржүүлэх боломжтой болж, хайпер-индивидуализм ажиглагдах болсон өнөө үед ямар нэгэн зүйлд харьяалагдах, олон нийт, нийгмийн утга учир юу вэ? Глобал цогц чадамжийг үнэлдэг PISA судалгаанд суурилан ЭЗХАХБ-аас боловсролын нийгэмд үзүүлэх бусад үр нөлөөг, жишээлбэл, ЭЗХАХБ-ын стратеги болон холбоо хамааралтай бусад салбарууд болох эрүүл мэнд, иргэний оролцоо болон хүрээлэн буй орчныг шинээр судлах
- Боловсролын нийгмийн зарим үр дүнг (эрүүл мэнд, улс төрийн оролцоо гм.) өргөнөөр хүлээн зөвшөөрдөг боловч танин мэдэхүйн айд суурилсан нийгмийн зарим үнэ цэн болох бусдын оронд өөрийг тавих, хүрээлэн буй орчинтойгоо харьцах хандлага зэргийг өргөнөөр хүлээн зөвшөөрөөгүй байна. Нийтгээрээ хандлага, зан үйлээ өөрчлөх, мэдлэгийг хамтаараа бүтээж, хамгийн чухал нь нийтгээрээ чадавхажиж, хариуцлага үүрдэг болоход боловсролын гүйцэтгэх үүрэг чухал ач холбогдолтой.

байна. Гэвч боловсролын үр дүнг бүрэн тооцох, ангилах зарчмын нэгдсэн үзэл баримтлал байхгүй ба энд эмпирик судалгааны стратеги боловсруулах боломжтой юм.

Боловсролын салбарт хүлээгдэж буй ирээдүйн гурван чиглэл

4. Суралцахуйн талаарх ойлголтыг сайжруулах

Эрүүл мэндийн салбар гэх мэт зэрэг төрийн бусад бодлоготой харьцуулахад боловсролын салбарын хувьд нотолгоонд суурилсан тогтолцоо төлөвшихөд нэлээдгүй хугацаа шаардагдсан. Багш, сургууль, бодлого боловсруулагчдын баримталж буй зарим мэдлэг нь одоо шаардлагагүй болсон. Боловсролын судалгаа тоо хэмжээ болон чанарын хувьд хязгаарлагдмал байдаг; мэдлэгээ хуваалцах, түгээн дэлгэрүүлэх, бодлогод тусгах процесс, үйл явц бүрэн хөгжөөгүй зэргийг энд дурдаж болохоор байна. Энэ нь суралцахуйн чанар, үр ашиг, боловсролын хөрөнгө оруулалтын үр ашигт чухал үр дагавартай. Өнгөрсөн хэдэн арван жилийн туршид боловсролын тогтолцоо өргөжин хөгжих явцдаа хамгийн сайн гэх магадлалтай тогтолцоог бүрэн ашиглаж чадаагүй байна. Жишээлбэл, эдийн засагчид болон сэтгэл зүйчид сургуулийн өмнөх насанд мэргэжлийн тогтолцоо, орчноор ханган суралцахуйг дэмжих нь онцгой чухал ач холбогдолтой болохыг саяхнаас л ярьж, ойлгож эхэлж байна. Хэл сурах болон тооллын зарчмыг хөгжүүлэх зэрэг бусад шинжлэх ухааны дэд салбаруудыг энд дурдах нь зүйтэй. Хүн хэрхэн суралцдагийг бид илүү сайн ойлгох болсон тул хуучны заах арга зүйн хандлагууд шүүмжлэлд өртөөд байна. Боловсролыг сайжруулж, боловсролын инновацыг дэмжих үүднээс суралцахуйн талаар судалгаа

шинжилгээ хийж, нотолгоо баримт цуглуулж бодлого, зөвлөмждөө тусгах нь чухал юм.

Сүүлийн үед техник технологи сайжирч, тархи судлалын мэсийн бус судалгаа болон мэдрэл судлалд хийгдэж буй шинэ нээлтүүдийн үр дүнд өмнө нь уламжлалт боловсролын шинжлэх ухаанд байгаагүй шинэ салбар бий болсон нь суралцахуйн үйл явцын туршилт, судалгаа юм. Тархи судлал, танин мэдэхүйн сэтгэл зүй, ХОУ болон холбогдох бусад шинжлэх ухааны дэд салбаруудыг багтаагаад суралцахуйн шинжлэх ухаан хэмээх шинэ салбар бий болж байна. Энэ салбар олон чухал нээлт хийж байгаа бөгөөд боловсролын бодлогод тусгах, практикт хэрэглэх оролдлогуудыг хийж эхэллээ. Шинэ юм сурах үед хүний тархинд ямар процесс явагддаг болохыг бид дөнгөж нээж илрүүлж байгаа бөгөөд шинжлэх ухааны шинэ салбар болохын хувьд суралцахуйн шинжлэх ухаан бүрэн хөлөө олглоо нэлээдгүй саад бэрхшээлийг даван туулах нь зайлшгүй. Харин үр дүнд нь бид хүн хэрхэн суралцдаг талаарх ойлголтоо нэмэгдүүлж, сургууль, анги танхимын институтчилэгдсэн суралцахуй хэрхэн явагддаг болохыг илүү сайн ойлгож авна. Суралцахуйг шинжлэх ухааны үндэслэлтэй судлахад танин мэдэхүйн хөгжил, амжилтад хүрэх мотивац, өсөх сэтгэлгээ (growth mindset) болон сайн сайхан байдлын хоорондын харилцан уялдааг авч үзэх нь чухал юм. Сүүлийн жилүүдэд дунд сургуулийн сургалтын нэгэн гол ай нь хүүхдийн сайн сайхан байдал болоод байна. Сайн сайхан байдлыг өнөөдрийн өнцгөөс үр өгөөжтэй, тогтвортой суралцах нийгэм, сэтгэл хөдлөлийн орчин нөхцөлийг бүрдүүлэх явдал хэмээн тодорхойлж байна. Нийгэм, сэтгэл зүйн байдал сайнгүй байгаа үед амжилттай суралцах боломжгүй юм. ЭЗХАХБ-ын боловсролын салбарт хийсэн сүүлийн үеийн ажлуудаас дурдвал сургуулийг

зэрэг уур амьсгалтай болгох, багш нар сурагчдыг дэмжиж ажиллах, дээрэлхэлтийн олон төрөл хэлбэрийн сөрөг үр нөлөө гм. сэдвүүдэд нэлээд анхаарал хандуулжээ. Хамгийн сүүлд авсан PISA үнэлгээгээр амжилтын мотивац, өсөх сэтгэлгээ болон амьдралд сэтгэл хангалуун байх зэрэг суралцахуйг эерэгээр нөхцөлдүүлдэг сэдвүүдэд төвлөрсөн болно.

Цаашид суралцахуйг дэмжих, илүү үр өгөөжтэй орчныг хэрхэн бүрдүүлэх, шинэ дизайн боловсруулах тал дээр судалгаа шинжилгээ хийгдэх нь зайлшгүй юм. Ирээдүйн сургалтын орчин суралцагч шаардлагатай арга хэмжээ авах, үйлдэл хийх чадварт суралцахад нь төвлөрч, суралцагч болон сурган хүмүүжүүлэгчийн гүйцэтгэх үүргийг шинээр тодорхойлох болно. Хүн хэрхэн суралцдаг судалгаа, түүн дотроо танин мэдэхүйн суурь болон дараагийн үе шат, суралцахуйн хамгийн мэдрэг үе шатын талаарх судалгаанд суурилан сургалтын хөтөлбөрийг ахин дизайнчлах боломжтой. Бусад шинжлэх ухааны салбарын адил энэ салбарт ч мөн адил олон улсын хамтын ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэх юм.

Боломжит саналууд

- Хүн хэрхэн суралцдагийг судалсан үр дүн, ахицыг боловсролын бодлого, туршлага, ялангуяа, боловсролын дизайн, багшийн мэргэжлийн мэдлэг, заах арга болон сургалтын хөтөлбөр боловсруулахад шилжүүлэн ашиглахад дэмжлэг үзүүлэх
- ЭЗХАХБ-аас багшийн хөгжлийн салбарт хийгддэг гол ажлын хүрээнд багшийн мэргэжлийн мэдлэгийн үнэлгээг бэхжүүлэх
- Сурлагын амжилтыг үнэлэх ажлын хүрээнд амжилттай багшлах, суралцахад нийгэм, сэтгэл хөдлөлийн нөхцөл байдлыг интеграцчилж харах өнцгийг хэвээр үргэлжлүүлэх
- Боловсролын үйл явц, түүний үр өгөөжтэй байдлын нэгэн чухал бүрэлдэхүүн болох сурагч, багшийн сайн сайхан байдалд төвлөрөх

5. Албан боловсролоос давж сэтгэх

Мэргэжлийн институтын орчинд албан боловсрол эзэмших нь ойрын ирээдүйдээ суралцахуйн зонхилсон арга хэлбэр хэвээр байх магадлалтай бөгөөд тодорхой цаг хугацаанд баригдан суралцах шаардлага одоо ч байсаар байна. Зориулалтын мэргэжлийн институтэд, сурган хүмүүжүүлэгчдийн дэмжлэгтэйгээр, төвлөрсөн байдлаар суралцах нь ихэнх тохиолдолд хамгийн үр дүнтэй байдаг. Гэсэн хэдий ч хүний суралцахуйн ихэнх хэсэг албан боловсролоос гадуур явагддаг гэдгийг мартаж болохгүй. Хамгийн эхний үе шатны суралцахуй гэр бүлийн хүрээнд, ойрын хүрээлэлд нь явагддаг. 15 настнуудын сурлагын үр дүнг үнэлэхдээ нийгмийн гарал үүслийг нь хамт авч үздэг нь сургуулийн болон сургуулийн гадна нөхцөлд хэрхэн суралцдагийг тодорхой хэмжээгээр хэмжээсжүүлэх оролдлого юм. Албан боловсролын орчноос гадуур нийгмийн харилцаанд орж, туршлага хуримтлуулах нь суралцагч сургуульд сурснаа бэхжүүлэх, дутуугаа нөхөж авах боломжоор хангадаг төдийгүй практик дээр суралцах нь сурч мэдсэнээ бодит зүйл гэдгийг мэдрүүлж, урам зориг өгдөг. Хүүхэд орон зайн мэдрэмжээ хөгжүүлэхдээ сургуульд сурсан геометрийн хичээлээ ашигладаг уу, гэртээ тоглож байсан тоглоом дээрээ суурилдаг уу, эсхүл амьдарч буй хотынхоо гудмаар алхаж, зүг чигээ олж хөгжүүлдэг үү? Орчин үеийн боловсролын тогтолцоонд энэхүү өргөн хэмжээний, янз бүрийн хэлбэрийн суралцах боломжийг хүлээн зөвшөөрч, танхимын сургалтын арга барилдаа тусгах хэрэгтэй юм.

Сургууль өөрөө мөн албан бус боловсролыг олгож байдаг ба сургуулийн орчны бүх зүйл “албан” боловсролын агуулгатай биш юм. Багш сурагчдынхаа төлөө санаа тавьж, тэднийг дэмжин

ажиллаж байгаа ба хүн хоорондын итгэлцэл, бусдын оронд өөрийгөө тавих хандлагыг төлөвшүүлэхэд хэрхэн нөлөөлж байгааг бодоод үзээрэй. Биесийн тамир, хичээлээс гадуурх үйл ажиллагаа, хүүхдүүд хоорондоо тоглож наадаж байгаа нь суралцагчийн суралцахуй болон сайн сайхан байдалд маш ихээр нөлөөлж байдаг.

Албан бус суралцахуй (non-formal) болон амьдралын орчинд суралцах (informal) зэргийг ухаж ойлгоход амаргүй зүйл бөгөөд өгөгдөл мэдээлэл цуглуулж, анализ шинжилгээ хийх, болон зарчмын хүрээг нь тодорхойлж өгөх шаардлагатай юм. Ажлын байрандаа суралцах болон тухайн хүрээлээсээ суралцах үйл явц нь албан боловсролтой хэрхэн холбогдож байгааг тогтоох үүднээс мэргэжлийн боловсрол сургалтын салбарт мөн судалгаа шинжилгээ хийгддэг. Сургуулийн өмнөх боловсрол болон халамжийн хүрээнд хийгддэг судалгааны хувьд албан болон албан бус тогтолцоогоор хатуу зааглагддаггүй суралцахуйн орчинд төвлөрч судалдаг. Нийгэм-сэтгэл хөдлөлийн чадварын судалгаа хийгдэж байгааг дээр дурдсан. Уг чадваруудыг эзэмшүүлэхэд гэр бүл, сургууль болон олон нийт ямар чиг үүрэгтэй оролцдогийг тогтоох зорилготой ба амжилт олохын тулд олон улсын хамтын ажиллагаа чухал юм. Суралцагч арга хэмжээ авах, үйлдэл хийх хэрэгслийг эзэмших (agency), суралцахуйн түүх намтар (learning biographies) болон насан туршийн суралцахуйгаас харахад суралцагч амьдралын янз бүрийн нөхцөл байдалд хуримтлуулсан туршлагаараа дамжуулан мэдлэг, ур чадвар, хандлага, үнэ цэнийг хөгжүүлдэг байна.

Амьдралын орчинд суралцахуй нь маш өргөн хүрээтэй бөгөөд нарийн судлагдаагүй талбар юм. Хүн хаана, ямар арга хэлбэрээр суралцдаг талаар бид тун бага зүйл мэдэх бөгөөд амьдралаас суралцаж буй мэдлэгийг

төрийн бодлогод тусгах, сайжруулах талаар бараг юу ч мэдэхгүй гэхэд болно. Гэсэн хэдий ч зарим нэг дэвшилт гарсаар байна. Ажлын мөн чанар, ажлын байрны чанар суралцахуй болон чадвар эзэмшилтэд эергээр нөлөөлдгийг бид олж тогтоосон. Насанд хүрэгчдийн чадамжийн судалгаанаас (PIAAC) харахад технологи их ашигладаг ажлын байранд суралцахуй болон хамтын ажиллагаа давуу зонхилдог байна. Хамтын ажиллагааг дэмждэг ажлын байранд хүмүүс харилцан бие биеэсээ суралцах боломж бүрддэг. Архитектур, хот төлөвлөлтийн бусад жишээ амьдралаас суралцахын ач холбогдлыг улам тодотгож байна. Хүрээлэн буй орчинд бие махбодоороо хүрч харьцаж, нэг цэгээс нөгөө цэгт хүрч, ээдрээтэй орчинд орон зайн баримжаагаа олох нь танин мэдэхүйн болон танин мэдэхүйн бус хөгжилд үр дүнгээ өгөх юм. Жишээлбэл, хотжилтын зарим хэлбэр, амьдарч буй орон сууц, орчин, хүрээлэн буй байгаль нь сөрөг зан үйлийг төлөвшүүлэх хандлагатай байдаг бол зарим нь эерэг нөлөөлөлтэй байдгийг бид мэднэ. Хэвлэл мэдээлэл, цахим төхөөрөмж, нийгмийн сүлжээ суралцахуйд хэрхэн нөлөөлдөг талаар чухал судалгаанууд бий. Цар тахлын үед олон хүмүүс гэртээ тусгаарлагдсан учраас амьдралын орчинд суралцах үйл явц нэмэгдсэн байх магадлалтай ба Google-ийн хайлтын сүлжээнд боловсролтой холбогдолтой асуулт, хандалт ихэссэн нь үүнийг нотолж байна. Энэ мэдээллийг бодлогын зөвлөмжид тусган амьдралаас суралцахуйг дэмжих нь амаргүй ажил боловч ирээдүйд энэ талбарт ихээхэн ажил хийгдэх

төлөвтэй байна. Эдийн засгийн зан үйлийн (behavioural economics) талбарт олсон ололтод тулгуурлан хүний тодорхой зан үйлд нөлөөлөх оролдлогын талаар судлах нь мөн сонирхолтой санаа байж болох юм. Боловсролын дэд бүтцэд хөрөнгө оруулж өргөжүүлэх нь ховор байдаг улс орнуудын хувьд бүрэн тогтолцоогоор нь өөрчлөх, хэрэгжүүлэх боломж бага байдаг тул харилцан мэдлэг, туршлагаа хуваалцах нь маш чухал ач холбогдолтой юм.

Боломжит саналууд

- Хүн хэрхэн суралцдагийг судалсан үр дүн, ахицыг боловсролын бодлого, туршлага, ялангуяа, боловсролын дизайн, багшийн мэргэжлийн мэдлэг, заах арга болон сургалтын хөтөлбөр боловсруулахад ашиглахад дэмжлэг үзүүлэх
- Сургалтын үр дүнг үнэлэхдээ суралцахуйн бусад арга зам, суваг, сургалтын орчны оруулж буй хувь нэмрийн тухай ойлголтыг сайжруулах
- Сургууль нь албан боловсролоос гадна амьдралаас суралцах (informal) боломжийг мөн адил олгодог талаарх ойлголтыг сайжруулж, сургуулийн эерэг орчныг хэрхэн амжилттай бүрдүүлэх тал дээр бодлогын зөвлөмж боловсруулах
- Олон нийт, иргэний нийгмийн байгууллага болон хэвлэл мэдээллийн хүрээнд албан болон албан бус боловсрол, амьдралаас суралцах суралцахуйн уялдаа холбоог хангах, бэхжүүлэх
- Албан бус боловсрол болон амьдралаас суралцахуйн талбарт цахимжилтыг сайжруулж, илүү өргөжүүлэн, хөгжүүлэхэд анхаарах

6. Тэгш хүртээмжтэй бөгөөд тэгш хамруулах боловсролын шинэ хандлагыг хөгжүүлэх нь

Боловсролын тэгш хүртээмжийн асуудалд бодлогын түвшинд маш их анхаарал хандуулдаг бөгөөд ингэхээс ч аргагүй юм. Боловсрол өргөжин тэлснээр суралцагчдад илүү их боломжийг бий болгосон боловч сургуулийн тогтолцоо нь ялгаварлан гадуурхалт, ялгаатай байдлыг бий болгодог талтай. Гэр бүлийн гарал үүсэл нь тухайн суралцагчийн боловсрол эзэмших үйл явц, амжилт, бүтэлгүйтэл болон нийгэмд эзлэх байр суурийг тодорхойлж байна. Энэ нь боловсрол өргөжин тэлэх гол үзэл санаа болсон авьяас, зүтгэл, чадвартай байхад нийгмийн байр суурь өснө гэсэн итгэл, хүлээлттэй зөрчилдөж байгаа юм. Боловсролын тогтолцоо тэгш хүртээмжтэй байснаар суралцагчийн сурлагын амжилт, чадавх нь түүний хүйс, үндэс угсаа, цагаач эсэх, тусгай хэрэгцээтэй эсэх гм. хувийн болон нийгмийн нөхцөл байдлаас үл хамаарна гэдгийг баталж чадна. Гэсэн хэдий ч боловсрол нь бүхий л талбартаа тэгш хүртээмжтэй, тэгш хамруулсан байж, суралцагч бүрд амжилттай суралцах нөхцөлийг бүрдүүлж, тэдний олон янз байдлыг хүлээн зөвшөөрч чадаагүй байна. Мэдлэгт суурилсан өнөөгийн нийгэмд хэн нэгнийг боловсролоос гадуур үлдээснээс үүдэх нийгмийн макро түвшний зардал тун өндөр юм. Учир нь авьяас чадварыг нээж, хөгжүүлж чадалгүй үрэн таран хийх төдийгүй боловсролд бүтэлгүйтвэл ирээдүйд нийгмийн халамж, хамгаалалд илүү их мөнгө зарцуулна. Үүнээс улбаалан боловсролын тэгш хүртээмжийн асуудал академик болон бодлогын хүрээнд өргөнөөр яригддаг сэдэв юм.

Тэгш хамруулах боловсролын тогтолцоо нь суралцагч бүрийг анхааралдаа авч,

олон янзын хэрэгцээг нь харгалзан үзэж, тухайн хувь хүний үнэ цэнийг өөрт нь ойлгуулж, бусдадаа болон нийгэмдээ харьяалагдах мэдрэмжийг төрүүлэхийг зорьдог. Одоогийн байдлаар боловсролын тэгш хүртээмжийг ярихдаа голчлон суралцагчийн хүйс, нийгэм эдийн засгийн байдал, эцэг эхийн боловсрол, ажил мэргэжил болон соёлын чадавх (жишээ нь PISA), эсхүл эцэг эхийн боловсрол эзэмшсэн түвшин (жишээ нь PIAAC) нь сурлагын амжилт, үр дүнд хэрхэн нөлөөлж байгааг хөндөж байна. Суралцагч болон түүний гэр бүлийн эдийн засаг, нийгэм, соёл болон боловсролын боломж, нөөц бололцооноос суралцагч боловсролын үр шим хүртэж буй эсэх, цаашлаад сурлагын амжилт хамаарч байна.

Нөлөөтэй гэж үзэж буй хүчин зүйлсийг илүү өргөжүүлж, жендэрийн хэвшмэл ойлголт, нийгэм соёлын олон янз байдал, шилжин суурьшсан эсэх, газар зүйн байршил, нас зэргийг харилцан хамааралд нь авч үзэх нь зүйтэй юм. Охид хөвгүүдийн мэргэжил болон боловсролыг сонгоход жендэрт суурилан оногдуулсан үүрэг, хэвшмэл ойлголт маш том нөлөө үзүүлдэг. Олон улс оронд охид STEM боловсрол гм. хөвгүүд ихэвчлэн сонгодог боловсролын замнал, мэргэжлээс зайлсхийсэн хэвээр байна. Боловсрол эзэмших боломж тодорхой нэг байрлалд төвлөрдөг учир орон зайн хувьд тусгаарлах нь боловсролын боломжийг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Хот хөдөөгийн хуваагдлаас гадна байрлал болон газар зүй хэрхэн нөлөөлдөг болох, эдгээр нь нийгэм-эдийн засгийн байдал, шилжин суурьшсан байдал зэрэг бусад хүчин зүйлстэй хэрхэн холбогдож байгаа талаар бидэнд мэдэх зүйл бага байгаа билээ.

Зарим судлаачдын үзэж байгаагаар боловсролын тэгш бус хүртээмж нь дан ганц боловсролын тогтолцооноос үүдэлтэй асуудал биш бөгөөд харин

нийгмийн бүлгүүдийн зорилго, зан үйлээс шалтгаалж байна (жишээ нь дундаж давхаргынхан бүх боломжийг өөртөө ашиглах, бусдад боломж олгохгүй байх – opportunity hoarding). Зарим судлаач суралцагчийн суралцах болон оюун ухааны чадварыг харгалзан үзэхгүй байгаагаас тэгш бус хүртээмжийн асуудал үүсэж байна гэж үзэж байна. Генетикийн өгөгдөл болон амьдралын эхэн үеийн (төрөхийн өмнөх үеийг хүртэл оруулаад) нөхцөл байдал нь танин мэдэхүйн чадварт нөлөөлж байгааг судалсан шинжлэх ухааны ололтуудаас харахад хувь хүний оюун ухааны түвшний ялгаатай байдал нь нийлбэр үзүүлэлтээрээ тэнцвэртэй гардаг гэсэн аксиомыг үгүйсгэж байна. Тэгш хүртээмжийг хөндөж байгаа үед генийн үзүүлэлт буюу суралцахуй болон хөгжил нь бидний генийн илрэл (генийн материалын нэгээхэн хэсэг илрэн гарч байгаа) гэдгийг, оюун ухаанаа хөгжүүлж байгаа байдалтай нь холбоотой гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Энэ нь суралцахуйд, ялангуяа, бага насны суралцахуйд маш чухал нөлөөтэй. Энэ нь боловсролын тогтолцоонд илүү өргөн хүрээгээр хөрөнгө оруулах шаардлагатайг харуулж байгаа бөгөөд ар гэр нь боловсролд нь бага хөрөнгө оруулдаг суралцагчийн хэрэгцээг илүү сайн хангаж чадна гэсэн үг юм. Ийнхүү үүсэн гарч буй академик хэлэлцүүлэг нь бодлогын түвшинд чухал ач холбогдолтой. PISA-ийн судалгаанаас харахад улс орны түвшинд тэгш хүртээмж, өндөр амжилт хоёрын аль нэгийг сонгох аргагүй юм. Зарим улс орон хоёуланд нь ахиц, амжилт үзүүлсэн байхад зарим улс оронд хэдийгээр бодлогын түвшинд арга хэмжээ авсан ч сурлагын амжилт доогуур, тэгш бус хүртээмж оршин байсан хэвээр байна. Иймээс тэгш хүртээмжтэй байх, тэгш хамруулах асуудлыг илүү цогц хүрээнд авч үзэх шаардлагатай.

Цар тахлын үед тэгш бус байдал улам өссөн. Танхимын сургалт зогссоноос үүдэлтэй сурлагын хоцрогдол, сурагчийн сайн сайхан байдал хэрхэн буурсныг судалж үзэхэд сурагчдын дунд тэгш бус байдал өссөн үзүүлэлт ахин дахин гарч байна. Гэрээс хичээллэх, зайн сургалтад хамрагдах нөөц бололцоо дутмаг, интернэтэд холбогдоогүй, гэртээ хичээлээ хийх чимээгүй орчин байхгүй, цахим хэрэгсэл болон эцэг эхийн дэмжлэг чиглүүлэг дутмаг, багш нарт үзүүлэх мэргэжлийн туслалцаа дэмжлэг дутмаг зэрэг шалтгааны улмаас эмзэг бүлгийн, сурлагадаа тааруу сурагчид хүнд хэцүү цаг үеийг даван туулаа. Цар тахлын хямрал зөвхөн орлого багатай, ганц бие аав ээжтэй суралцагчид нөлөөлөөд зогсохгүй, янз бүрийн нөхцөлийн суралцагчдад нөлөөлсөн. Цагаач, дүрвэгч, үндэсний цөөнх, уугуул үндэстэн суралцагчид, тусгай хэрэгцээтэй суралцагчид биеэр очиж боловсролд хамрагдах боломжгүй болсноос гадна сургуулиас үзүүлдэг нийгэм, сэтгэл хөдлөлийн дэмжлэг болон үдийн цай зэрэг нэмэлт үйлчилгээ байхгүй болсон. Ингэснээр тэд сурлагаар улам хоцрогдож, илүү тусгаарлагдах эрсдэл өндөр байна. Цар тахлын хямралын үеэр ар гэрийн боломжтой айл өрхүүд нэмэлт арга хэмжээ авч эхэлсэн ба сүүдрийн боловсролын үйлчилгээ, хувийн багштай давтлага зэргийн тоо эрс нэмэгджээ. Гэвч боломж бололцоогүй ар гэрийн хувьд санхүүгийн болоод соёлын хүчин зүйлийн улмаас нэмэлт үйлчилгээ авах боломжгүй юм. Боловсролын үйлчилгээ хэвийн байдалдаа эргэн орох үед алдагдсан боломжийг нөхөхөд, ялангуяа, эмзэг бүлгийн суралцагчдад онцгой анхаарал хандуулан ажиллах хэрэгтэй. Ийм нөхцөл байдал ихэнх улс оронд тулгарсан тул харилцан бие биеэсээ суралцах нь маш чухал юм.

Боломжит саналууд

- Боловсролын тэгш хүртээмж, тэгш хамран сургах талаар цогц судалгаа хийх
- Суралцахуйн тэгш бус боломж хэрхэн илэрч байгааг, зарим бүлгийн суралцагчид хэрхэн боловсролоос гадуур хоцорч байгааг илрүүлж, боловсролын тэгш хүртээмж, тэгш хамруулалтыг нэмэгдүүлэх бодлогын зөвлөмж боловсруулах
- Улам олон янз байдалтай болж буй нийгэмд боловсрол эзэмших боломжийг илүү сайн ойлгуулах үүднээс тэгш хамруулалт болон тэгш хүртээмжийн сайн туршлага аль алиныг нь, тэдгээрийн харилцан огтлолцлыг судлах. ЭЗХАХБ энэ талбарт хэлэлцүүлгийн хүрээг тогтоож, чиглүүлэхэд хувь нэмрээ оруулж болно. Боловсролын тэгш хүртээмжийг хил хязгаараас үл хамааралтай болгох ямар арга зам байна вэ?
- Нийгмийн бүлгүүдийн хоорондын хуваагдлыг илүү нэмэгдүүлэхгүй байх үүднээс технологийн инновац нь тогтолцооны тэгш бус байдлыг бууруулахаар дизайнчилагдсан байхаар чиглүүлэх
- Боловсролын тэгш хүртээмжийг дэмжсэн бодлого, туршлагын үр өгөөжийг эргэн харж улс орнууд инновацлаг бодлогоо хуваалцаж, харилцан суралцахыг дэмжих

Бодлого боловсруулахад зайлшгүй шаардлагатай хоёр хүчин зүйл

7. Боловсролын үр ашгийг нэмэгдүүлэх

Төсвийн хувьд улс орнуудын өмнө бэрхшээл тулгарсан хэвээр байна. Төрийн өр зээл өндөр байгаа үед төрийн бусад салбарууд болон боловсролын салбарын зардал мөн өсөх бөгөөд энэ нь ирээдүй хойч үед дарамт болж очно. Хүн ам зүйн өөрчлөлтөөс үүдэлтэй эрүүл мэнд, өндөр настны асаргаа, сайн сайханд зориулсан зардал болон цаг уурын өөрчлөлттэй холбоотой зардал мөн нэмэгдэх төлөвтэй байна. Боловсролын үр өгөөжийг сайжруулах, өгөөж нь зардлаасаа давахыг шаардсан шүүмжлэл өсөх хандлагатай байгаа бөгөөд боловсролын тогтолцоо үүнд бэлэн биш байна. Боловсролын зардал харин ч өсөх шинжтэй байна. ЭЗХАХБ-ын ихэнх гишүүн орнууд сүүлийн 20 жилд боловсролын санхүүжилтээ нэлээд хэмжээгээр өсгөсөн боловч ихэнх тохиолдолд сурлагын амжилтын хэмжигдэхүйц ахиц мэдэгдээгүй. Нэмэлт санхүүжилтийн тодорхой хэсгийг анги дүүргэлтийг багасгах зэрэг арга хэмжээ авахад зарцуулсан бөгөөд боловсролын үр дүнд мэдрэгдэхүйц ямар нэгэн өөрчлөлт гараагүй байна. Бусад салбарт технологийг өөрсдийн зориулалтад ашиглаж бүтээмжээ нэмэгдүүлсэн байхад боловсролын бүтээмжийн хувьд ийм амжилт одоогоор ажиглагдаагүй байна.

Зардал өсөж, бүтээмж нэмэгдэхгүй хэвээр байж, чанар буурсан эсвэл зогсонги байдалд орсон, санхүүжилтийн өгөөж тодорхойгүйн дээр гаднаас ирж буй үр ашгийг нэмэгдүүлэх шахалт, шаардлага нь боловсролын тогтолцооны хувьд том

бэрхшээл болж байна. Боловсролын оролт, гаралт, хувиргалтын шатанд хаана нь учир шалтгаан нь байгааг тодорхойлоход хэцүү ч улс орон даяар боловсролын бүтээмж хаана, ямар ялгаатай байгааг олж тогтоох нь бодлого боловсруулахад онцгой чухал ач холбогдолтой юм. Үр ашгийг нэмэгдүүлэх нь бодлогын түвшинд яригдах хамгийн чухал асуудлын нэг бөгөөд олон улсын түвшинд харилцан суралцаж, дүн шинжилгээ хийж, бодлогын хэлэлцүүлэг зохион байгуулах нь зүйтэй юм.

Боломжит саналууд

- Боловсролын үр өгөөжийг нэмэгдүүлэх арга замыг эрэлхийлэх үүднээс улс орнууд хамтран ажиллах
- Бага зардлаар их өгөөж хүртэхийн тулд зардлын шийдвэр гаргах талаар бодлогын өөр бусад хувилбаруудыг боловсруулах

8. Боловсролын инновацийг тууштай дэмжих

Боловсролын тогтолцоонд үзүүлж буй шахалт, шаардлага нэмэгдэх үед зарим тохиолдолд шинэ зүйл турших, инновац хийх боломж гардаггүй ба өнгөрсөн үед амжилттай хэрэгжиж байсан арга зам руугаа эргээд орох хандлагатай байдаг. Энэ нь олон учир шалтгаантай юм. Өөрчлөлт шинэчлэл хийлээ гэж үзэхэд ихэнх тохиолдолд энэ нь хэнд, хэр их ашигтай гэдэг нь тодорхойгүй байдаг. Ялангуяа, боловсролын салбар

суралцагч, эцэг эх, багш, ажил олгогч, үйлдвэрчний эвлэл гэх мэт маш олон оролцогч талтай тул үр ашиг нь илүү тодорхойгүй байдаг. Боловсролын тогтолцооны дэд бүтэц маш нүсэр, төрийн хэд хэдэн шат дамжлагыг өөртөө багтаадаг ба шат дамжлага бүрд зардлыг танах, өөр тийшээ шилжүүлэхийг эрмэлздэг тул өөрчлөлт шинэчлэл хийхэд шаардагдах зардал хаанаас гарах нь мөн тодорхойгүй байдаг. Боловсролын шинэчлэлийн мөн чанар, хэмжээ, хуваарилалтад нөлөөлөх маш олон хүчин зүйлс байдаг тул шинэчлэлтэй холбоотой үүсэн гарах зардал, түүний үр ашгийг тооцоолоход хүндрэлтэй байдаг. Боловсролын шинэчлэлийн богино хугацааны үр ашгийг тодорхой тооцоолоход хэцүү байдаг. Ялангуяа, шинэ бодлого хэрэгжүүлэх, түүний үр дүнг харахын тулд маш их цаг хугацаа зарцуулдаг. Шинэчлэлийн хөрөнгө оруулалт нь урт хугацаандаа маш өндөр зардалтай байдаг.

Боловсролын үйлчилгээ үзүүлдэг, ихэнхдээ төрийн хөрөнгө оруулалттай олон байгууллага, тогтолцоо байгаа нь боловсрол эзэмших сонирхол, хэрэгцээ байгаа гэсэн үг бөгөөд үүнээс улбаалан боловсрол эзэмшсэнээр давуу тал үүсдэг, нийгэмд илүү байр суурь эзэлдэг явдал арилж байгаа нь боловсролын өөрчлөлтөд чухал ач холбогдолтой үзэгдэл юм. Ийм учраас одоо байгаа байдлаар нь хадгалан үлдэх сонирхолтой талууд, өөрчлөлт хийгдвэл нөлөөлөх эрх мэдлээ алдах эрсдэлтэй оролцогч талууд олон бий. Намгийн мэлхийнүүдийг намгаа орхиод яв гэх боломжгүй юм. Хамгийн жижиг өөрчлөлт шинэчлэл ч маш том хэмжээний нөөцийг өөр тийш нь шилжүүлж, сая сая хүний амьдралд нөлөөлнө. “Шинэчлэлийг мэдэгдүүлэхгүй” хийх боломжгүй тул бодлого зохицуулалт гаргаж өргөн хэмжээгээр дэмжлэг үзүүлэх нь зүйтэй. Үндсэндээ сурган хүмүүжүүлэгчид

өөрсдөө хэрэгжүүлж, хамгаалж зогсохгүй тохиолдолд боловсролын шинэчлэл хийх аргагүй юм.

Багшийн чанар, статусыг сайжруулах, хариуцлага хүлээх тогтолцоог бэхжүүлэх, сургуулийн орчныг болон дээд боловсролын санхүүжилт, хяналтыг сайжруулах зэргээр хэд хэдэн улс орны боловсролын яам анхдагч, ил тод шинэчлэлүүдийг хийлээ. Дээд боловсролын санхүүжилтийг төрөөс олгох эсвэл суралцагчийн сургалтын төлбөрөөр санхүүжүүлж байгаа тохиолдолд тогтвортой санхүүжилт шийднэ гэдэг маш хэцүү болохыг бодлого боловсруулагчид бүгд мэднэ. Суралцагчийн үнэлгээ, шалгалтыг нэмэгдүүлсэн шинэчлэл хийвэл багш нар эсэргүүцнэ, мэргэжлийн боловсролын салбарт шинэчлэл хийвэл үр дүнд нь бүрэн дүүрэн итгэхгүй байгаа эцэг, эхийн зүгээс эсэргүүцэлтэй тулгарна.

Гэсэн хэдий ч боловсролын салбарт инновац хийгдэх нь ойлгомжтой юм. Цаг хугацаа, орон зай, техник технологи болон хүний хүчин зүйлсийг эргэн харснаар боловсролын үр дүн сайжирч, үр өгөөж ихсэнэ. Цар тахлын үед инновацын эхлэл аль хэдийн тавигдсан билээ. Үндэсний хэмжээнд сургуулиудыг стандарт, удирдлагаар хангаж, сургуулиуд, орон нутгийн байгууллагад өөрсдийн тохиромжтой гэж үзэж буй арга хэлбэрээрээ дамжуулан хариу үйлдэл үзүүлэх эрх чөлөөг нь олгосон хэд хэдэн сайн туршлага байна. Ингэснээр цаашид боловсролын үр дүнг сайжруулах, үр өгөөж болон тэгш хүртээмжийг нэмэгдүүлэх, инновац хийгдэх үндэс суурь тавигдаж байна гэж үзэж болох юм.

Гэхдээ өөрчлөлт болгон инновац байж чаддаггүй ба энэ нь өөрчлөлтийн чиглэл болон зорилгоос шууд хамаарна. Инновац гэдэг нэрийн дор алдаа мадагтай олон өөрчлөлт хийгдэх

эрсдэлтэй хэдий ч инновацыг тууштай дэмжих нь чухал юм. Хэтэрхий их өөрчлөлт буцаад тогтолцоондоо хор хөнөөлтэй байдаг. Суралцахуйн шинжлэх ухаанд суурилаггүй, багш нарт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байвал амжилт олохгүй юм. Дээрээс доошоо чиглэсэн инновацыг багш нар эсэргүүцэх хандлага нэмэгдэж байгаа ба инновац, өөрчлөлт шинэчлэлийг маш нарийн бодож, төлөвлөж хэрэгжүүлэх нь зүйтэй. Суралцахуйд хийгдэж буй инновац нь өөрчлөлт хэрэгтэй учраас л өөрчилж буй бус, харин ирээдүйн замыг заах Алтангадас байх учиртай.

Технологи нь боловсролд төдийгүй бусад салбарт инновац хийх гол үндэс суурь болдог. Гэхдээ одоогийн байдлаар цахим технологийн боловсролд үзүүлсэн үр нөлөөг харахад хувирган өөрчлөх гэхээс илүүтэйгээр одоо байгаа практикыг хадгалахад чиглэсэн байдал ажиглагдаж байна. Үүнд хэд хэдэн учир шалтгаан байгаа нь программ хангамж, хичээлийн хэрэгслийг дизайнчлахдаа шинжлэх ухааны үндэс суурьтай заах арга зүйг ашиглаагүй, хэт энгийн хандсан, үндсэн орчин нөхцөл хангагдаагүй гэх мэт юм. Цахим технологийн шилжилт дөнгөж эхэлж байхад боловсролын тогтолцоо, суралцагчид хүндээр хүлээж авч байгааг цар тахлын нөхцөл байдал бидэнд харууллаа. Танхимын сургалт цуцлагдаж, зайны сургалт эхлэхэд багш нарт сургалтаа шууд үргэлжлүүлчихээр цахим платформ, сургалтын болон үнэлгээний хэрэгсэл байсангүй. Бүгдийг нь өөрсдийнхөө хүч чадлаар шинээр хийж оролдох шаардлагатай болсон бөгөөд цар тахлын нөхцөл байдал үүсээд бараг нэг жил өнгөрчихсөн байхад ч цахим технологийг боловсролдоо интеграцчилсан улс гарын таван хуруунд багтахгаар цөөхөн байна. Улс орнууд үүнээс сургамж авахын сацуу технологитой харьцах, хэрэглэх тал

дээр боловсролын тогтолцооны хүчин чадал ямар байгааг мэдэж авсан гэж болохоор байна.

Боловсролын тогтолцоо илүү уян хатан, суралцагч бүрийн хэрэгцээг харгалзсан тогтолцоо руу шилжиж байгаа бөгөөд цар тахлын нөхцөл байдлын улмаас шилжилт улам хурдсаж байна. Цахим суралцахуйн тусламжтайгаар сургууль суралцагчдын ялгаатай хэрэгцээ бүрд зориулж тохирсон шийдэл санал болгох боломжтой. Цар тахлын дараах үед суралцагчдад дэмжлэг, туслалцаа шаардлагатай бөгөөд энэ үед цахим технологи маш их ач холбогдолтой болно.

Боловсролын салбарт гарч байгаа инновацыг бид илүү ухаалаг өнцгөөс харж, дүгнэх хэрэгтэй юм. Бодлого боловсруулагчид инновац хийхдээ дээрээс доошоо чиглэлтэй хандсан оролдлогууд ихэнхдээ амжилт олдоггүй. Боловсролын тогтолцооны дотор болон гадна байх бүхий л оролцогчид нэг зорилгын төлөө, үндэслэлтэйгээр нэгдэж хамтран ажилласнаар амжилттай инновац хийж чадна. Боловсролын тэргүүн шугамд ажилладаг мэргэжилтнүүд онцгой үүрэг гүйцэтгэх ба инновацын үйл явцдаа тэднийг оролцуулах хэрэгтэй. Багшийн эрх мэдлийг ил далд байдлаар хязгаарласан шинжтэй инновац амжилт олохгүй юм. Хэвтээ тогтолцоонд буюу боловсролын тогтолцоонд адил түвшинд ажилладаг янз бүрийн мэргэжлийн хүмүүс хамтран ажиллаж, хийсэн ажлынхаа үр дүнд мэргэжлийн хариуцлага хүлээдэг үед инновацыг амжилттай хийж чадна. Олон улсын хамтын ажиллагаа мөн чухал үүрэг гүйцэтгэнэ.

Бодлого боловсруулах үндэслэлийг баримт нотолгоотой гаргах, инновацыг удирдан чиглүүлж, туршиж хэрэгжүүлэхэд шинжлэх ухааны судалгаа, өгөгдөл мэдээлэлд

үндэслэсэн, мэдлэгт суурилсан тогтолцоо маш чухал. Инновац, туршилт нь амжилттай болсон ч, болоогүй ч түүнээс туршлага, сургамж авдаг байх нь мөн чухал. Цар тахлын нөхцөл байдлын төгсгөл ирж, энгийн нөхцөлд шилжих үед хийгдэх ёстой чухал ажлуудын нэг нь боловсролын тогтолцоо хэрхэн хариу үйлдэл үзүүлсэнд үнэлгээ дүгнэлт хийж туршлага, сургамжаа тэмдэглэх явдал юм. Цар тахал бол жинхэнэ амьд туршилт байсан ба түүнээс авсан сургамжаасаа өчүүхэн төдий ч гэсэн суралцаж, илүү сайн ирээдүй бүтээхийн төлөө хэрэглэж чадвал амжилт болох билээ.

Боломжит саналууд

- Боловсролын инновац нь боловсролын үр өгөөж, үр ашиг, чанар, тэгш хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хамтын, зориудаар чиглүүлэх хөгжлийн үйл явц мөн гэдэг байр суурийг улс орнуудад ойлгуулах
- КОВИД-19 цар тахлын нөхцөл байдлаас авсан сургамжаа ашиглан боловсролын тогтолцоог бүхэлд нь эргэн харж, инновац хийх
- Боловсролын тогтолцоондоо туршилт хийж, алдаа онооноосоо суралцахад улс орнуудыг уриалах

